

“ГҮНЗГИЙ МЭД”

MONGOLIAN ECONOMY

2015 оны 04 сар, №07, 08 (086, 087)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ

ХЭН БАЙХАА ХААНААС ЭХЛЭХ ВЭ

АМЖИЛТЫН ТӨЛӨӨС


ЕРТӨНЦ

СИНГАПУРЫН БАЯЛАГ: ЛИ ГУАН ЯАО

ИТГЭЛЦЭЛ

ИРЭЭДҮЙГ ГЭРЭЛТҮҮЛЭХ

ЭХНИЙ АЛХАМ




Монгол Улсын үнэт зүйл юу болох, Хууль эрх зүйн тогтвортой орчин, Мега төсөл, Үйлдвэржилтийн бодлого, Япон улстай хийсэн чөлөөт худалдааны хэлэлцээр, Зээлжих зэрэглэл, Санхүүгийн зах зээл, Татварын бодлого зэрэг сэдвийг хөндөн бичлээ.



RIVER GARDEN

Evergreen

Модон морин жилийн
шилдэг барилга



PCD NOMIN
CONSTRUCTION
DEVELOPMENT
GROUP
ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ

2-р ээлж ЗАХИАЛГА АВЧ БАЙНА

120.3м², 127м², 170.3м², 216.1м²

Sound of Khatan Tuul river, singing birds, colorful flowers,
big green trees and sound of blue lake ...



Давуу тал:

- Эко ногоон орчин
- Спорт комплекс талбай
- 2 түвшинт нуур
- 1.5 км урт гүйлтийн болон дугуйн зам
- Хүүхдийн тоглоомын талбай
- Усан бассейн спорт цогцолбор
- Сургууль, цэцэрлэг
- Худалдаа, үйлчилгээ
- 24 цагийн харуул хамгаалалт



Тус хотхоны нэгэн чухал онцлог нь хүний амьдрах хамгийн таатай орчныг бүрдүүлэх, тэр дундаа байгалийн сайханд уул усаа толидон торгон ногоон зүлэг, төрөл бүрийн мод, бут, сөөгөн дунд сэтгэл тэнүүн, аз жаргалтай сайхан амьдрах нөхцлөөр хангахыг чухалчлан нийт хотхоны нутаг дэвсгэрийн дийлэнх хэсгийн буюу 70-аас багагүй хувьд ногоон байгууламжийг бий болгосон юм. Монголын №1 ногоон хотхон River Garden нь таны гэр бүлд аз жаргал, амар тайван байдлыг мэдрүүлэх болно.

RIVER GARDEN хотхон нь хотын төв цэгээс 3 км зайд үзэсгэлэнт байгаль дунд бэсрэг хиймэл нуур, төрөл бүрийн мод бут сөөг бүхий ногоон байгууламж, дугуйн зам, сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис, хөлбөмбөгийн талбай зэргийг багтаасан спорт комплекс талбай, фитнес, усан бассейн, аэробек, иог, бүжгийн танхим бүхий спорт танхим болон супермаркет, ресторан, үсчин гоо сайхан, массаж, SPA, цэцэг, бэлэг дурсгал, аяллын болон спорт бараа, бусад брэнд дэлгүүр гэх мэт төрөл бүрийн үйлчилгээг цогцлоосон RIVER TOWER үйлчилгээний төв болон RIVER STREET үйлчилгээний гудамжийг төлөвлөсөн иж бүрэн цогцолбор орон сууцны хороолол юм.



Эдгээр газруудтай
хамгийн ойрхон ...



СКАЙ РЕСОРТ



ХҮҮХДИЙН ПАРК



ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН



ОРЧОН СУРГУУЛЬ



ЗАЙСАН ТОЛГОЙ



AMERICAN SCHOOL OF ULAANBAATAR



SAKURA SCHOOL

Утас: **7577-7577**
www.rivergarden.mn



692,000

Монголчуудын дундаж цалин

210,000,000

Та тэтгэврийн даатгалаа 10% хүүтэйгээр
30 жил хадгалахад үүсэх хуримтлал

69

Монгол хүний дундаж наслалт

24,400,000

Таны буцаан авах тэтгэврийн
нийт хэмжээ

137

Хуримтлуулсан мөнгөө буцааж
авахын тулд таны амьдрах ёстой жил

**ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ХАДГАЛАМЖ
ТАНЫ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА**



ОРОН СУУЦНЫ САЛБАРТ

8±1
 ХУВИЙН
 ХҮҮТЭЙ
 ОРОН
 СУУЦНЫ
 ЗЭЭЛ



600 ТЭРБУМ
 ТӨГРӨГ



14000

ӨРХ
 ОРОН
 СУУЦТАЙ
 БОЛОВ



28 ОРОН СУУЦНЫ
 ХОРООЛМЫН САНХҮҮЖИЛТ



10000 ШИНЭ
 АЖЛЫН
 БАЙР

АВТО ЗАМЫН САЛБАРТ (2010-2014 ОНД)




УЛСЫН ХЭМЖЭЭНД НИЙТ
3804 KM
 АВТО ЗАМ ТАВИГДСАН

ҮҮНЭЭС ГОЛОМТ БАНКНЫ САНХҮҮЖИЛТЭЭР
1667 KM АВТО ЗАМ
 ТАВИГДАВ



УУЛ УУРХАЙН САЛБАРТ



40% ТӨМРИЙН ХҮДЭР,
 ХҮДРИЙН БАЯЖМАЛЫН
 ЭКСПОРТИЙН САНХҮҮЖИЛТ

20% ЖОНШ БОЛОН
 НҮҮРСНИЙ
 ЭКСПОРТИЙН
 САНХҮҮЖИЛТ

14% НИЙТ
 АЛТ
 ТУШААЛТЫН
 САНХҮҮЖИЛТ

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ

НИЙТ
17
 АЙМАГТ






140 | 190 ТЭРБУМ
 ТӨГРӨГИЙН
 САНХҮҮЖИЛТ
 ОЛГОВ



1600 ШИНЭ
 АЖЛЫН
 БАЙР

ГҮНЗГИЙ МЭД

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ

ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэнн

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

Сэтгүүлчид:

Б.Энхцэцэг

А.Бүрэнжаргал

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав / 9409 2904

Б.Наранцогт / 9409 2905

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

«Express tower» 11 давхар 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

www.mongolianeconomy.mninfo@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дэх салбарууд

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ЧУУЛГАН-2015

P12



- 10 Хэн байхаа хаанаас эхлэх вэ
- 12 Эрх зүйн тогтвортой орчныг бүтээх нь
- 15 Байгаа зөв онилбол хөгжлийн зам дөт
- 16 Алдах эрхгүй үйлдвэржилт
- 19 Япон, Монголын шинэ түншлэл ба боломж
- 22 Амжилтын төлөөс
- 26 Үзэсгэлэнгийн сүүлийн өдөр төгсгөл бус эхлэл байх учиртай
- 30 Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулах нь
- 32 Сэм Уолш: Бид Монголоос ямар нэг онцгой эрх хүсч, тусгай шаардлага тулгаагүй
- 34 Өрийн удирдлагын тухай хууль болон түүний эргэн тойронд
- 36 З.Нарантуяа: Системийн найдвартай, эрсдэлгүй байдлыг хангана
- 40 Ядуусын амьдралд олон салаа өргөс ургасаар, ужирсаар

P32



ЕРТӨНЦ

- 47 Сингапурын баялаг: Ли Гуан Яао

P47



- 50 Агаарын тээврийн өчигдөр ба өнөөдөр
- 51 Дэлхийг хэрсэн Чингисийн үр сад

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ЧУУЛГАН-2015

- 52 Хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг тольдохуй
- 54 Бодлогыг тандахад
- 55 Арбитртай найзалъя
- 58 Байгууллагын нэрийн хуудас бол хүн

ЗАВСАРЛАГА

- 60 Хятадыг 1 цагт
- 61 Улс орнуудын өрсөлдөөн
- 62 Чөтгөрийн тойрог

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013
оны Шилдэг сэтгүүл”
Монголын бизнесийн зөвлөлийн
“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл
мэдээллийн байгууллага - 2012”
МҮХАУТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”

РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ



СЭТГҮҮЛИЙН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Эрхэм уншигч, захиалагчид болон Эдийн засгийн чуулганы зочин, төлөөлөгчдөд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Mongolian Economy” сэтгүүл 2011 оны Монголын эдийн засгийн чуулганы үеэр анхны дугаараа гаргаж, уг чуулганы оролцогчдод хүргэж, та бүхний заримаас нь “Нийгэмд хэрэгтэй сайн сэтгүүл гаргасан байна. Баяр хүргэе” хэмээсэн талархлын үг сонсож байсан сайхан дурсамж энэ үеэр сэргэдэг юм. Мөн манайх тухайн цаг мөчөөс эхлээд Монголын эдийн засгийн чуулгантай хамтран ажиллаж, жил бүрийн чуулганы мэдээллийн ивээн тэтгэгчээр “өрсөлдөгчгүй” оролцож ирлээ. Нөгөө талаас хамтран ажилладаг Монголын эдийн засгийн форум ТББ-ын хамт олонд

талархаж явдгаа энэ дашрамд илэрхийлье. Зургаа дахь жилээ болж буй “Монгол Давос”-д зориулж гаргасан бидний энэ удаагийн сэтгүүл маань форумын үеэр яригдах эдийн засаг, санхүү, бизнес, хөгжлийн тухай олон асуудлыг тусгасан зузаан дугаар гарлаа.

“Итгэлцэл” уриан дор хоёр өдөр чуулах та бүхний сонирхсон сэдэв, хэлэх ярих асуудлын чинь санаа, агуулга, өнцгөөс таны гарт байгаа “Mongolian Economy” сэтгүүлийн хуудаснаа буусан гэдэгт итгэлтэй байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн чуулган тал бүрийн оролцоог хангаж, асуудлыг олуулаа хэлэлцдэг. Энэ үеэр эдийн засгийн хүндрэл, хөгжлийн гарц хайсан асуудлуудыг түлхүү ярих учраас Монгол Улсын үнэт зүйл юу болох, Хууль эрх зүйн тогтвортой орчин, Үйлдвэржилтийн бодлого, Япон улстай хийсэн чөлөөт худалдааны хэлэлцээр, Зээлжих зэрэглэл, Санхүүгийн зах зээл, Татварын бодлого зэрэг сэдвийг хөндөн бичлээ. Манай сэтгүүлчдээс гадна шаардлагатай зарим эдийн засгийн хүнд хэцүү, нарийн ойлголт ухагдахууны талаар бидэнтэй хамтран ажилладаг мэргэжлийн эдийн засагч, шинжээч, судлаач нарын өгүүлснээр хүргэж байна.

Мөн дэлхийн эдийн засагт асуудал дагуулж байгаа онгоцны ослоудын тухай, саяхан таалал төгссөн Сингапурын эцэг гэгдэх ноён Ли Гуан Яаогийн бүтээсэн гавьяа, түүх гээд ертөнцийн сонин сайхнаас ч сонирхуулахаа мартаагүй ээ. Түүнчлэн манай засвсарлага секцийн мэдээллүүд таны хурлын нойрмог байдлын сэргээш болох болов уу.

Та бүхний ажилд амжилт хүсье.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ



facebook.com/Mongolian.
Economy



twitter.com/
EconomyMongolia



youtube.com/user/
MongolianEconomy

МОНГОЛД**БАНК САНХҮҮ**

Банкны салбарын өрсөлдөх чадварыг тодорхойлжээ.

Нийт 25 орноос Монгол Улсын банкны салбарын өрсөлдөх чадвар арвандөрөвдүгээрт жагссан байна. Үүнээс үзэхэд Монголын банкны салбарын хөгжил зарим талаар улсын нийгэм, эдийн засгийн хөгжлөөс түрүүлсэн гэх дүгнэлтийг банкны холбооноос гаргажээ. 2013 оны эцсийн байдлаар санхүүгийн салбарын активын 95 хувийг арилжааны банкууд эзэлж байгаа бол ДНБ-ий санхүүжилтийн 50 орчим хувийг арилжааны банкууд бүрдүүлж байгаа нь 2000 онтой харьцуулахад даруй 10 дахин өссөн дүн юм.

АСЕМ

Манай улс 2006 онд АСЕМ-ын гишүүнээр элссэнээс хойш тус байгууллагын үйл ажиллагаа, санал санаачилгад идэвхтэй оролцож ирсэн. Ази, Европын Дээд түвшний XI уулзалт 2016 оны долдугаар сард Улаанбаатар хотод болно. 51 орны Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Гадаад хэргийн сайд нар, олон улсын байгууллагын удирдлага, хэвлэл мэдээллийнхэн зэрэг нийт 5000 гаруй зочид, төлөөлөгч оролцохоор тооцоолж буй. Тус уулзалтыг зохион байгуулах ажлыг удирдан зохион байгуулах, чиг үүргээр хангах Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ахлан ажиллана. Энэ хүрээнд таван дэд ажлын хэсэг гарч чиглэл чиглэлээр тус уулзалтад бэлтгэж байгаа талаар үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаанаар мэдээллээ.

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал болон ирээдүйн

төлөвийг хэрхэн тооцоолж байгааг Азийн хөгжлийн банк өнгөрсөн сарын 24-нд танилцууллаа. Өнгөрсөн онд эдийн засгийн өсөлт удааширч 7.8 хувийн өсөлттэй гарсан. Харин энэ онд өсөлт саарч гурван хувь орчим болж буурна гэсэн юм. 2014 оны эдийн засгийн өсөлтийн 4.8 хувийг уул уурхайн өсөлт, үлдсэн хувийг нь ХАА, үйлчилгээний салбарын өсөлт бүрдүүлж, бусад салбарт өсөлт ажиглагдаагүй байна. Энэ жилийн хувьд ипотекийн зээлийн эрэлт буурч буйтай холбоотойгоор барилгын салбарт өсөлт багасах хандлагатай байгаа аж. Мөн зээл хэлбэрээр зах зээлд нийлүүлсэн мөнгөний эргэн төлөлтөөс үүдэн мөнгөний нийлүүлэлт буурах агаад улмаар эдийн засгийн өсөлт удааширах төлөвтэй байна гэж үзжээ. Харин эдийн засгийн гурван хувийн өсөлтийг задалбал ХАА-н салбар нийт эдийн засагт 1.4 хувь орчим өсөлт үзүүлэх бөгөөд үлдсэн хувийг уул уурхай, барилгаас бусад аж үйлдвэрийн салбарын өсөлт бүрдүүлнэ гэж тооцоолжээ.

НҮҮРС

Монголын анхны нүүрс шингэрүүлэх үйлдвэрийг /МАК/ Германы “Siemens” компанитай хамтран байгуулахаар ажиллаж байна. Адуунчулууны уурхайг түшиглэн барих энэ үйлдвэрийн ТЭЗҮ зэрэг бэлтгэл ажил дуусч, 10 км урт салаа төмөр замын зураг төсөл болон усны судалгаа хийх ажил хийгдэж байгаа талаар төслийн баг мэдээллээ. МАК компанийн хувьд нийт 2.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай энэ төслийн бүтээн байгуулалтыг ирэх оноос эхэлж 2019-2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Үйлдвэр жилд 400 мянган тонн түлш, 17 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх боломжтой юм байна. Энэ нь Монгол Улсын

түлшний хэрэглээний 30-40 хувьтай тэнцэх үйлдвэрлэл аж.

ТОМИЛГОО

Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв “ҮЦТТХТ” ХХК-ийн нэгдүгээр сарын ТУЗ-ийн хурлын шийдвэрээр гүйцэтгэх захирал Т.Гандуламыг үүрэгт ажлаас нь чөлөөлөөд байсан юм. Харин ээлжит хурал гуравдугаар сарын 25-нд болж, энэ үеэр Ж.Алдаржавхланг тус компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилсон байна. Тэрбээр өмнө нь Орон сууц санхүүжилтийн корпорацийн захирлын албыг хашиж байжээ.

ДЭЛХИЙД**МОДИ МОНГОЛД АЙЛЧИЛНА**

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарэндра Модиг АНУ, Австрали, Европын улсууд болон Энэтхэгийн тэнгисийн улсуудаар хийх айлчлалын дараагаар Энэтхэгийн гол геополитикийн өрсөлдөгч улс болох Хятад болон стратегийн ач холбогдолтой Зүүн Азийн орнуудаар айлчлах төлөвлөгөөтэй байгаа аж. Тэрбээр тавдугаар сарын 14-19-ны хооронд Хятад, Монгол болон БНСУ-д айлчлах аж. Албан ёсны мэдээллээр энэхүү айлчлал Энэтхэгийн Зүүн Ази дахь бодлогын хүрээг дээшлүүлэх мөн “Энэтхэгт хийе” санаачилгын хүрээнд стратегийн ач холбогдолтой бүс нутагт улсынхаа гадаад бодлогыг сайжруулах зорилготой аж. Монгол болон Энэтхэг улс 2009 онд байгуулсан харилцан ойлголцолын санамж бичгийн хүрээнд Ураны нийлүүлэлтийн асуудлыг урагшуулах сонирхолтой байгаа аж. Монгол Улс

Энэтхэгээс кибер аюулгүй байдлын тусламж авах хүсэлтэй байгаа, мөн хилийн хамгаалалтын тусалцаа зэрэг хоёр улсын харилцааг холбох салбарууд байгаа юм.

УУЛ УУРХАЙН БАЙДАЛ ОДООХОНДОО ТОГТВОРТОЙ БАЙНА

Байгалийн нөөцийн салбарт хөрөнгө оруулагчид газрын тос, байгалийн хийн салбарыг бодвол уул уурхайн салбараас илүү тогтвортой мөнгөний урсгалыг олох магадлал илүү өндөр байдаг. Түүхий эдийн үнэ унаснаар уул уурхай болон эрчим хүчний салбарынхан хүнд цаг үеийг туулж буй. Хятадын эдийн засаг буурах хандлагатай байгаа нь метал, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүнд нөлөөлж байгаа, ингэснээр зардал болон мөнгөний урсгал хязгаарлагдаж байгаа аж. “BHP Billiton”, “Рио Тинто” болон “Anglo American” зэрэг томоохон компаниудын удирдлага өөрчлөгдсөний дараагаар шилжих хөрөнгийн зарлагыг бууруулах мөн 2012 онд эхлүүлж байсан томоохон төслүүдийг хойш тавьж эхлэх болсон байна. “Рио Тинто”-гийн хөрөнгийн зардал 2012 оноос хойш хоёр дахин буурсан байна. Уул уурхай болон газрын тосны компаниудын хувьцаа энэ жил зах зээл дээр илт унаж эхэлсэн бөгөөд зардлаа илүү танасан компаниуд оносон нь харагдаж байна. Хэдийгээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ бага хэвээр байх төлөвтэй байгаа ч томоохон компаниудын нөхцөл байдалд одоохондоо нөлөөлөхүйц хэмжээнд хүрээгүй байгаа аж.


ХЯТАД БОЛОН МОНГОЛ ХУДАЛДААНЫ БҮС БАЙГУУЛНА



Хятад болон Монголын тал

худалдааны бүс байгуулах талаарх анхны уулзалтаар хоёр улсын хил дээр тал талдаа есөн ам километр талбайг хамтарсан эдийн засгийн бүс болгохоор тохиролцов. Энэхүү бүсийг Хятадын Эрээн Хот болон Монголын Замын Үүдэд байгуулах талаар хоёр тал ӨМӨЗО-ны Эрээн хотод гуравдугаар сарын сүүлээр уулзаж хэлэлцсэн аж. Хятадын худалдаа, аж үйлдвэрийн яамны мэдээлснээр хоёр тал дөрөвдүгээр сард дахин уулзах аж. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж болон Си Зиньпин нар газар хуваарилалтын талаар хэлэлцээрийг наймдугаар сард хийх бөгөөд Ерөнхийлөгч Си Зиньпин энэхүү бүсийн ач холбогдолыг онцлон чөлөөт худалдааны бүсийн гэрээнд аль болох түргэн гарын үсэг зурах хэрэгтэйг хэлсэн юм. Хятад болон Монгол Улс 4.710 км газар нутгаар хиллэдэг аж. Эрээн хот нь Хятад-Монгол-Оросын төмөр замын дагуу байрладаг бөгөөд хоёр орны худалдааны 70 хувийг эзэлдэг хамгийн чухал гаалийн хяналтын цэг юм.

“TURQUOISE HILL”-ИЙН ШИНЭ МЭДЭЭ



Turquoise Hill-ийн 2014 онд гаргасан дүгнэлтээс үзэхэд Оюутолгой компани 2014 онд сайн аюулгүй ажиллагааны гүйцэтгэлтэй байсан ба нэг ч хүний амь эрсдээгүй ба осол гэмтэл харьцангуй бага гарсан аж. Оюутолгой компани 2014 онд ойролцоогоор 733.700 тонн баяжмалыг борлуулж 1.6 тэрбум ам.долларын цэвэр ашиг олсон байна. “Turquoise Hill” 2014 оны эхний ашигтай ажиллагаагаар 658,3 сая ам.долларын мөнгөн гүйлгээг хийсэн аж. Энэ онд 175.000-195.000 тонн зэс болон 600.000-700.000 унци алтны баяжмал олборлох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ тоо нь 2014 онд хийсэн олборлолттой ойролцоо аж.



БНХАУ-ЫН БОАО-ГИЙН ФОРУМ

Ерөнхийлөгч Си Зиньпин Азийн аюулгүй байдал шинэ эдийн засгийн дэг журамтай холбоотой БНХАУ-ын хэтийн төлөвийг танилцуулахдаа, Хятад улсын хөгжлийн үр өгөөжийг түгээж хамтын ажиллагааг бүс нутаг дахь улсуудтай өргөжүүлэх хүсэлтэй байгаа талаар гуравдугаар сарын сүүлээр болсон Боао-гийн форумийн үеэр мэдэгджээ. Хятад улс Азид болон дэлхийн улсуудад илүү ач холбогдолтой хамтарсан бүс нутгийн дэг журмыг тогтооход хамтрахад бэлэн байгаа гэж Ерөнхийлөгч Си тус форумын үеэр тавьсан илтгэлдээ дурьдлаа. “Шинэ Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банк болон Хятадын бусад санаачлагууд нь төмөр зам, усан боомт болон бусад төслүүдэд олон зуун тэрбум долларын хөрөнгө оруулалт хийх хөшүүрэг болох мөн бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжих зорилготой” гэж тэрбээр онцолжээ. Эдгээр зорилтуудын хамгийн чухал төлөвлөгөө нь АДБХОБ-ны “Нэг бүс, нэг зам” бөгөөд энэхүү төлөвлөгөө нь Ази болон Хятадыг Ойрхи Дорнод, Африк ба Европтой холбосон түүхэн далайн эргийн зам дагуу дэд бүтцийг бүтээн байгуулахад оршиж байгаа аж. Энэхүү төлөвлөгөөг маш олон улс болон бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг компаниуд сайшаан хүлээн авсан бөгөөд Азийн Хөгжлийн Банк энэхүү дэд бүтцийн бүтээн байгуулалтад дор хаяж их наяд ам.доллар шаардлагатай гэсэн тооцоог гаргажээ. Хятад улс ирэх таван жилд 10 их наяд ам.долларын бараа бүтээгдэхүүний импорт хийх ба 500 тэрбум ам.долларын гадаад хөрөнгө оруулалтыг хийх болно гэж Ерөнхийлөгч цохон тэмдэглэжээ. Монгол Улсын хувьд АДБХОБ-ны анхны гишүүдийн нэг юм. Боао-гийн форумыг Швейцарь улсад зохион байгуулдаг Дэлхийн эдийн засгийн форумын Ази хувилбар гэж үзэж байгаа бөгөөд бизнес болон эдийн засгийн асуудлуудын талаар давамгайлж хэлэлцсэн аж. ■

ҮНЭТ ЗҮЙЛ



Монголын маань үнэт зүйл, үндэсний бахархал хаана оршино вэ

Хэн байхаа хаанаас ЭХЛЭХ ВЭ

Б.Үүрийнтуяа

Сайн хүний нэрийг мянга худалдана гэдэг үгийн утгыг Монголоос л харж мэднэ бас ойлгоно. Хэдэн зуун жилийн тэртээ Монгол хэмээх Их Улсыг байгуулж дэлхий нийтийг сөхрүүлж явсан Их хаан, эзэн Чингисийнхээ нэрийг монголчууд бид түм буман удаа урдаа барьж хоолоо олж идсэн дээ. Архины шилнээс эхлээд улс орнуудын өрийн жагсаалтад хүртэл “сэлгүүцэх” тэр хүмүүний нэрийн өмнөөс улсаа барьцаалж өр зээл авчихаад өнөөх хэдэн “ногоон”-оос үлдсэн юм юу гэвэл энгийн иргэд тоймтой хэлж мэдэхгүй л байх. Түүний үлдээсэн нэр хүндийг үр хойч бид нь хэр өндөрт өргөн авч явж байгаа талаар дор бүрнээ бодоод нэг үзье.

Монгол нутгаа нэгэн гэр бүл хэмээн төсөөлвөл гэр дотроо бид монголчууд. Төв Азийн зүрхэнд орших агуу түүхт хүчирхэг үндэстэн. Маргаангүй. Гэтэл гэрээсээ гараад бид хэн болж хувирч буй

гэвэл худалч, луйварчин, эргэж буцсан олиггүй зантангууд болж орхиж. Итгэл гэдэг эрхэм зүйлийг монголчуудад хүлээлгэх гаднынхан ховордсоор. Гаднаасаа байг гэхэд “Монгол” гэр дотроосоо ч дээрхийг горьдож үл чадах. Учир юунд байгааг онцлон хайвал бусдын хэрэгт хошуу бүү дүр, лаагаа иднэ үү луувангаа иднэ үү маньд ямар хамаа байх вэ гэсээр нэгнээ гэж итгэх сэтгэлээ булшилж хаяжээ. Ганц мод гал болохгүй, ганц хүн айл болохгүй гэж ярьдаг атлаа гэрийнхээ галыг асаах хүсэлгүй болтлоо нэр хүнд, үнэт зүйл, үндэсний бахархлаа ардаа үлдээчихэж.

Дэлхий хавтгайраад дэндүү удаж байна. Гэвч бид өнгөрсөн, баларснаараа ирээдүйг төсөөлж бусад нь биднээс гуйсаар, сөгдсөөр байхмэт сэтгэсээр. Энэ нь монголчууд хавтгайрсан бөмбөрцгийн хөгжлөөс хэт хоцроод эхэлснийг харуулж буй. Тодруулан хэлбэл, бид хэн байхыг хүсэж, зорьж байна гэхээр товч бас тодорхой хариулт хайгаад олохгүй

юм. Улс нийтээрээ хаана хүрэхээр тэмүүлж байгааг асуух гэхээр хэлээд өгөх хэн нэгэн алга. Дор бүрнээ хүсэж, мөрөөдөж, зорьж байгаа ч нэгдээд урагшлах болохоор хаачихаа, хэнийг “дуурайхаа” мэдэхгүй будилж явна. Ядаж монгол монголоороо байх учраа ч олохгүй байгаагаас үзвэл бид зүглэх чигээ мэдэхгүй учир явах замаа ч сонгож чадахгүй байна. Энэ талаар UFC группын ерөнхий захирал О.Амартүвшин “Бид шуудайнд хийсэн үхрийн эвэр шиг байна. Нэг зүгт харж чадахгүй байна. Хэн нь урдаа байх юм, хэн нь ардаа байж хэр хугацааны дараа байраа сэлгэх үү гэдгээ цэгцэлж тодорхойлоогүй цагт нүүдэл хийж чадахгүй. Өгсөх уулаа зөв сонгоод, тэр цэгтээ хүрэхийн тулд алсын хараатай зохион байгуулалт хийх хэрэгтэй. Ингээгүй тохиодолд замаасаа буцах хэрэг гарна” гэсэн юм.

Тэгэхээр монголчууд гэртэй хэн байх, гадаа гараад хэн болох тухайгаа нухацтай ярихгүй бол өдгөө

бидэнд тохогож буй муу нэрийн жагсаалт уртаас урт цуварсаар байх нь.

ОЙЛГОЛТЫН АЛДАА

Үндэсний бахархал гэхээр морин хуур, их аварга Дагвадорж, Олимпийн алтан медаль хэмээн хариулах хүмүүстэй таарав. Ямар нэг зүйл эсвэл хэн нэгнээр бахархах нь буруу биш ч бидний өмнөө зүүж нэрийн хуудас болгон олон улсад тунхаглах үнэт зүйл мөн эсэх нь эргэлзээтэй.

Үндэсний бахархал гэвэл улс нийтээрээ баримтлах үнэт зүйлтэй байх хэрэгтэй. Гэвч үнэт зүйл гэхээр үндэсний дээл, халтар манан хөөрөг гэж төөрөлддөг тухай философич, судлаач С.Молор-Эрдэнэ ярилаа. Тэрбээр “Энэ бол үнэт зүйл биш. Музейн үзмэр. Үгийн утгаа ялгаж ойлгохгүй байна. Учир нь иргэд боловсролгүй байгаа юм. Монголчууд хүн болох хэрэгтэй” гэсэн юм. Түүний хэлснээр монгол хүний үнэт зүйл хөдөлмөр байх учиртай гэнэ. Тэрбээр “Өнөөдрийг хүртэл монголчууд бусдын бүтээснээр амьдарч ирсэн. Газарт байгаа баялаг дээрээ л эргэлдээд, түүнийхээ нэг хэсгээс гаргаж ирж зарж байна. Түүнээс биш байгалийн баялаг бодит баялаг болгоод бүтээгээд байгаа юм биш. Анхдагч хэрэгцээгээ ч өөрсдөө хангаж чадахгүй ард түмэн болчихож. Монгол хүн болж төрснийхөө гавьяаг гаргахгүй байна. Хүн болгон ямар нэг юмны үзүүрээс атгачихсан. Гэхдээ цааш үргэлжлүүлээгүй. Иймд хөдөлмөр гэдэг үнэт зүйлийг боловсролоор бий болгох хэрэгтэй” хэмээн тайлбарлалаа. Өөрөөр хэлбэл, боловсролоор дамжуулан хөдөлмөр гэх үнэт зүйлтэй болсноор өнөөдрийн тулгамдаад буй буруу бүхнээс ангижирч эдийн засаг хэмээх гарцыг бий болгох ажээ. Гэтэл боловсролын салбарыг зарлага гэж хардаг тухай UFC группын ерөнхий захирал О.Амартүвшин хэлсэн. Тэрбээр нэмж хэлэхдээ “Хөдөлмөрлөж байгаагаа дэмжихгүй юм аа гэхэд дараад баймааргүй байна. Болохгүй байна гэж шүүмжлэх биш болохгүйн эсрэг юу хийж чадахаа бодох хэрэгтэй. Маш хатуу журам, дүрмээр явах хэрэгтэй. Сахилга батгүй нийгэм урагшлахгүй. Иймд үүнийг бий болгох хэрэгтэй. Ардчилал гэж юу вэ, эрх чөлөө гэж

юу вэ гэдгээ зөв ойлгох хэрэгтэй. Америк гоё, Сингапур гоё гэж ярьдаг. Тэгвэл тэр гоё гээд байгаа зүйлээ Монголдоо яаж бий болгох вэ гэдгээ ойлгомоор байна. Сайны хажуугаар орж ирэх саар зүйлд хэрхэн зөв хариу үйлдэл хийх үү гэдгээ сайн мэддэг баймаар байна. Засахын төлөө өөрсдөө ажил. Хуулийг чандлан сахих хэрэгтэй” гэдгийг сануулав. МНН группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан “Манай нийгэмд зорилго байна уу гэхээр Монголын 3.0 сая иргэнийг нэгтгэж буй зорилго алга. Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан зүйл байдаг. Тэрийг зорилго мөн гэж үзвэл түүнийг дагаж мөрдөх хэрэгтэй. Гэтэл зорилгоо хэмжих хэмжүүр байхгүйгээс үүдэж тэр нь мөрөөдөл болчихоод байна” хэмээв. Философич С.Молор-Эрдэнэ “Зорилго тавьж болно. Гэхдээ тэр нь бодит байх хэрэгтэй” гэв. Мөн тэрбээр “Үндсэн хууль хууль биш. Энэ бол тунхаг бичиг. Монголчуудын зорилгоо буулгасан баримт бичиг байх ёстой. Түүнээс улбаалаад зорилгодоо хүрэх, өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиа биелүүлэх хуулиудыг бий болгох учиртай” гэлээ.

ТЭД МӨРӨӨДӨЖ БАЙХАД БИД ЯАГААД БОЛОХГҮЙ ГЭЖ

Dream. Хамгийн түгээмэл утгаар нь эх хэлнээ хөрвүүлэн буулгавал зүүд гээчийг хэлнэ. Тэгвэл day dreaming буюу манайхны ярьж заншсанаар сэрүүн зүүдлэх эсвэл мөрөөдөх цаг, зав, боломж, чадавч бидэнд байхгүй хэмээн С.Молор-Эрдэнэ шүүмжлэв. Тэрбээр “Мөрөөдөл аюултай. Хүн мөрөөдөж болно. Хязгааргүй. Улсаараа мөрөөднө гэвэл их халтай” гэлээ.

Тэгвэл яагаад америкчууд мөрөөдөөд, түүнийгээ алсын хараа болгоод, тэр ч бүү хэл сэрүүн зүүдээ бодит амьдрал болгож чадаад байна вэ. Урд хөршүүд хүртэл Хятад мөрөөдөл гэж дэлхийд тунхаглаад байгааг Молор-Эрдэнээс асуухад “Эдийн засаг нь хөдөлмөрч хүмүүс дээр тогтож байхад тэд мөрөөдөг л дээ. Мэдлэг, боловсрол, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж чадаж байгаа хүмүүс юу бодит гэдгийг мэдэж байгаа учраас юу мөрөөдөхөө мэдэж байгаа” гэж хариулав. Түүний хэлснээр боловсролгүй хүн яаж эрүүл амьдрахаа мэддэггүй. Тийм

ч учраас монголчууд эрүүлээр “мөрөөдөхөө” мэдэхгүй байгаа аж. “Том улсууд мөрөөддөг юм байна гээд дуурайгаад байна. Хуулж ханалаа. 2008 онд улс төрчид баахан Кувейт гэж ярьсан. Тэгээд л Сингапур, Америк гээд хуулирдаг” хэмээн тэрбээр хатуухан хэлээд авсан. Тэгвэл О.Амартүвшин хэлэхдээ “Хүмүүс зорилго, мөрөөдлөө хольж хутгаад ойлгохгүй байгаа учраас хүчин зүйлсээ зөв тодорхойлж чадахгүй байна. Зорилгоо мөрөөдөл гэж хараад мөрөөдлөө зорилго гэж эндүүрээд байгаа юм. Мөрөөдөл хүн бүрт байх ёстой. Хувь хүнийг нэгтгэж буй гэр бүлд байх ёстой. Албан байгууллагад байх ёстой. Ингээд нэгдэж явсаар улсын хэмжээнд, үндэстний хэмжээнд байх ёстой асуудал. Тэрхүү мөрөөдөл агуу том байж, тэрний дараагийн зорилго тодорхойлогдоно. Ингэхдээ зөв тодорхойлох хэрэгтэй. Жишээлбэл, би 35 настай. Тэгчихээд 100 жилийн дараа би гээд яриад байж болохгүй. Бодит байх хэрэгтэй. Дээр нь мэдлэг, боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн боломж гээд мөрөөдлийг бодит болгож татаж ирдэг хүчин зүйлүүд байна. Иймд 10,20,30 жилийн дараа бид хаана байх ёстойгоо алсын хараагаар тодорхойлох хэрэгтэй” хэмээн онцолсон.

Хөгжсөн орнуудын мөрөөдлийн “жишгээс” харахад тэд үүнийгээ томъёолсон байдаг. Эрх чөлөө, нээлттэй боломж, эрх тэгш байдлын эх орон Америк гэдэг ухагдахуун Америк мөрөөдлийн тулгуур санаа, зорилго. Хятад мөрөөдлийн идеологи нь дундаж давхаргаа хүчирхэгжүүлэх, ингэснээр эв нэгдлийг бий болгож, бүх талаараа хүчирхэг Хятад орныг дэлхийд зарлах аж. Нэг тэрбум гаруй хүнийг хүчирхэг Хятад бий болно гэсэн мөрөөдөлд нэгтгэн, түүнд хүрэх маш тодорхой зорилтуудыг биелүүлэх “даалгаварыг” урд хөршийн төр засаг иргэддээ өгчээ. Түүнчлэн гэрийн даалгавраа хийхэд улс нь хамаг чадлаараа туслана гэж амалж буй. Амлаад зогсохгүй биелүүлээд эхэлжээ. Тэгвэл бидэнд нэг зүгт харах чигийг зааж өгч байгаа тэгээд харахаас цааш юу хийх тухай хэн зөвлөж байна вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат “Монгол Улс Азийн бар болно” гэсэн маш тодорхой зорилго

дэвшүүлж байжээ. Түүн рүү тэмүүлнэ гэж ч хэлж байсан. Гэтэл өнөөдөр яг ийм төрлийн оноогоод хэлсэн зүйл байхгүй байгааг дээр дурьдсан нийгмийн төлөөллүүд хэлсэн. Тухайлбал, О.Амартүвшин “Бодлогын ямар нэг бичиг баримт гардаг. Өнөөдрийг хүртэл гаргасан зорилт гэж болохуйц зүйлс амьдралгүй байгаа нь бизнесийнхэн, иргэд эсвэл нийгмийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг хамарч чадаагүй учраас газар авахгүй хэсэгхэн хугацааны дараа алга болчихоод байгаа юм. Гарч буй зорилтууд сонгуулийн циклээр тодорхойлогдож байна” гэлээ. Өөрсдийгөө хэн болох, хаана явж буйг дэлхийн бусад оронтой жиших шаардлага тулгараад байна. Түүнчлэн хэн байх хүсэлтэй байгаа мөн түүнийгээ хэрхэн гүйцэлдүүлэх төлөвлөгөөтэй байгаагаа ярилцаж нэгдсэн зөвшилцөлд хүрснээр зорилгоо биелүүлэх алсыг харсан хэмжүүрүүдээ зөв гаргаж ирэх цаг тохиогоод буй. Энэ хүрээнд ухаанаа уралдуулах ёстой байтал бүх түвшинд итгэлцэл байхгүй болсныг Амартүвшин, Молор-Эрдэнэ нар ярьсан. Энэ талаар О.Амартүвшин захирал дэлгэрүүлэхдээ “Гурван сая иргэн гурван сая чиг рүү харчихаад байна. Тэгэхээр монголчуудыг мөрөөдлөөр нь залах ёстой юм уу бахархлаар нь удирдах ёстой юм уу гэдгийг мэдэх хэрэгтэй. Мөрөөдөл байлаа гэхэд зорилгоор зоригжуулж тэмүүллээр хөглөх хэрэгтэй байна” гэсэн юм.



БАГАНА НЬ БАТ, ТООНО НЬ СУУРЬТАЙ БАЙХАД

“Стратеггүй тактик ялагдлын өмнөх бужигнаан” гэдэг үг манайхны хувьд бодит байдал. Монголын эдийн засгийн форумын ажлын хэсгийн гишүүн Ц.Эрдэнэбатын хэлж буйгаар урт хугацааны алсын харааг богино хугацааны зорилтод даатгаж болохгүй аж. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг. Хааш тэмүүлж алхах тухайгаа хэлэлцэж байгаа нь сайн хэрэг. Гэвч эцсийн дүнд бариад авах

үр дүн гарахгүй байгаад хамаг учир нуугдаж байна. Хэлэлцэнэ гэхээр маргалдаж, талцах биш, харилцан итгэлцэж, ойлголцох гэж нэгдэж оролцох хэрэгтэй байгаа аж.

Монголчууд бид тус бүртээ гэрээ ачаад нүүгээд явчихдаг заншлаасаа багахан хагацаж нэг нь нийтийнхээ төлөө нийт нь нэгнийхээ төлөө байж “Монгол” хэмээх гэрийнхээ багана, тооноо зүй ёсоор нь босгох хэрэгтэй бас шаардлагатай болжээ. Багана нь бат, тооно нь суурьтай байхад алсдаа хэрхэхээ цэгцлээд явахад амаргүй зүйл бага. ■

ХУУЛЬ

Эрх зүйн тогтвортой орчныг бүтээх нь

Ц.Элбэгсайхан

Засгийн газрын “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” хөтөлбөрт “Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх” гэсэн бүлэг бий. Энэ бүлгийн нэгдүгээрт “Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, бизнесийн ээлтэй орчныг бүрдүүлэх” ажлыг Засгийн газар бүх түвшиндээ хэрэгжүүлнэ гэжээ.

Нэгэн бизнесмэн эрхэм гадаадад худалдан авсан бараагаа транзит тээвэрт ачуулчихаад ирэхийг нь хүлээжээ. Гэтэл ачаа бараа нь замд явах зуурт Монголд хууль өөрчлөгдөж хилээр нэвтрэх боломжгүй болов. Ингээд бараа нь Монгол Улсын гааль дээр хураагдах нь тэр. Асуудал үүгээр дууссангүй. Хуульд орсон өөрчлөлтийн үр дүнд бизнесмэн маань хууль бус бараа хил нэвтрүүлэхийг оролдсон хэрэгтэн болж, шүүхэд дуудагдахад хүрчээ.

Энэ бол зүгээр л өнөөгийн хууль эрх зүйн нөхцөл байдалд үүсч болох захын жишээ. Гэхдээ энэ жишээ амьдрал дээр “батлагдсан”, үүнтэй төстэй олон үйл явдал тохиолдсон, тохиолдож байгаа гэдгийг бизнесийн хүрээнийхэн ярьж байна. Ерөөсөө хууль эрх зүйн тогтворгүй байдал хөрөнгө оруулагчдыг үргээсэн гэдгийг дээрээ ч, доороо ч ярьж, шүүмжилж буй. Хэчнээн хичээн, зөв зүйтэй, алдаа мадаггүй (алдаагаа зассан), хийгүй хууль баталлаа ч

хэрхэн хэрэгжүүлэх, хэр амь бөхтэй байхыг хэн ч мэдэхгүй. Эх хуулийг нь хөнддөггүй юм аа гэхэд, дутуугүй чухал үүрэгтэй журмыг хэдэн сар жилээр хүлээлгэж гаргадаг, арай гэж гаргасныгаа удалгүй шинэчилдэг байдал үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг зовоодог.

Эхэнд дурдсан жишээнд ямар гарц шийдэл байж болох вэ? Үүнд хамгийн оновчтой шийдвэр бол хууль, журам батлагдсан даруйдаа хүчин төгөлдөр хэрэгждэг байдлыг халах. Энэ нь бизнесмэнүүдэд бэлтгэлээ хангах, зөрчлөө арилгах хугацааг нь өгөх хэрэгтэй гэсэн санаа юм. Үүнээс гадна хууль батлагдахаас өмнө бизнесмэн “бараагаа ачуулчихсан” байвал нэг удаад “өршөөдөг” байдлаар ч юм уу боломж олгодог байхыг бодолцох хэрэгтэй гэдгийг хуульч Б.Амарсанаа хэллээ.

Эрх зүйн тогтворгүй байдлыг бий болгож байгаа нэг үндсэн шалтгаан нь өмнө дурдсанчлан журам батлах тухай. Хамгийн ойрын жишээ нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагаж мөрдөх журам. 2013 оны

арваннэгдүгээр сараас хууль хэрэгжиж эхэлсэн ч бүтэн найман сарын дараа журам нь батлагдсан байдаг. Журам батлагдаад мөн найман сар гаруйн хугацаа өнгөрсөн ч нөхцөл байдал дээрдсэн зүйлгүй. Үүний хариулт нь хөндөж буй эрх зүйн тогтворгүй орчинтой холбоотой гэж Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал асан, “B2B Mongolia” (Таны бизнесийн гүүр) компанийн захирал И.Сэр-Од тайлбарлаж байна. Түүний хэлж буйгаар гаднын томоохон хөрөнгө оруулагчид Засгийн газартай гэрээ байгуулахдаа Монгол Улстай гэрээ байгууллаа гэж ойлгож ханддаг. Гэтэл дараагийн Засгийн газар байгуулагдахад өмнөхөө үгүйсгэдэг нь манай улсыг амласнаасаа буцдаг, “найдваргүй түнш” гэдэг муу нэр олоход хүргэжээ. Сэр-Од “Хэдэн жилийн өмнө дэлхийн томоохон хөрөнгө оруулагчид Улаанбаатарт оффисоо нээж байсан нь магад 1911 оноос хойш хичээж олсон нэр хүндийн илэрхийлэл байсан. Харин тэр нэр хүндээ эргэж сэргээхэд тодорхой хугацаа

шаардлагатай” гэсэн юм.

Үүнээс гадна замбараагүй олон журам тогтвортой бус байдлыг бий болгодог байна. Тухайлбал, эх хууль буюу тухайн асуудлыг шийдвэрлэдэг үндсэн хууль байгаа ч үүний зэрэгцээ давхар журам, тушаал гаргах эрх нь салбарын сайдад нээлттэй байдаг. Хэдийгээр сайдын тушаал хуулийн хүрээнд гэдэг ч ойлголтын зөрүүтэй байдлаас үүдэн бизнес эрхлэгчид буруудах тохиолдол гарах нь энүүхэнд.

Тогтворгүй хуулийн тод жишээ болсон Ашигт малтмалын тухай хуулийг саная. Хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 оны долдугаар сарын 8-нд баталсан. Өнөөдрийг хүртэлх хугацаанд уг хуульд нийт 14 удаа өөрчлөлт, засвар оржээ.

Тухайлбал;

2008 оны арванхоёрдугаар сар, 2009 оны нэг, долдугаар сар, 2010 оны долоо, арваннэгдүгээр сар, 2011 оны хоёр, арванхоёрдугаар сар, 2012 оны тавдугаар сар, 2013 оны аравдугаар сар, 2014 оны хоёр, тав, долдугаар сар,



Шог зургийг А.Амарсайхан

Энэ оны нэг, хоёрдугаар сард тус тус засвар оруулсан. Хуульд өөрчлөлт оруулсан, нэмсэн, хассан нийт 152 заалт байгаагаас хоёроос олон удаа засвар хийгдсэн 35 заалт (хүчингүй болсон заалтууд орсон) байна.

Жишээ нь, Хууль дахь “үйлчилгээний хөлс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хураан авах,” гэсэн заалт нь энэ оны найруулга бөгөөд өмнө нь 2009, 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ.

Үүнээс гадна 2010 оны зургадугаар сараас 2011 оны зургадугаар сар хүртэл ганц жилийн дотор “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай” гэсэн хоёр зүйлтэй хууль гурван ч удаа батлагдсан юм. Энэ нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулах явц удааширнаас үүдэлтэйгээр хуулийн хэрэгжих хугацааг өөрчлөн ахин дахин батлахад хүргэж байв. Ер нь энэ хууль гарсанаар хайгуулын ажилд орж ирж байсан хөрөнгө оруулалт буурсныг Уул уурхайн үндэсний ассоциацийн Ерөнхийлөгч Н.Алгаа үргэлж хөнддөг. Хуулийн сүүлчийн сунгалт нь хугацаагүй (Ашигт малтмалын хууль шинэчлэгдэх хүртэл) сунгаснаас гадна шилжүүлэхийг нь бас хориглосон юм. Тиймээс тусгай зөвшөөрөл шилжүүлэх бус шууд компани худалдах үзэгдэл бий болсон байна. Ингээд 2014 оны долдугаар сарын 1-нд эх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав. Үүнтэй холбоотойгоор мөн “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журам” гэгч батлагдсан.

Хамгийн сүүлд 2015 оны хоёрдугаар сарын 6-нд “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл гэгчийг өргөн мэдүүлж 12 хоногийн дараа УИХ-ын чуулганаар анхны хэлэлцүүлгээр нь баталж орхисон. Гол өөрчлөлт нь компани төрийн эзэмшлийн хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх замаар шилжүүлэн авч болох заалтууд юм. Түүнчлэн уул уурхайн харилцааг Ашигт

малтмалын тухай хуулиас гадна өөр хэд хэдэн хууль зохицуулж байна. Тухайлбал 2009 онд батлагдсан “Урт нэрт хууль”, “Цөмийн энергийн тухай хууль”, 2014 оны “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”, “Газрын тосны тухай хууль”, 2012 оны “Ойн тухай хууль”, “Усны тухай хууль” болон 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” хамаарна.

Ийм л хаврын тэнгэр шиг хуйсганасан хууль, эрх зүйн орчинд бизнес эрхлэгчид баялаг бүтээж байна. Бүгдээрээ хэлэлцэж баталсан хуулиа хойтон жил нь ахиад л бүгд хэлэлцэж өөрчлөнө. Тэгэхдээ хувийн

“Тогтворгүй хуулийн тод жишээ болсон Ашигт малтмалын тухай хуулийг саная. Хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 оны долдугаар сарын 8-нд баталсан. Өнөөдрийг хүртэлх хугацаанд уг хуульд нийт 14 удаа өөрчлөлт, засвар оржээ.”

хэвшлийнхний санал бодлыг сонсч байсан удаагүй гэнэ. Магад хууль тогтоох аргачлал нь өөрөө алдаатай байж болох. Монголын хуулиуд гадаадын бэлэн хуулийн орчуулга болохоор хөрсөн дээрээ буудаггүй гэсэн шүүмжлэл сонсогдох нь бий. Тухайлбал Үндсэн хууль нь хүртэл Герман, Францаас авсан хуулбар гэгддэг.

Эрх зүйн тогтворгүй байдал нь хууль тогтоомжийн тодорхойгүй байдлаас болж шүүх үйл ажиллагаан дээр ч ажиглагддаг тухай өмгөөлөгч Б.Баяр ярьж байна. Хуулинд шүүгч дотоод итгэл үнэмшлээрэй шийдвэр гаргана гэсэн заалт бий гэнэ. Үүний дагуу шүүгч маргаантай хэрэгт дотоод итгэл үнэмшлээрэй шийдвэр гаргадаг ч яагаад гэдгийг шүүхийн бичгийн шийдвэрт тусгадаггүй. Тусгах тухай хуулийн заалт байдаггүй учраас тэр. Үүнээс үүдэн ижил төстэй хэргүүдэд өөр, өөр ял шийтгэл оноох

явдал гардаг байна. Энэ нь олон улсын “Шүүхийн шийдвэр урьдчилан таамаглах боломжтой байх ёстой”, “Ил тод байх ёстой” гэдэг зарчимтай зөрчилдөж, шүүмжлүүлсээр байгаа аж. Тэрбээр мөн “Хуульд өөрчлөлт оруулах нь муу зүйл биш. Учир нь хууль үргэлж шинэчлэгдэж, сайжирч байх ёстой. Тэгэхдээ хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг хааж, боосон, хориглосон биш. Эсрэгээрээ боломж бий болгосон, дэмжсэн байх шаардлагатай” гэж үздэг байна.

Жастин Капла гэгч АНУ-ын иргэн болон бусад холбогдох хүмүүсийн шүүх хурал болж шүүхээс шийтгэл оноосон үйл явдал саяхных. Капла бол санхүүгийн асуудлаар шүүхэд дуудагдсан 200 гадаад иргэний нэг нь л гэдгийг бизнесийн хүрээнд ярьж байна. Үүнээс гадна мөн л санхүүгийн “гэмт хэрэгтэн”-д буруутгагдаж, шалгагдаж байгаа 3000 гаруй монгол хүн байгаа гэх. Тэднээс яг хэд нь санаатайгаар үйлдсэн, хэд нь санамсаргүй бөгөөд тогтворгүй хуулийн орчинд өөрөө ч мэдэлгүй буруутсаныг ялгаж салгах аргагүй. Ямартай ч энэ эх толгойгүй, учир замбараагүй хуулийн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт, дүрэм, журам дунд гаднын “хитмэнүүд” гэхээсээ илүүтэй дотоодын баялаг бүтээгчид хохирч байгаа гэдэг л харин жинхэнэ үнэн биз ээ.

Энэ “үймээн”-ий хөлд хохирогч нь Монгол Улс, бизнес эрхлэгчид төдийгүй энгийн иргэд болж байна. И.Сэр-Одын хэлснээр эрх зүйн тогтвортой орчин бүрдээгүй нөхцөлд тогтвортой хөрөнгө оруулалт байх боломжгүй аж. Тэрбээр “Энэ нь амьдрал дээр тохиолдож санхүүжилтгүй болсон компаниуд зардлаа танах, ажлын байраа цомхтгох арга хэмжээ авч, иргэний аж амьдралд нөлөөлөхүйц хэмжээнд хүрсэн нь харамсалтай байна” гэсэн юм. Гэхдээ бүх хөрөнгө оруулагч гарчихаагүй байгааг Сэр-Од мөн сануулж байсан. Тэд Монгол Улс хувийн хэвшил, хувийн хөрөнгөтэй хэрхэн харьцаж байна гэдгийг ажиглаж байгаа аж. Тиймээс тогтворгүй байдал бий болгосон хуулиудыг цаашид батлахгүй байхад анхаарах хэрэгтэй гэсэн юм. ■

СУДАЛГАА

Байгаа зөв онилбол Хөгжлийн зам дөт



Иланд Роберт Манн
/“Mongolian Economy” сэтгүүлийн
Англи хэлний редактор/

Монголын уул уурхайн салбарт тодорхойгүй байдал ноёрхсоор байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алгуур алдаж буй хэрэг болж байна. “The Mining Law Review” судалгаанд өгүүлснээр Монгол Улсын Засгийн газар хуулийн хүрээнд гэнэтийн шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийсээр буй бөгөөд энэ нь Монголын эдийн засгийн өсөлтөд зайлшгүй шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулж буй голлох хүчин зүйл аж. Монголын Засгийн газар алсаа хараагүй бодлогуудыг хэрэгжүүлж ирсэн нь нэг удаагийн үзэгдэл биш. Ингэхийн зэрэгцээ тулгуур салбараа “тоглоом” гэж санаж савалгаатай бодлогоор авч явсаар ирсэн нь уул уурхайн салбарт үр дүнгүй туршилт хийсээр хийж уул уурхайг улсынхаа эдийн засгийн хөдөлгөгч хүч гэж үзэхгүй байгааг харуулсан хэрэг юм. Сүүлийн жил гаруйн хугацаанд Монголын Засгийн газар уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгахыг зорьж буй гэдгийг дээрх судалгаанд онцолсон байна. Ингэхдээ шинэчлэл, нэмэлт өөрчлөлт бүрийг бэхжүүлэн хэрэгжүүлэх нь Монголын эдийн засгийн хөгжлийг улам бадраах үндэс төдийгүй тус салбарт урт хугацаанд үргэлжлэх амжилт дагуулна хэмээн дүгнэсэн байгаа юм.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Хуулийн тогтвортой орчин гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувь хэмжээтэй шууд холбоотой оршдог. Хууль хэр тууштай хэрэгжиж байна тэр хэмжээгээр гадаадын хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэж байдаг аж.

Өнгөрсөн оны сүүлээр хэвлэгдэн гарсан “The Mining Law Review” судалгаанд өгүүлснээр Монгол Улсын онцлох салбаруудад үйлчлэх хэд хэдэн чухал хуульд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хуулийн дээрх савалгаатай байдал хөрөнгө оруулагчдыг Монголын зах зээлд орох хүслийг улам бууруулж буй. Энэ талаар “Oxford Business Group”-ийн гаргасан “The Report: Mongolia 2014” тайланд дурдахдаа “Гэнэтийн өөрчлөлтүүд, түүнийг эргүүлэн татдаг явдал, чухал хууль дүрмийг батлахдаа хэт уддаг нь хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид төлөвлөлт хийх боломжийг сааруулж байгаагийн зэрэгцээ тогтвортой орчинд үйл ажиллагаа явуулах баталгаагүй болгож байна” гэжээ.

Монголын Засгийн газар хуулиар “наадах” дуртайгийн бас нэгэн илрэл 2012 онд баталж байсан Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тод харуулдаг. Тодруулж хэлбэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтад тун халгаатай байсан хэмээгддэг тус хууль хэрэгжиж эхэлснээр Монголыг сонирхож байсан хөрөнгө оруулагчид өөр орнууд руу анхаарлаа хандуулах болсон. Хэдийгээр зарим шинжээчийн үзсэнээр тус хууль Монголын уул уурхайн салбарын стратегийн хэсгүүд дэх Хятадын компаниудын нөлөөг багасгах сэдэлтэй байсан гэх боловч үр дагавар нь үүгээр дуусаагүй юм. Улмаар Монголын Засгийн газар тус хуулийг хэрэгсэхгүй болгосон ч эдийн засагт хэдийнэ хүнд гарз учруулсан байлаа.

Монголын төрийн зүгээс тус хуулийг илүү либерал болгож 2013 оны аравдугаар сард шинэчлэн баталсан. Ингэхдээ нэршлийг Хөрөнгө оруулалтын тухай хууль болгосон. Өдгөө Монгол Улсад орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт

хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 85 хувиар буурсан гэх тоо бий. Гэхдээ энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хэрэгжилт муу байна гэсэн үг биш. Уг хуулийг хөрөнгө оруулалтын салбар тогтворжиж буйн илрэл хэмээн “The Mining Law Review” судалгаанд бичсэн байгаа юм. Гагцхүү Засгийн газар хуулийн тууштай хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй аж.

Тайланд онцлон тайлбарлахдаа шинээр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль холбогдох салбаруудад чиглэх хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэжээ.

Монголын санхүүгийн болон үнэт цаасны зах зээлийн хөгжил ерөнхийдөө сул. Хөрөнгө оруулалтаас хэт хамааралтай эдийн засгийн хувьд Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт огцом буурсан нь хүндрэл дагуулсан. Тэгвэл тайланд гаргасан зөвлөмжид “Олон улсын стандартад нийцсэн, итгэж болохуйц үнэт цаасны зах зээлийг бий болгосноор үнэт цаасны арилжааг дэмжиж, капитал босгох, нөгөө талаар санхүүгийн сектор төрөлжих боломж бүрдэнэ” гэсэн байна. Мөн Монгол Улс санхүүгийн салбараа төрөлжүүлээгүй цагт хөрөнгө оруулалтаас хамаарсан эдийн засаг хэвээр байх тухай өгүүлжээ. Ийм төрөлжилт нь эргээд хөрөнгө оруулалтын тогтвортой орчин шаарддаг.

АЛДААТАЙ Ч АВАРЧ БОЛОХ ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийг хөндөөд багагүй хугацаа өнгөрлөө. Дээрх хуулиудыг батлахдаа Монголын Засгийн газар ил тод байдлыг сайжруулах зэргээр хөрөнгө оруулалтын салбарт дэм болох алхмуудыг хийж буйг тайланд



оролцсон хуулийн фирмүүдийн төлөөллүүд сайшаасан байна. Түүнчлэн дээрх хуулиуд хэрэгжиж байгаа нь холбогдох салбаруудын ирээдүйд чухал хувь нэмэр болох талаар ярьжээ. Зах зээлийн мөнгөн хөрөнгийн чадамж сайжрах нь Монголын үнэт цаасны зах зээл, ялимгүй удаан ч гэсэн хөгжих боломж бүрдэх юм. Ийн тус зах зээлийн хөгжлийг дэмжих үүднээс дээр дурдсан хуулиудыг өөрчлөн шинэчилсэн билээ.

Өнгөрсөн болон энэ оны хувьд Монголын Засгийн газар, томоохон

хөрөнгө оруулагчид хооронд татвартай холбоотой маргаан багагүй дэгдсэн. Тодруулбал, Канадын “Хан Ресурс”-т Монгол Улс 100 сая ам.доллар төлөх шийдвэрийг Олон улсын арбитрын шүүхээс гаргасан. Түүнчлэн “СаусГоби” компанийн холбогдох удирдах албан тушаалтнууд татвараас зайлсхийсэн хэрэгт буруутгагдан түр хугацаанд хоригдсон явдал олон улсад сөрөг дохио өгсөн. Мөн “Рио Тинто”-той хийх хэлэлцээр эцэслэгдээгүй байгаа нь олон улсын хөрөнгө оруулагчдад хүлээлт үүсгэсээр байгаа төдийгүй

Тавантолгойн тендерт ялсан консорциумын Монголын Засгийн газартай хийх хэлэлцээр тодорхой шалтгаануудын улмаас тоймтой урагшлахгүй байгаа юм.

Харин уул уурхайн хайгуул, олборлолт хийх тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн нь хөрөнгө оруулагчдад таатай мэдээ болсон. Одоогоор 29 тусгай зөвшөөрлийг хуучин эздэд нь буцаан олгосон бол зургааг тендерт оролцож лицензийн эзэмшлээ авсан комданиудад өгчээ. Үүнтэй холбогдуулан “The Mining Law Review” тайланд “Барьцаалах зарчмаар хөрөнгө босгож санхүүжилт хайх арга зам Монголын дотоод эдийн засгаа санхүүжүүлэх гол эх үүсвэр болж байна” хэмээжээ.

Монголын уул уурхайн салбарт холбогдох бүхий л хууль хэрхэн хэрэгжихийг харах л үлдлээ. Хэдий муу мэдээ тасрахгүй байгаа ч тулгуур салбараа хөгжүүлэх эрмэлзэл Монгол Улсын төрд бийг үгүйсгэж боломгүй. “Хууль эрх зүйн шилжилтийн үе тохиож байгаа энэ үед хөгжлийн шийдэл гарсаар байна. Монголын зах зээлийн онилох гол бай нь хууль эрх зүй хэвээр байна” гэсэн дүгнэлтийг “The Mining Law Review” тайлан хийжээ. ■

БОДЛОГО

Алдах эрхгүй үйлдвэржилт



Б.Дөлгөөн
/Эдийн засагч/

Монгол Улс хэрэглэгч улс гэсэн нэр зүүгээд багагүй хугацаа өнгөрсөн. Бид өнөөдөр хэрэглэж буй олон бүтээгдэхүүнийхээ маш бага хувийг дотооддоо үйлдвэрлэдэг нь үнэн юм. 2012 онд хийсэн судалгаанаас харахад, бид хэрэглэж байгаа бензинийг 100 хувь гаднаас, төмрийн 93 хувийг, нэхмэл хувцасны 62 хувийг гээд ихэнх бүтээгдэхүүнээ гаднаас авдаг байна. Үүнийг тухайн үед Ерөн-

хий сайд байсан Н.Алтанхуяг “Монголдоо бүтээх шаардлага” танилцуулгадаа дэлгэж байсныг өнөөдөр олон хүн санаж байгаа байх.

Өнгөрсөн хоёрдугаар сарын 6-нд Засгийн газар “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг УИХ-д өргөн барьсан билээ. Монгол зах зээлийн нийгэмд шилжиж орохоос өмнө үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ таван жилийн төлөвлөгөө тавьж ажиллаж, өөрийн гэсэн зорилттой үйлдвэрлэлийг хөгжүүлж байсан. Төрөөс төлөвлөж, төрийн байгууллагууд хэрэгжүүлдэг тогтолцоонд сул тал байсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэсэн хэдий ч бид нэгэн үе аж үйлдвэрлэлийг Монголдоо цогцлоож чадсан юм.

2013 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт

үйлдвэрлэл ДНБ-ий 30.3 хувьтай тэнцэж байсан. Тухайн оны үнээр энэ бол 9.8 их наяд төгрөгтэй болж байсан гэсэн үг. Гэвч үйлдвэрлэлийн нэг том индекс болох экспортыг авч үзвэл манай улсын нийт экспортын 97 хувийг технологийн багтаамжгүй болон нам технологит бүтээгдэхүүн эзэлж байна. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш 25 жил өнгөрөхөд өнөөдөр яагаад ийм дүр зурагтай байна вэ? Энэ асуултын хариулт манай байгалийн баялагтай салшгүй холбоотой. Бид ашигт малтмалын бүтээгдэхүүнээ түүхийгээр гаргаж байгаа учраас технологийн багтаамжгүй эсвэл нам технологит бүтээгдэхүүний хэмжээ өндөр. Хоёрдугаарт, манай үйлдвэрлэлийн өнөөгийн стандарт, технологийн нэвтрэлт муу байгаатай

холбоотойгоор дотоодод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн экспортод гарч чадахгүй байна. Манай улсад аж үйлдвэрлэл хөгжихгүйгээр экспортод эзлэх технологийн багтаамжгүй, нам технологит бүтээгдэхүүний хувь буурахгүй.

**АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖИХӨД
ТОДОРХОЙ ЗОРИЛТУУД,
СТРАТЕГИ ШААРДЛАГАТАЙ**

1995 онд цахилгаан бараа, бүтээгдэхүүн Хятад улсын нийт экспортын 15 хувийг эзэлж байсан бол 2009 онд энэ хэмжээ 30 хувь хүртэл нэмэгдсэн байна. Харин энэ хугацаанд экспортод бөс бараа, бүтээгдэхүүний эзлэх хэмжээ 25 хувиас 20 хувь хүртэл буурсан аж.

зайлшгүй шаардлага бий. Тиймээс ч “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-д тусгасан зорилтуудыг гурван үе шаттайгаар тус бүр таван жилийн хугацаатай 2015-2030 онд хэрэгжүүлэхээр Засгийн газар төлөвлөж тодорхой бодлогуудыг боловсруулж байгаа юм.

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ЭКСПОРТОД ТУЛГУУРЛАЖ
ХӨГЖҮҮЛЭХ ЁСТОЙ**

Аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ импортыг орлох эсвэл экспортыг дэмжих чиглэлтэйгээр хөгжүүлдэг. Үйлдвэрлэлийг импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дагнан хөгжүүлнэ гэвэл олон дутагдалтай гэдэгт өнөөдөр хөгжлийн

лийг нэгтгэн үндсэн хүчин зүйлийн бүтээмж гэж нэрлэдэг. Үүнд багтаж байгаа гол хүчин зүйлс нь технологийн дэвшил болон бүтээмж байдаг. АНУ-ын Принстон их сургуулийн харьяа Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн профессор Дани Родрикийн хэлж байгаагаар Латин Америк импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлснээр үндсэн хүчин зүйлийн бүтээмжээ нэмэгдүүлжээ.

Латин Америкийн хувьд 1970-1980 онд импортыг орлох үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлсэн боловч өнөөдөр Латин Америкийн улсуудын хувьд үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хэмжээ эргээд буурчигжээ. Үүний гол шалтгааны нэг бол тэд импортыг орлоход хэт анхаарснаас болсон гэж



Аж үйлдвэрлэл хөгжихгүйгээр экспортод эзлэх нам технологит бүтээгдэхүүний хувь буурахгүй

Энэ чиг хандлага үргэлжилбэл урд хөрш илүү нэмүү өртөг шингэдэг, өндөр технологи бүхий үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж улмаар нам технологит, эсвэл технологийн багтаамжгүй бүтээгдэхүүний эзлэх хэмжээ багасна. Манай улсын хувьд энэ хугацаанд өөрийн харьцангуй давуу талыг ашиглан ямар үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэх тал дээр нарийн стратеги, тодорхой зорилтуудыг тодорхойлж гаргах

эдийн засагчид санал нэгддэг. Гэвч импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлд давуу ч тал бий. Ийм төрлийн үйлдвэрлэлийг богино хугацаанд хөгжүүлэх боломжтой байдаг. Үүнээс гадна үндсэн хүчин зүйлийн бүтээмж(total factor productivity)-ийг нэмэгдүүлдэг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд капитал болон хөдөлмөр ордог боловч үйлдвэрийн бүтээгдэхүүний гарц нэмэгдэхэд нөлөөлсөн бусад хүчин зүй-

үздэг. Жишээлбэл Мексик, Колумб, Аргентин улс импортыг орлохыг чухалчилж, энэ чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлсэн. Эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Латин Америкийн олон улс өөрийн дарамттай болж хоцорсон гашуун түүх бий. Харин энэ хугацаанд амжилттай хөгжиж, эдгээр хөгжлийн өсөлтөө урт хугацаанд хадгалагдаж үлдсэн Зүүн Азийн улсуудын хувьд үйлдвэрлэлийг илүү экспортод

чиглүүлж хөгжүүлсний үр дүнд хөгжилтэй орны тоонд багтжээ. Зөвхөн импортыг орлоход анхаарч үйлдвэржилтийг хөгжүүлнэ гэвэл тухайн улс импортын тарифыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах гол аргыг ашигладаг. Гэтэл дотоодын зах зээлээ хамгаалуулж чадсан аж ахуйн нэгжүүд гадаад зах зээл рүү экспортлохгүй тохиолдолд тэд энэхүү хамгаалалтад дасаж, улмаар шинэчлэл авчрах сонирхол буурч, үр дүнд нь хамгаалагдсан зах зээл дээрх хэрэглэгчид илүү өндөр үнээр бүтээгдэхүүн худалдан авах шаардлагатай тулгарч, улмаар хохирдог. Гэтэл дотоодын зах зээлийг хамгаалахдаа тухайн дотоодын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд экспортлох шаардлага тавих юм бол илүү амжилттай байдаг. Жишээлбэл Өмнөд Солонгос улс дотоодын авто машины үйлдвэрүүдийг хамгаалах үүднээс импортын татвараа тусгай хэлэлцээр байгуулаагүй орнуудын бүтээгдэхүүнд 20.4 хувь хүртэл тавьсан байдаг. Ийнхүү импортын татварыг өндөр тогтоосны хариуд Өмнөд Солонгосын Засгийн газар машин үйлдвэрлэгчдэд АНУ-ын хурдны замаар найдвартай зорчих машин үйлдвэрлэхийг шаарддаг. Үүний үр дүнд Солонгосын машин үйлдвэрлэгчид хамгийн сүүлийн үеийн технологийн шинэчлэлтэй ойр байж, үүнийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ гаргахад хялбар байдаг байна.


МОНГОЛЫН БОЛОМЖ

Нэгэнт үйлдвэржилт бол Монголоос өмнө олон улс орон хэрэгжүүлж, алдах үедээ алдаж, олох үедээ олсон түүхтэй учир бүхэл бүтэн шинжлэх ухаан болсон. Бидний хувьд ч гэсэн “Аж үйлдвэрлэл” хөгжүүлэх стратеги боловсруулахдаа эдгээр гадаадын олон улсын туршлагаас суралцах зүйл ихтэй билээ. Бидэнтэй хамгийн ойрын жишээ гэвэл Япон, Солонгос зэрэг улс байна. Харин Засгийн газар энэхүү чухал бодлогоо боловсруулахдаа зөвхөн амжилттай хэрэгжсэн жишээнээс гадна амжилтгүй унасан загваруудыг давхар судалж чадвал ирээдүйд манай бодлого хэрэгжилт илүү өндөр үр дүнтэй байна. Үүнээс гадна хамгийн чухал зүйл бол өнөөдөр шиг төрийн болоод хувийн хэвшилд ног-


Үндсэн хүчин зүйлийн бүтээмж (%)

Бүс нутаг	1960-1970	1970-1980	1980-1990	1990-2000
Зүүн Ази (Хятад орохгүй)	1.5	0.9	1.3	0.5
Латин Америк	1.6	1.1	-2.3	0.4
Өмнөд Ази	0.7	-0.2	2.2	1.2
Африк	1.9	-0.3	-1.4	-0.5
Ойрхи Дорнод	2.6	-0.6	0.1	0

Эх сурвалж: профессор Дани Родрик



Эх сурвалж: Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн “Монголдоо бүтээх шаардлага” танилцуулгаас



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

дож буй өрийн дарамт өндөр үед үйлдвэржилт нэрийн дор хий дэмий өрсөлдөх чадваргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө зарж, улсын хувьд алдаатай бодлогын араас хөөцөлдөж цаг алдахаас сэргийлэх ёстой.

Тийм учраас үйлдвэрлэлийг экспорт руу чиглүүлж хөгжүүлэх нь манай ирээдүйн чиг хандлага мөн. Экспортыг дэмжих үйлдвэрлэл бол бидний үйлдвэржих ирээдүйн боломж. Энэхүү боломжийг Монгол Улс, Япон улстай байгуулсан "Эдийн засгийн түншлэл"-ийн хэлэлцээрээр баталгаажуулж өгсөн гэж хэлж болно. Анх 2010 онд манай хоёр орны хоорондын "стратегийн түншлэл"-ийн хүрээнд "Эдийн засгийн түншлэл"-ийн хэлэлцээр байгуулахаар талууд тохиролцож байсан нь ажил болж Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Япон Улсад ажлын айлчлал хийх үеэр "Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр"-т энэ оны хоёрдугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан

юм. Энэ хүрээнд Монгол Улс дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан Барааг кодлох уялдуулсан системийн ангиллаар 9300 орчим төрлийн барааг Япон улс руу импортын бага тарифтайгаар оруулах боломжтой болжээ. Манай улсын хувьд 70 орчим төрлийн барааг Япон руу экспортолж, Японоос 1500 орчим бараа бүтээгдэхүүн импортолж авдаг байна. Монгол 2010-2014 оныхооронд нийт 2.0 тэрбум ам.долларт тэнцэх бараа бүтээгдэхүүнийг Япон улсаас импортолж авсан бол энэ хугацаанд 54 сая ам.долларт тэнцэх бараа бүтээгдэхүүнийг Япон улс руу гаргасан байна. Нэг ёсондоо Японоос авсан барааны 2.7 хувьтай тэнцэх хэмжээний барааг тус улс руу экспортолжээ.

Өнөөдрийн энэ дүр зураг бол эргээд бидний үйлдвэржилт байхгүйгээс гадна Япон улсын импортын тариф, дотоодын нарийн бодлоготой холбоотой. Япон улс хөгжсөн улс ч гэлээ бараа бүтээгдэхүүн бүр дээр импортын

тариф харилцан адилгүй өндөр байдаг. Яагаад энэ боломжийг бид үйлдвэржилттэй холбож ярьж байна вэ гэвэл "Эдийн засгийн түншлэл"-ийн хэлэлцээрийг Японы Парламент, Монгол Улсын УИХ-аар хэлэлцэж баталсны дараа буюу хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Японы тал 9300 барааныхаа 86 хувийг буюу 8000 төрлийн барааны импортыг бүрэн чөлөөлөх юм байна. Уг боломжийг алдалгүй, мөн өөрсдийн харьцангуй давуу талыг ашиглан үйлдвэржилтээ сэргээх нь одоо манай бодлого боловсруулагчид, хувийн хэвшлийнхэн, мэргэжлийн холбоодоос хамаарах юм.

2013 онд хийсэн судалгаанаас үзэхэд Монгол Улс Япон улстай "Эдийн засгийн түншлэл" –ийн хэлэлцээр байгуулснаар Монголын ДНБ жилд дунджаар 0.33-0.34 хувь, нийт экспорт 0.36 хувь өсөх тооцоо гарсан байдаг ч гэлээ, эргээд манай үйлдвэржилт тэлж, үйлдвэрлэл өсвөл үүнээс өндөр гарах бүрэн боломжтой. ■

ЭЛЧИН САЙД

Япон, Монголын шинэ түншлэл ба боломж

Б.Энхцэцэг

Монгол Улс Японы хувьд экспортоор 74 дүгээр байрыг эзэлж байгаа бол импортоор 126-д ордог орон. Гэхдээ хоёр орны хоорондох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /ЭЗТХ/-ийн хүрээнд олгогдож буй боломжуудыг Монгол сайн ашиглаж чадвал энэхүү байр сууриа өндөрсгөх боломжтой гэж Монгол Улсад суугаа Японы Элчин сайд Шимизү Такэнори хэлж байна. Тэрбээр Япон улс Монголыг хөгжиж чадна гэж итгэж буй учир ЭЗТХ байгуулсан хэмээн хэлсэн юм. Шимизү Такэнори нь Монголтэй ажил амьдралаа холбоод 40 жил болж байгаа хүн. Түүний үндсэн боловсрол, мэргэжлийн чиглэл нь хууль зрх зүй, гадаад бодлого хэдий ч Монгол хэлийг сонирхон судалж, 1977-1978 онд МУИС-ийн монгол хэлний тусгай ангид суралцаж төгсжээ. Тэрбээр өдгөө Монгол хэлээр чөлөөтэй ярьдаг. Мөн Шимизү Такэнори сайд Монголын талаар олон тооны

бүтээл нийтлэлийг туурвиж япон болон монгол хэл дээр хэвлүүлж байжээ. Манай сэтгүүл энэ удаад түүнтэй ЭЗТХ эцэслэгдсэн тэй холбоотойгоор яриа өрнүүлсэн юм.

-Монгол улс Япон улстай харилцаж ирсэн эдийн засгийн харилцаа ямар түвшинд явж ирэв. Хоёр орны эдийн засгийн харилцаанд сүүлийн жилүүдэд ямар дэвшил гарсан бэ?

-Тэртээ 1990-ээд оноос хойш Япон улс Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд Монголын тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжсээр ирсэн. Өнөөг хүртэл Япон улсаас үзүүлсэн буцалтгүй тусламж, иенийн хөнгөлөлттэй зээл, техникийн хамтын ажиллагааны нийт дүн ойролцоогоор 250 тэрбум иен буюу 2.3 тэрбум ам. долларт хүрч, Монголын зам тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбараас гадна эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан зэрэг нийгмийн салбаруудыг өргөнөөр хамарсан. Монгол Улс,

ялангуяа газрын баялгаа ашиглан эдийн засгаа үсрэнгүй хөгжүүлэх болсон цагаас хойш Япон улсын хөгжлийн албан ёсны тусламжид суурилсан нэг талт эдийн засгийн харилцаа бус, хоёр талт эдийн засгийн харилцаа тогтоохыг зорих нь зүйн хэрэг болсон юм.

Японы компаниудын Монголыг сонирхох сонирхол нэмэгдэж байгаа бөгөөд ялангуяа 2013 оны гуравдугаар сард Ерөнхий сайд Шинзо Абэгийн Монгол Улсад хийсэн айлчлалын дараагаас улам эрчимжин, Монголд орж ирэх компанийн тоо ч өссөн. Цаашид манай хоёр орны хувийн хэвшлийнхэн нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглан, эдийн засгийн харилцаагаа улам бүр хөгжүүлэх нь чухал. Үүнд гурван жилийн турш хэлэлцсэний эцэст энэ оны хоёрдугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан "Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр" нь дээрх харилцааг хөгжүүлэх чухал хүчин зүйл болох юм.

-Өнгөрсөн хугацаанд гэрээ



байгуулах хүрээнд ямар бүтээгдэхүүнүүд дээр голчлон онцолж тохиролцоонд хүрсэн бэ?

-Япон, Монгол хоёр улс нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт ЭЗТХ-ийн үндсэн үзэл баримтлалыг нийцүүлэх үүднээс, гаалийн татварын тухайд “гадаад худалдааны нийт дүнгийн 90 буюу түүнээс дээш хувийг 10 жилийн дотор бүрэн тэглэх” гол зарчмыг баримтална. Үүний тулд эхлээд Япон улсаас Монголд нийлүүлэх нийт экспортын дүнгийн 70 орчим хувийг эзлэх автомашин болон машины сэлбэгийг гаалийн татвараас бүрэн чөлөөлөхгүйгээр ЭЗТХ-ийн үндсэн зарчмыг хангаж чадахгүй юм. Япон улс хуучин автомашины гаалийн татварыг тэглүүлэн, хуучин автомашины экспортыг дэмжиж байна гэсэн буруу ташаа ойлголт гарсан байж болзошгүй ч Япон улсын

хувьд ийм сонирхол огтхон ч байхгүй. Хэлэлцээний дүнд гол хэрэглээ болох цилиндрийн багтаамж нь 4500 см куб хүртэлх бүрэн угсарсан автомашиныг (үйлдвэрлэснээс хойш 0-3 жил болсон) ЭЗТХ хүчин төгөлдөр болмогц гаалийн татвараас шууд чөлөөлнө. Машин механизмын тухайд гэвэл, гол нэр төрлийн барилгын машин механизм (бульдозер зэрэг)-ын гаалийн татварыг шууд тэглэх, бусад машин механизмыг 10 жилийн дотор үе шаттайгаар чөлөөлөхөөр санал нэгдсэн. Харин үйлдвэрлэснээс хойш 10 ба түүнээс дээш жил болсон хуучин автомашиныг гаалийн татвараас чөлөөлөхгүй гэж тохиролцсон. Мөн гэрээ хүчин төгөлдөр болсноос хойшхи тав дахь жилдээ зах зээлд нэвтрэх нөхцөлийг сайжруулах болон бусад асуудлуудын талаар хэлэлцээ хийхээр заасан болно.

-Тэгвэл Монголын талаас

түншлэлийн хүрээнд Японд хэдэн нэр төрлийн бараа нийлүүлэх вэ?

-Монголын талаас хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнийг Японы гаалийн татвараас чөлөөлөх хүсэлтийг тавьсан ч уг барааг Японд эмзэг бараанд тооцдог. Хэлэлцээний дүнд чацарганы дарс зэрэг зарим чацарганы гаралтай бүтээгдэхүүн, тэжээвэр амьтны тэжээлийг татвараас шууд чөлөөлөхөөс гадна зарим боловсруулсан үхрийн махан бүтээгдэхүүн, жишээ нь “beef jerky” (хатааж боловсруулсан үхрийн мах), “corned beef” (нөөшилсөн үхрийн мах) зэрэгт гаалийн татварын квот тогтоохоор болсон. Одоогийн байдлаар үхрийн махны хувьд шүлхий өвчин зэрэг асуудлаас болоод түүхий мах экспортлох боломжгүйг анхааран үзээд, мал, амьтны эрүүл мэнд болон мал эмнэлгийн үйлчилгээ, сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн мах, органик хүнс, үр тариа болон хүнсний ногооны үйлдвэрлэл зэрэг хөдөө болон мал аж ахуйн салбарт хамтран ажиллахаар тогтсон нь ч ЭЗТХ-ийн онцлог бөгөөд хоёр талын хэлэлцээний үр дүнд гарсан амжилт юм.

-Ирэх жилүүдэд Японы хөрөнгө оруулагчид Монголын зах зээл рүү идэвхтэй орж ирж, монголчуудтай хамтарч ажиллана гэж харж байгаа. Тэгвэл Япон компани болон хөрөнгө оруулагчид Монголд орж ирэхэд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр ямар давуу хөнгөлөлт боломжуудыг олгож байгаа вэ?

-Хөрөнгө оруулалтын хувьд, өмнө нь байгуулсан “Монгол Улс, Япон Улс хоорондын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр”-тэй харьцуулахад, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах тал дээр илүү ахиц гарсан, өөрөөр хэлбэл хувийн хэвшлийнхэн харилцагч орныхоо хөрөнгө оруулалтын зах зээлд гарсны дараа төдийгүй хөрөнгө оруулалтын зөвшөөрөл авах үе шат хүртлээ үндэсний нөхцөл, нэн тааламжтай үндэстний нөхцлийг эдлэх боломжтой. Жишээлбэл, Японы компани Монголд хөрөнгө оруулахад Монголын компанитай нэгэн адил нөхцөл, эсвэл дор хаяж Монгол гуравдагч оронд үзүүлдэг нэн тааламжтай нөхцөлийн аль нэгийг эдлэх боломжтой болно.

Үүнийг мэдээж зөвхөн Японоос Монголд төдийгүй, Монголоос Японд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд ч

адил мөрдөнө. Монголын компаниуд Японд идэвхтэй хөрөнгө оруулалт хийх нь Монголын эдийн засагт эерэгээр нөлөөлөх нь гарцаагүй.

-Японы хөрөнгө оруулагчид Монголд орж ирэхэд одоо ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна гэж харж байгаа вэ?

-Японы Элчин сайдын яам нь Япон улсын Засгийн газрыг төлөөлөх байгууллагын хувьд Японы компаниудад тулгарч буй бүхий л асуудлын талаар шаардлагатай тусламж, зөвлөгөө өгдөг. Тэдний тавьж буй асуудлуудыг нэгтгэн үзвэл, нэгдүгээрт, Монголын хууль эрх зүйн орчин гэнэт өөрчлөгддөг, хоёдугаарт, хуулийн тайлбар нэгдсэн байдлаар тогтоогүй тул хариуцаж буй хүнээсээ хамааран харилцан адилгүй байх, гуравдугаарт, зөвшөөрөл, лиценз олгох журмыг хуулинд заасны дагуу хэрэгжүүлдэггүй, мөн хууль тогтоомж, дүрэм, гэрээг мөрдөх ёстой гэдэг ойлголт хэвшээгүй зэрэг асуудлууд голдуу гардаг. ЭЗТХ хүчин төгөлдөр болсноор хөрөнгө оруулалтын болоод бизнесийн орчин сайжран, дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх арга зам, сайжруулах механизм бий болж эдгээр саад учруулж буй хүчин зүйлс буурна гэж найдаж байна.

-Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан, Монголын барааг Японд экспортлоход шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлтийн талаар товчхон сонирхож болох уу?

-Монголын тал бүтээгдэхүүн экспортлохдоо ЭЗТХ-ийн тусгай хөнгөлөлттэй тарифын хэмжээг хэрэглэх хүсэлтэй бол хэлэлцээрт заасан гарал үүслийн дүрэмд үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас Монголын зохих гарал үүсэлтэй барааны шаардлага хангасан болохыг нотолсон гэрчилгээг авч, бусад заасан бичиг баримтын хамт гаалийн бүрдүүлэлтээ хийх шаардлагатай. Түүнчлэн, гаалийн татварын квотыг хэрэглэх үед, Монголын талд квотын шалгуурт нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийн, энэ хүрээнд Японы гаалийн татварын квотын гэрчилгээг олгоход шаардлагатай бичиг баримтуудыг (экспортлох тоо хэмжээг тусгасан байх) экспортлогч этгээдийн мэдүүлэгт үндэслэн Монголын талын эрх бүхий төрийн байгууллага олгоно.

-ЭЗТХ-ийн бодит үр дүн хэзээнээс хэрхэн гарч ирэх бол. Ойрын үед гарах үр дүн нь аль

салбарт ямар байх бол?

Худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал нь эдийн засгийн байдал, ханшийн өөрчлөлт зэргээс ихээхэн хамаардаг тул ЭЗТХ хүчин төгөлдөр болсноор ямар үр дүн гарахыг урьдчилан таамаглахад хэцүү хэдий ч хүчин төгөлдөр болмогц гаалийн татваргүй болох олон байгаа тул юуны өмнө бараа бүтээгдэхүүний худалдааны салбарт тодорхой үр дүн гарах болов уу. Өмнө нь ЭЗТХ-ийг байгуулсан улсуудын жишээг харахад импорт, экспортоос гадна хөрөнгө оруулалт ч мөн нэмэгдсэн байдгийг дурдах нь зүйтэй.

-Сүүлийн үед Монголын хөрөнгө оруулалтын орчин муудсантай холбоотой цөөнгүй гаднын компани Монгол дахь үйл ажиллагаагаа хумилаа. Тэгвэл Японы компаниудын хувьд байдал ямар байна вэ?

-Монголд ажиллаж буй япон компаниудын тоо эсрэгээрээ нэмэгдэх хандлагатай байгаа. Учир нь тэд байдал одоо хэцүү байгаа ч Монголын ирээдүйд итгэлтэй байна. Хэрэв байгалийн баялгаа зохистой ашиглаж чадвал хөрөнгө оруулалт сэргэж, эдийн засаг сайжирна. Мөн хүндрэлтэй энэ үед ирж үйл ажиллагаа эхлүүлбэл ирээдүйд илүү амжилт олж мэдэх юм гэдэг яриа манай компаниудын дунд өрнөж байна. Өнгөрсөн онд гэхэд Японы хөрөнгө оруулалттай компаниудын тоо өмнөх жилтэй харьцуулахад 11-ээр нэмэгдсэн.

-Монголын хувийн хэвшил болон төр энэхүү эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглахын тулд ямар бэлтгэлүүд хийх шаардлагатай вэ?

-Мэдээжийн хэрэг, ЭЗТХ хүчин төгөлдөр болмогц хэлэлцээрийн агуулга бүгд нэг бүрчлэн хэрэгжиж эхэлнэ. Өөрөөр хэлбэл, ЭЗТХ-ийн бүх заалтуудыг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоог бий болгохгүй аваас хүчин төгөлдөр болж чадахгүй. Иймд Монголын тал энэ нөхцөлийг яаралтай хангахын төлөө шуурхай ажиллах шаардлагатай байна. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр хамтарсан хороо байгуулан, үйл ажиллагааны журам болон холбогдох дэд хороодыг байгуулах зэрэг хэлэлцээрт заасан олон зүйлийг шийдвэрлэнэ. Мөн хүчин төгөлдөр болсон өдөртөө гарал үүслийн гэрчилгээг олгох зэрэг ажил эхэлнэ.

Монголын хувьд анх удаа байгуулж буй ЭЗТХ учраас Монголын Засгийн газрын холбогдох байгууллагуудын ажилтнуудын сургалтаас эхлээд хэлэлцээрийг хэрэгжүүлэх тогтолцоог баттай бүрдүүлэх, нөгөөтэйгүүр хувь хүн, хувийн хэвшлийнхний ЭЗТХ-ийг ашиглахыг дэмжих үүднээс олон нийтийн сурталчилгаа, тайлбар зэргийг хийх нь чухал болов уу. Хувийн хэвшлийнхэн ч мөн өөрсдөөс шаардагдах бичиг баримтуудыг бүрдүүлснээр анх ЭЗТХ-ийн ашигтай тарифыг хэрэглэж болохыг ойлгож, ЭЗТХ-ийн бүтцийг сайтар судлаасай гэж зөвлөмөөр байна.

-Япон улс ЭЗТХ байгуулсантай холбоотойгоор Монгол руу өгөх Засгийн газрын буцалтгүй тусламж дэмжлэгээ тэглэж байгаа юу?

-Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4000 ам.доллар хүрэх гэж буй улс буцалтгүй тусламж авах статуст хамаарахгүй болдог. Тиймээс цаашид Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг зөв зохистой ашиглах нь Монгол Улсад хэрэгтэй болов уу. Жишээлбэл, шинэ онгоцны буудал барих хүрээнд өгсөн хөнгөлөлттэй зээлийн хүү ердөө жилийн 0.2 хувь байх жишээтэй. Ийм хөнгөлөлттэй зээлүүдийг ашиглаж болно. Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн Засгийн газар харин энэ чиглэлд илүүтэй анхаарч байгаад талархалтай байна.

10 жилийн дараах Монгол Японы эдийн засгийн харилцаа ямар түвшинд гарсан байна гэж Та төсөөлж байна вэ?

-Би хувьдаа нэгэн хүсэл мөрөөдлийг тээж явдаг. Улс төр, соёлын харилцаатай харьцуулахад удааршралтай хөгжиж буй Япон, Монгол хоёр улсын эдийн засгийн харилцаа нь ЭЗТХ-ийн бүхий л хүчин чадлыг ашиглан өргөжин хөгжөөсэй. Цаашид хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт, худалдаа эргэлт улам нэмэгдэн, харилцан ашигтай, бие биенээ нөхсөн эдийн засгийн харилцаа тогтож улмаар Япон, Монгол хоёр улс өөр хэн нэгнээр орлуулшгүй "Стратегийн түншүүд" болоосой хэмээн хүсдэг.

Монголоос Японд хөрөнгө оруулсан компаниудын дундаас Сүмогийн Их аварга шиг амжилт гаргах компани төрөн гарч, цаашлаад Монголын олон брэнд бүтээгдэхүүн Японы дэлгүүрүүдийн лангууг дүүргэсэн байх сайхан ирээдүйг төсөөлөн боддог. ■

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

АМЖИЛТЫН ТӨЛӨӨС

Б.Энхцэцэг

Олон улсад аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, чуулган олонтаа болдог. Гэвч дэлхий 10.096 байгууллага, аж ахуйн нэгж зорьж очдог нэг л аялал жуулчлалын үзэсгэлэн бий. Тэр нь Германы Берлин хотноо жил бүр зохион байгуулагддаг ITB Berlin (The Internationale Tourismus-Borse). Тухайлбал, Лондон хотноо болдог “World travel market” хэмээх салбарын томоохон үзэсгэлэнд 5.000 аялал жуулчлалын байгууллага оролцдог. Энэ нь И Тэ Бэ /Герман дуудлага нь/ үзэсгэлэнгийнхээс 2-3 дахин доогуур үзүүлэлт. 2015 онд И Тэ Бэ өмнө нь тогтоосон амжилтуудаа эвдэж, илүү олон салбарын болоод аялах сонирхол бүхий хүмүүст үзэсгэлэнгээ үзүүлж чадсан. Тэд үзэсгэлэнгийн эцэст бахархалтайгаар бид дэлхийд тэргүүлэгч гэдгээ дахин баталлаа гэж зарласан. Тэгвэл тус үзэсгэлэнд албан ёсны түнш орноор оролцсон Монгол Улс дээрх амжилтаас хуваалцаж чадсан уу гэдэг монголчуудад илүү сонин.

И Тэ Бэ-гийнхэн монголчуудад хүлээлгэсэн итгэл нь хөсөрдөх вий гэдгээс эхэндээ эмээж байсан гэдэг. Харин буруу сонголт хийгээгүй гэдгийг нь баталж, ямар ч хөгжингүй орноос дутахааргүй, зарим талаар илүү байсанд баярлаж байгаагаа үзэсгэлэнгийн зохион байгуулагчид эцэст нь хэлсэн билээ. Тухайлбал, Герман талаас Монголын нээлтийн ажиллагаан дээр хамтарч ажилласан төслийн менежер Холгер Вилке “И Тэ Бэ-гийн зохион байгуулах багт орж 20 гаруй жил ажиллалаа. Гэхдээ өнгөрсөн хугацаанд Монголынх шиг ийм өвөрмөц, гайхал төрүүлэм нээлтийг харж байсангүй. Миний хувьд хамгийн шилдэг нь” гэсэн юм. Мөн И Тэ Бэгийн үзэсгэлэнгийн танхимуудад байгууллага, аж ахуй нэгжүүд 11 мянган сурталчилгааны талбай зассанаас Монголын сурталчилгааны талбай дизайны шийдлээрээ зургаадугаарт жагссан. Үүний зэрэгцээ Германы



Монгол Улс И Тэ Бэ-гийн (City Cube) хэмээх шинэ цогцолборт анх удаа нээлтийн арга хэмжээгээ зохион байгуулсан орон боллоо


Аяллын судалгааны хүрээлэнгийн судалгаагаар Монголыг зорих сонирхолтой германчуудын тоо 4.3 хувиар өссөн байгаа нь харагджээ. Энэ нь гурван сая герман хүн гэсэн үг аж. Тэднээс 150.000 нь ирэх гурван жилд Монголд аялахаар шийдчихсэн гэдгээ хэлсэн байна.

Жилдээ нэг удаа Берлин хотын бүх зочид буудал дүүрч, хөл хөдөлгөөнд даруулдаг. Энэ бол И Тэ Бэ-гийн үеэр буюу гуравдугаар сарын эхний өдрүүд. Берлин хотод “Чи хаанаас ирсэн бэ” гэх асуулт тосох бүрт “Монголоос” хэмээн хариулахад, зөрүүлээд “Энэ жилийн И Тэ Бэгийн түнш орноос ирсэн хүн байна” хэмээн найрсаг хүлээн авч байсныг үзэсгэлэнд ирсэн монголчууд хэлж байлаа. И Тэ Бэ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн Ерөнхий захирал Кристиан Гёке “Берлин хот нь өнөөдөр нүүдэлчдийн нийслэл болоод байна” хэмээн хэлж байсан. Тус үзэсгэлэнд Ерөнхийлөгч, Аялал жуулчлалын салбарын сайд тэргүүтэй аялал жуулчлалын салбарын 300 шахам монгол төлөөлөгч ирсэн. Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж

“Монголчууд эргэн ирсэн. Гэхдээ энэ удаад дайлаар мордох гэж биш найз нөхөд болох гэж ирлээ” хэмээн салбарын шийдвэр гаргагч 3600 хүний өмнө хошигноод авсныг олон улсын хэвлэл мэдээллийнхэн олзлон авч, И Тэ бэгийн тухай сурвалжлагууддаа онцолж байв.

Мөн тус хотын хамгийн олон хүн цувдаг гол гудамж талбайгаар Монголын лого бүхий таксинууд сүлжилдэж, Монголыг сурталчилсан зурагт хуудас, самбар олны нүдийг хужирлаж, “Messe Berlin” үзэсгэлэнгийн барилгын гадна 15 ханатай Монгол гэр сүндэрлэн, төв хаалга дагуу Монгол түнш орноор оролцож буйг илтгэсэн томоохон зургийг туургалан тойруулсан байв. Хэдийгээр эдгээр өдрүүдэд дэлхий нэг дор цугладаг ч Берлин хот Монголоор “амьсгалж” байна уу гэлтэй өнгө төрх бүрдсэн юм.

Өнгөрсөн 10 гаруй жил И Тэ Бэ үзэсгэлэнд тасралтгүй оролцсон Монголын 7-8 аяллын компани бий. Энэ удаад 16 аяллын компани оролцсон бөгөөд тэдний хэлж байгаагаар энэ жил манай улс түнш орноор оролцож буйн хувьд



Монголын сурталчилгааны талбайг зорин ирж сонирхож буй хүмүүсийн тоо огцом өссөн төдийгүй хамтарч ажиллахаар шинэ түншүүд олноороо ханджээ. Өмнө нь компаниуд зөвхөн урьдаас уулзахаар цаг тохирсон гаднын аяллын компаниудтай л И Тэ Бэ дээр уулздаг байсан бол энэ жил цаг товлоогүй шинэ компаниудын төлөөлөл өөрсдөө хүрч ирэн уулзаж байгааг тэд хэлж байлаа. Мөн хуучин түншүүдийн хувьд Монголд итгэх итгэл батжиж, улам нэмэгдэж байгаагаа хэлж байсан гэв. “Жуулчин” компанийн Германы зах зээл хариуцсан менежер Г.Болор-Эрдэнэ “Хэдэн жилийн өмнө Австри, Швейцарьт очиж, компаниудтай уулзаж байхад төдийлэн нааштай хандахгүй байсан атлаа энэ жил өөрсдөө бидэнтэй ирж уулзаад гэрээний түвшинд ярилцаж буй нь Монгол Улс И Тэ Бэ-д хэр өргөн хүрээтэй оролцож байгаагийн илрэл юм. Бид тус үзэсгэлэнгийн үеэр нийт 58 компани, харилцагчидтай уулзсан. Үүний 21 нь хуучин харилцагч, 37 шинэ компани байна.” гэсэн юм.

**ЗАГАСНЫ ДЭГЭЭ БУС ЗАГАС
ӨӨРӨӨ АМТТАЙ БАЙХ ЁСТОЙ**

Энэ жилийн 49 дэх удаагийн И Тэ Бэ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 186 орны 175.000 хүн оролцсон нь өмнөх жилээсээ өссөн үзүүлэлт. Тус үзэсгэлэнд олонд нэртэй нийт 75 улсын 5180 сэтгүүлч, 29 орны 350 аяллын блогч оролцож, тус арга хэмжээг сурвалжилсан гэсэн тойм мэдээг И Тэ Бэ-гийн мониторингийн албанаас гаргаад байна. Тус үзэсгэлэнгийн үеэр хийгдсэн нийт мөнгөн гүйлгээ өнгөрсөн жилийнхээс өсч, 6.7 тэрбум еврод хүрчээ. Монголын хувьд энэхүү том хүрээллийг ашиглаж, өөрсдийгөө сурталчлах, аялал жуулчлалын салбарт чадавхтай тоглогч байж чадна гэдэг итгэлийг өгөхийг зорьсон. Тиймээс ч И Тэ Бэ-д чамлахааргүй мөнгө зарцуулж, албан ёсны түнш гэх байр сууриар гарч ирсэн билээ. Уг үзэсгэлэнд зарцуулсан мөнгө их мөнгө үү гэвэл “Тийм”. Гэхдээ хангалттай мөнгө байсан уу гэвэл “Үгүй”.

Анх Засгийн газраас И Тэ Бэ-д оролцохтой холбогдуулан төсөвлөсөн 18 тэрбум төгрөгийн төсөв эцэстээ 7.4 тэрбум болон буурч, түнш орны ажлын хэсгийнхэн хандивын арга

хэмжээ зохион байгуулж, 2.6 тэрбум төгрөгийг босгож, үйл ажиллагаандаа зарцуулсан. Үүний хүчинд ямартай ч нүүр улайхааргүй оролцоод л ирлээ. Гэхдээ төсөв мөнгөндөө уягдаагүй бол өөр олон сурталчилгааны дагалдах ажлуудыг хийж болох байсныг ажлын хэсгийнхэн хэлж байв.

Аялал жуулчлалын салбарт зарцуулсан дээрх мөнгөний үр дүн гарахгүй байх вий гэх нэг талаас айдас нөгөө талаас хардлага иргэдэд байна. Тус үзэсгэлэнд оролцсоны дараах жилээс жуулчдын тоог нэг сая, 2020 он гэхэд хоёр саяд хүргэх зорилтыг Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгасан байгааг БОНХАЖ-ын сайд Д.Оюунхорол хэлсэн. Энэ бол өнгөрсөн онд 5.9 хувийн бууралт амсаж, 392 мянган жуулчин хүлээн авсан манай улсын хувьд биелэхэд бэрх тоо. Үүнийг И Тэ Бэ-гийн хүчинд бодит болно гэж хүлээж байна. Салбарынхан ирэх жилийн хувьд жуулчдын тоо өсөх нь тодорхой гэж үзэж байна. Харин нэг саяд хүрнэ гэдэгт тийм ч итгэлтэй биш байгаа юм. “Цолмон Трэвел” компанийн ерөнхий захирал М.Навчаа “Монгол түнш орны байр сууриар оролцсон үр дүн энэ жилдээ бага мэдрэгдэж болох ч, ирэх жилүүдэд илүү сайн мэдэгдэнэ” гэсэн юм.

И Тэ Бэ үзэсгэлэнгийн үеэр ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Талиб Рифай БОНХАЖ-ын сайд Д.Оюунхоролтой уулзахдаа “Монгол И Тэ Бэ-д өндөр түвшинд оролцож, өндөр үнэлгээ, нэр хүнд олж авлаа. Гэвч энэ түвшиндээ хэрхэн удаан тогтох вэ гэдэг том сорилт танай улсад ирж байгаа. Энэ бол амжилтын ард гэтэж байдаг төлөөс нь” хэмээн хатуу сануулсан юм.

Улс орнууд энэхүү үзэсгэлэнд нэлээд их мөнгийг зарцуулж түнш орноор оролцдог. Хэдэн тэрбумаар нь мөнгө зарцуулж түнш орноор оролцчихоод 0 хувийн өгөөжтэй үлдсэн газрууд ч бий. Тиймээс л жинхэнэ ажил И Тэ Бэ үзэсгэлэнгийн дараа өрнөдөг гэдгийг аялал

ИНФОГРАФИК

Монгол Улс “ITB-Berlin 2015”-д албан ёсны түнш орноор оролцоход нийт **10** тэрбум төгрөг зарцуулж **41** ажил хийсэн. Үүний **7.4** тэрбумыг Засгийн газраас гаргасан. Түнш орны ажлын хэсгийнхэн хандивын шугамаар мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр **2.6** тэрбум төгрөгийг босгожээ. Монголчууд нэгдэж чадсан тус үзэсгэлэнгийн зардлын задаргааг инфографикаас сонирхоорой.

МӨНГӨН БУС ХЭЛБЭРЭЭР

1000



ширхэг олбог Монголын ноос, ноолуурын холбоо



1000 ш

Арьс ширний холбоо нэрийн хуудасны сав хандивласан



40 + 500 ш

“Говь” ХХК- VIP зочдын гарын бэлгэнд 500 ш ноолууран ороолт, 40 хүний ноолууран цамц хандивласан



40 ш

Торго салон үндэсний 40 хувцасыг түр хэрэглүүлсэн

20 ₮ сая



“Моннис” групп 20 сая төгрөг хандивласан



40 тн

“УБ ТЗ” 40 тоннын чингэлэгийг үнэгүй тээвэрлэсэн

85 ₮ сая

AIR



МИАТ ХК-85 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний онгоцны тасалбар, ачаа тээшний хөнгөлөлт үзүүлсэн

30 ₮ сая



АПУ ХК-30 сая төгрөг хандивласан

10.000\$



Голомт банк- 10.000\$ хандивласан мөн санхүүгийн үйлчилгээний хөнгөлөлт үзүүлсэн

15.000\$

AIR



“Turkish airlines” 15,000\$ тэнцэх онгоцны тасалбарыг хандивласан

ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ



700.000 €

Албан ёсны түншээр орох роялти төлбөр

203.000 €

26С талбайд босгосон сурталчилгааны талбайн өртөг

10.000 €

4.1 талбайд босгосон ХХК-сурталчилгааны талбайн өртөг

40.450 €

Талбайн түрээс нийт

160.000 €

3.600 хүний хүлээн авалтын зардал

180.000 €

Нээлтийн арга хэмжээний төсөв

380.000 €

Маркетингийн зардал нийт

жуулчлалын салбарын ахуууд монголчуудад зөвлөж байна. Аяллын сэтгүүлч, инженер Ди-Ролф монголчуудад хандан “Загасны дэгээ бус загас өөрөө амттай байх ёстой” хэмээн хэлсэн.

Хувийн хэвшлийнхний зүгээс Монголын бүх салбарт зонхилж буй тодорхойгүй байдал аялал жуулчлалд ч мөн том садаа болж буйг учирладаг. Онгоцны нислэгүүдийнх нь хуваарь жилээр байтугай хагас жилээр тодорхой гардаггүй. Нислэгийн хуваарь өөрчлөгдөх, цуцлагдах нь энгийн үзэгдэл болчихсон. Жил бүр болдог арга хэмжээнүүд нь тогтмол бус. Зарим жил зохиогдохгүй өнждөг эсвэл зогсдог гэхчлэн тодорхойгүй байдал, төрийн зохион байгуулалт дутаж буй жижиг асуудлууд хувийн хэвшлийнхэнд гаднын түншүүдтэй хамтарч ажиллахад ихээхэн төвөг болж буйг тэд хэлж байна. И Тэ Бэ-гээс бид “Итгэл” гэх том хөшүүргийг салбартаа авчирчихаад хөгжлөө түлхүүрдэх гээд байж байна. Гэвч үүнийгээ эргүүлээд алдах хэмжээнд хүргэх олон том жиг асуудал бидэнд байсаар байна. “Цолмон Трэвел” компанийн захирал М.Навчаа “Цэгцгүй байгаа асуудлуудыг цэгцэлж, нэгдсэн дүрэм журамд оруулан, салбарын оролцогчид нийлж том хөдлөхгүй бол жижиг, жижгээрээ хийх гэж оролдоод ямар ч бүтээмж бий болохгүй нь. Дэд бүтэц, хууль эрх зүйн асуудалд улс анхаар. Үүнээс цааш хэрхэн үйлчлэх асуудлыг хувийн хэвшил бид анхааралдаа авъя” хэмээн хэлж байна.

Монголчууд И Тэ Бэ дээр сайн,

сайхан байснаараа гайхагдаж, магтаалд ханатлаа бялуурчихаад ирсэн. Гэвч одоо ярьснаа ажил болгох цаг. Компаниуд харилцаа тогтоосон байгууллагуудтайгаа эргэж холбогдон, цааснаас амьдралд буулгах талаас шаргуу зүтгэж, засгийн газар, засгийн газрынхаа хэмжээнд аялал жуулчлалыг харилцан ашигтай хөгжүүлэх тал дээр ярилцсанаа ажил болгоход хүчлэх нь зүйтэй. “Дараагийн алхмууд юу байх вэ гэдгээ цаг хугацаатай нь сайн тодорхойлоод аваад явбал энэ бүхний үр дүн гарна. Үгүй аваас эргээд эхэлсэн цэгтээ очих эрсдэл бодитоор бий” гэж “World Tourism Forum Lucerne” байгууллагын дарга, профессор Мартин Барт хэлсэн юм.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Талиб Рифай Монгол Улсыг И Тэ Бэ үзэсгэлэн дээр гаргасан амжилтыг ажил хэрэг болгох тал дээр тусална гэдгээ амласан. Тиймээс хамтарч ажиллаж, тусалж болох дөрвөн бодитой санал байгааг Д.Оюунхорол сайдтай уулзах үеэрээ хэлсэн. Үүнд дэлхий даяар Монголын имижийг илүү сайн таниулах, адал явдалт аялал жуулчлалын чиглэлээр олон улсын томоохон форумыг Монголд зохион байгуулах, хууль зүйн хүрээнд аялал жуулчлалын салбарыг илүү нарийвчлахад туслах, мөн хөрөнгө оруулалт татахад хялбар болгох, эцэст нь хүний нөөцийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд тусалж, дадлагажуулах гэсэн. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага өмнө нь Монгол Улстай хамтарч ажилладаг

байсан ч хэзээ ч ингэж дорвитой томоохон саналуудын хүрээнд санаачилга гаргаж байгаагүй юм.

Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд нийлээд аялал жуулчлалыг хөгжүүлэх эхлэлийг сайн тавьж чадсан. Одоо хувийн хэвшлийнхэн ур чадвараа нэмэгдүүлж, дагнасан мэргэжлийн зах зээлүүд рүү орж ажиллах шаардлага бий. “Компаниудын хувьд дэлхийд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн мэдлэгээрээ мэргэжлийн хурал, чуулган дээр илтгэл тавьж мэргэжлийн салбарын түвшинд маркетинг хийх хэрэгтэй байна.” гэж Аялал жуулчлал-Ирээдүй” ТББ-ын захирал Б.Индраа хэлж байна. Мөн И Тэ Бэ-д оролцох хүрээнд зарлалын самбар, баннер гэх мэт төлбөр өндөртэй маркетингийн аргыг бид ашигласан бол ирэх жилээс энэ хүчээ сааруулахгүйгээр цахим ертөнц тэр дундаа нийгмийн сүлжээгээр маркетингаа хийх хэрэгтэй байгааг тэрбээр мөн онцолсон юм.

Бид Монгол улсын аялал жуулчлалын салбарын онцлог давуу талыг чамгүй түвшинд таниулан, олон улсаас өндөр оноо авч, итгэлийг нь өвөртлөөд ирлээ. Гэхдээ тэр итгэлийг даах сайн менежмент одоогоор салбарын хувьд байхгүй. Бид өндөрт гарсан ч тулах баганагүй байгаа нь тус салбар хэзээд унахад бэлэн, хэврэг гэдгийг харуулж буй. Хэврэг байдлаа дархалж чадахгүй аваас И Тэ Бэ үзэсгэлэнд оролцсон нөр хөдөлмөр, оруулсан хөрөнгө оруулалт, цаг хугацаа, гаргасан амжилт ахархан хугацаанд замхрах эрсдэл бодитоор оршиж буй. ■



И ТЭ БЭ

Үзэсгэлэнгийн сүүлийн өдөр төгсгөл бус эхлэл байх учиртай



Дэлхийн хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн болох “International Tourism Boerse-2015”-д Монгол Улс энэ жил албан ёсны түнш орноор оролцсон учир “Mongolian Economy” сэтгүүл Берлиний зорьсон юм. Бид энэхүү үзэсгэлэнг сурвалжлах үеэр “ITB Berlin”/И Тэ Бэ-Герман дуудлага нь/ үзэсгэлэнгийн захирал Дэвид Рүүтстэй ярилцлаа. Тэрбээр И Тэ Бэ-гийн бүрэлдэхүүнд 2001 оноос эхлэн ажиллажээ.

-И Тэ Бэ үзэсгэлэнгийн энэ жилийн гүйцэтгэлийн тайланг харахад олон амжилтуудаа шинэчлэн тогтоожээ. Таны хувьд ямар амжилтаа илүү тодотгох вэ ?

-Бид оролцогчдынхоо тоогоор илт өндөр үзүүлттэй дэлхий дээрх ганц үзэсгэлэн. Чухамдаа, гаднын

зочид нийт оролцогчдын 75 орчим хувийг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ манайх хамгийн олон гадаад худалдан авагчидтай үзэсгэлэн. Энэ жил уг үзүүлэлт 40-43 хувь болтлоо өссөн нь дээд амжилт. Энэ жилийн тайлангаас үзэхэд 115,000 мянган худалдан авагч, 175,000 зочид ирсэн байна. “Messe Berlin”-ий гаргасан тооцоогоор үзэсгэлэнг дагаж хийгдсэн нийт, худалдаа борлуулалт 2015 онд өнгөрсөн жилийн 6.5 тэрбум еврогоос 6.7 болтлоо өссөн байна. Тэгэхээр манай үзэсгэлэн зөвхөн аялал жуулчлалын салбарын томоохон цугларалт төдийгүй бизнесүүдийн төвлөрөлийг бий болгож чадаж байна. Нэгдүгээрт, та өөрийн төлөвлөөгүй олон зүйлийг харж, хийх болдог. Хоёрдугаарт, Берлинд аялал жуулчлалын бүх л

хүрээнийхэн нэг дор цугладаг. Нийт 170.000 ам.дөрвөлжин талбай бүхий 26 танхимаар дамжуулан аялал жуулчлалын шинэ технологи, зочид буудал, агаарын тээвэр, сувилал, амралтын газартай танилцаж дэлхийн бүх улсыг нэг дор үзэж болно. Үзэсгэлэнд оролцогчид И Тэ Бэ-гийн үеэр бизнес уулзалтуудаа хийхийн тулд өдөрт дунджаар 14 километр алхдаг гэх судалгаа бий. Гуравдугаарт, түншүүдтэйгээ илүү ойр харилцааг үүсгэх боломж олгодог. Мэдээж хэрэг бид бүгд интернэт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр харилцаж ажлаа амжуулдаг. Гэвч амьд харилцааг үүсгэнэ гэдэг ямар ч өөр сувгуудаас илүү онцгой зарах урлаг.

-Энэ арга хэмжээ Герман тэр дундаа Берлиний эдийн засагт хэрхэн нөлөөлж байна вэ? Миний ажигласнаар бол энэ үеэр Берлинд зочид буудлын өрөө олж авна гэдэг хүнд асуудал болчихдог бололтой.

-Ер нь бол Берлиний зочид буудлууд энэ тав хоногийн турш нэг хоногт л гэхэд 11 сая еврогийн орлого олж байна. Үзэсгэлэнг зорьж ирсэн зочид хамгийн их мөнгө үрж байгаа нь мэдээж. Тэд таксинд сууж, нисэх буудал, зоогийн газруудаар үйлчлүүлж, дэлгүүр хэсч, хотын аялал хийж буй. Үүний зэрэгцээ “Messe Berlin” үзэсгэлэнгийн цогцолбор эдгээр өдрүүдэд 25.000 ажлын байрыг бий болгодог. Өргөн хүрээнд авч үзвэл, Герман улс ойролцоогоор 300 сая еврогийн нэмэлт орлогыг татвар болон бусад сувгаар И Тэ Бэ үзэсгэлэнгээс хүртдэг. Энэхүү үзэсгэлэнг Берлиний хотын захиргаа удирддаг юм. Бид Берлин хотын үйл ажиллагааны нэг хэсэг учир Монгол Улс албан ёсны хамтрагчаар оролцож буй энэ үзэсгэлэнд олон улсын нэр нөлөө бүхий эрх мэдэлтнүүд, улс төрийн томоохон удирдагчдыг урин ирүүлж чадаж байгаа.

-Түнш орноор сонгох

боломжтой олон сайхан улс байхад яагаад энэ удаад заавал Монгол Улсыг сонгосон юм бэ?

Нэгдүгээрт, бид энэ шийдэлд хүрэхийн тулд доод тал нь 4-5 жил төр, хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажилласан. Бидний хувьд найдвартай түнш олох нь их чухал. Бид тэр түншээ Монголоос олсон. Хоёрдугаарт, бид Монголын ирээдүйн бололцоог олж харсан. Түнш орноор өндөр хөгжсөн улс сонгогдоно гэдэг зоосны нөгөө тал гэсэн үг. Тэд зөвхөн өөрсдийн шинэ зочид буудал эсвэл өөр ямар нэг зүйл үзүүлнэ. Учир нь, тус улс аль хэдийнэ танигдчихсан, хүмүүст ихэнх зүйл нь ойлгомжтой байдаг. Тэгэхээр хүмүүс “Би энэ газрыг мэдэх юм чинь дээ” гэж хэлдэг. Харин өнөөдөр танай улс түнш орноор сонгогдсоны хүчинд өрнөсөн үйл явдал биднийг их баярлууллаа. Олон улсын хэвлэл мэдээллийнхэн Монголын талаар мэдээлэл багатай учир хоорондоо уралдан асууж шалгаан, мэдээлэл авахыг хичээж, илүү олон талаас тэр дундаа танигдаагүй тэр л өнцгөөс сурвалжлан хүргэхийг чармайж байв. Монголыг сонгосон гурав дахь шалтгаан нь Монголд байгаа тэр асар их нөөц бололцоог олж харсан нь юм. Жуулчдад төдийлэн сайн танигдаагүй учир Монгол нь онцгойлон зорих газарт тооцогдож байгаа. Барууныханд ялангуяа орчин үеийн техник технологийн хор нөлөө, стрессээс ангижирдаг аяллын цэг болно гэж харж байна.

-Жуулчдын Монголыг сонирхох хандлагад хийсэн гаднын судалгааг та бүхэн түнш орны тухай хэвлэлийн бага хурал дээр дурьдаж байсан. Энэ судалгааны үр дүнг танилцуулахгүй юу?

Тиймээ. Германы Аялал жуулчлалын судалгааны институт саяхан нэг судалгаа гаргасан. Өнгөрсөн оноос энэ оны өдийг хүртэлх хугацаанд Монголыг аялах газар гэж мэддэг болсон, сонирхож эхэлсэн германчуудын тоо бараг тэгээс 4.3 хувь болтлоо өссөн. Энэ нь гурван сая герман хүн гэсэн үг. Үүнээс 150.000 нь ирэх гурван жилд Монгол руу аялах төлөвлөгөө аль хэдийнэ гаргасан гэж байгаа. Эдгээр 150.000 жуулчдын ихэнх нь 40-өөс доош насны хүмүүс байгаа бөгөөд энэ нь Монголын хувийн хэвшлийнхэнд сонирхолтой бөгөөд хэрэгтэй мэдээлэл юм. Яагаад гэвэл тэд одоо

өөрсдийн хүлээн авах зочдоо 40-өөс доош насны идэвхтэй залуус гэдгийг мэдэж авлаа. Эдгээр хүмүүст олон төрлийн сонирхол байж болох ч бас хэт тансаг зэрэглэлийн үйлчилгээг илүүд үздэг хүмүүс биш. Харин тэд социал сүлжээ болон интернэт маш сайн ашигладаг. Энэ бол орхигдуулж болохгүй маркетингийн чухал мэдээлэл. Үүнтэй нийцүүлэн Монголын аялал жуулчлалын салбарынхан бүтээгдэхүүн үйлчилгээгээ боловсруулж болох юм.

-Монголын ямар талууд залуу жуулчдын сонирхлыг илүү татаж байна вэ? Манай орныг илүү адал явдалт аялал хийхэд тохирсон газар гэж хараад байна уу?

-Адал явдалт аялал жуулчлал гэх талаас түлхүү хамааралтай биш байх. 40 наснаас доош гэдэг нь бас 39 настай хүмүүс энэ ангилалд багтаж байгаа гэсэн үг. Тиймээс бүгд залуус гэж ойлгож болохгүй. Тухайлбал, энэ насны хүн аль хэдийнэ амьдрал, ажлаа төвхнүүлчихсэн бизнес эрхлэгч байж болно. Энэ үеийн хүмүүс дэлхийн олон орноор аялаад үзчихсэн хүмүүс байх нь элбэг учир тэд одоо илүү содон сонин газруудыг үзэхийг хүсч байдаг. Тэдний үзэхийг хүсч байгаа зүйл бол өдөр тутмын амьдралаас нь тэс ондоо тэр орчин нөхцөл. Ингэх нь нэг талаар тэдэнд стрессээ тайлах боломжийг олгодог. Мөн тэд урьд өмнө нь сонсож, харж байсан ч биеэрээ дунд нь орж, мэдэрч байгаагүй тийм соёл заншилтай танилцахыг хүсэж байгаа. Миний Монгол руу аялсан туршлагаас харахад Монголын хаана ч хүмүүс нь нээлттэй, зочломтгой байдаг юм билээ. Би Азийн олон орноор аялж байсан. Харин Монголд тэс өөр мэдрэмжийг авсан учир надад ердөө ч Азид байгаа мэт санагдаагүй. Азийн соёл ерөнхийдөө бага зэрэг хаагдмал заримдаа ичимхий гэж тодорхойлж болмоор. Харин Монголын хувьд нээлттэй, шулуухан байдаг нь нэг талаас европуудтай төстэй санагдсан. Тийм учраас барууны жуулчид Монгол руу аялах нь илүү тохиромжтой юм болов уу.

-Олон хүн Монголын зохион байгуулсан нээлтийн ажиллагаанд сэтгэл хангалуун байх шиг санагдсан. Таны хувьд нээлтийн ёслол ямар байсан бэ? Монгол албан ёсны түншийн хувьд олгогдсон боломжуудаа бүрэн ашиглаж чадсан болов уу?

-Бид “Аялал жуулчлалын ирээдүй” ТББ болон бусад хүнтэй нээлтийн ажиллагааг зохион байгуулахад хамтран ажилласан. Энэ нээлтийн ёслол миний И Тэ Бэ үзэсгэлэн дээр үзэж байсан шилдэг үзүүлбэрүүдийн нэг нь. Учир нь энэ нээлтийн арга хэмжээ хүмүүсийн төсөөлж байснаас тэс ондоо байсан. Хүмүүс Азийн орнуудын нийтлэг дуу хөгжмийн өнгө аясыг хүлээж байсан. Харин эртний түүхтэй энэ жижиг орон санаанд багтамгүй өргөн хүрээнд маш хүчтэйгээр өөрийгөө илэрхийлж чадлаа. Мөн Монгол олон улсын хэмжээний урлагийн одуудтай гэдгийг энэхүү гала тоглолтоор харуулж чадлаа. Энэ бол зөв үйлдэл. Монголчууд цөөхүүлээ ч дэлхийн өнцөг булан бүрт авьяас чадлаа гайхуулан амьдарч яваа гэдгээ аялал жуулчлалын салбарын томоохон 4000 төр хувийн хэвшлийн төлөөлөлд мэдүүлсэн. Монгол талын зохион байгуулагчдын хамтаар бид монголчуудад нөлөө бүхий гадныхантай уулзах, харилцаа тогтоох зэрэг олон боломжийг олгосон. Би хувьдаа Монголыг боломжоо сайн ашигласан гэж үзэж байгаа. Гэхдээ И Тэ Бэ үзэсгэлэнгийн сүүлийн өдөр төгсгөл биш харин эхлэл байх ёстой гэдгийг хэлье. Өнөөдөр олж авсан боломжуудаа ирэх 24 сарын хугацаанд жинхэнэ ажил болгож, үр шимийг нь үзэх хэрэгтэй. Энэ бол та бүхэнд үлдэж буй том шалгуур. И Тэ Бэгийнхэн бид Монголын аялал жуулчлалын салбарыг нялх хүүхэд шиг байнга асарч тусалж чадахгүй шүү дээ. Бидний үүрэг бол бол замыг чинь зааж, чиглүүлэх. Бид зөвлөгөө өгөхдөө хэзээд баяртай байх болно. Бид үүргээ гүйцэтгэсэн, одоо та бүхэн үргэлжлүүлээд аваад явах хэрэгтэй. Үр дүнд хүрэхийн тулд холбоо тогтоосон хүмүүстэйгээ үргэлжлүүлэн харилц, хэвлэл мэдээллийнхэнтэй холбоотой бай. Бидний цуглуулсан мэдээлэл, сурталчилгааг бүтээгдэхүүн үйлчилгээгээ боловсруулахдаа ашигла. Цаашид 40-өөс доогуур насны хэрэглэгчдийн зах зээлийг илүү тулж ажиллах уу, илүү социал сүлжээг ашиглаж маркетингаа хийх үү гэх зэргийг тунгаа. Энэ удаагийн үйл ажиллагаанд томоохон үүрэг гүйцэтгэсэн талууд болох Засгийн газар, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд



ITB Berlin 2015- Түнш орноор оролцсон Монголыг танилцуулах хэвлэлийн бага хурал И Тэ Бэ үзэсгэлэнгийн захирал Дэвид Рүүтс, И Тэ Бэ үзэсгэлэнгийн хэвлэлийн ажилтан Астрид Занд, "Аялал жуулчлал-Ирээдүй" ТББ-ын төслийн менежер Б.Эрдэнэчимэг, Германд суугаа Монголын Элчин сайд Ц.Болор, Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар, логистикийн төвийн дэд ерөнхийлөгч Мартин Бак

хамт суугаад хийсэн бүтээснээ ярилцан, тайлагнаж, ирэх 24 сарын төлөвлөгөөгөө боловсруулна гэж найдаж байна.

-Монголын аялал жуулчлалын компаниуд урьд жилүүдээс илүү олон гэрээ хийсэн учир нэлээд сэтгэл хангалуун байх шиг байна. Танд энэ жилийн И Тэ Бэ-гийн үеэр хийгдсэн бизнес хэлэлцээрүүдийн талаар мэдээлэл бий юу?

-Бидний үйл ажиллагаа анх дөрвөн тэрбум еврогийн гүйлгээтэйгээр эхэлж байсан. Өмнөх жил 6.5 тэрбум евро байсан бол энэ жил 6.7 тэрбум евро байлаа. Өөрөөр хэлбэл И Тэ Бэ-г дагаж ийм хэмжээний мөнгөн гүйлгээ хийгдэж байна гэсэн үг. Энэ үзүүлэлт тогтвортой өсч байгаа. Оролцогч бүр бизнесийнхээ талаар бүх мэдээллээ дэлгэрэнгүй хуваалцаад байдаггүй. Ерөнхийдөө ирсэн зочдын 80 хувь нь И Тэ Бэ-гээс эерэг хүлээлттэй буцдаг. Харин одоо тулгарах сорилт бол И Тэ Бэ дээр олсон боломжит хамтрагчиддаа борлуулалт хийж чадах эсэх юм. Статистикээс харахад үзэсгэлэнгийн үеэр харилцаа тогтоож чадсан түншүүдийнхээ 50 хувийг алдаж, мөнгөө салхинд хийсгэж байгаа нь олж авсан боломжуудынхаа араас зөв аргаар тууштай явж чадаагүйтэй холбоотой байдаг. Үзэсгэлэнгийн дараах тайлангийн хурал дээр тавигдах эхний асуулт нь холбоо тогтоосон түншүүдтэйгээ эргэж холбоо барьсан уу гэдэг байх ёстой. Энэхүү үйл ажиллагааг ирэх зургаан

сар, 24 сард үргэлжүүлэх хэрэгтэй. Бид мөн өргөн хүрээнд хэвлэл мэдээллийнхний анхаарлыг татаж өглөө. Мөнгөн дүнгээр тооцвол 30 сая евротой дүйцэхүйц 570 сая хэвлэл мэдээллийнхэнтэй холбож, тэдний анхаарлыг та нар дээр татаж авчирч чадлаа. Энэ бол барагтаа худалдаж авч дийлдэг багц биш шүү. Иймээс одоогийн олсон амжилтаа хадгалж, галаа унтраахгүй байх хэрэгтэй.

И Тэ Бэ-г хэвлэл мэдээллийнхэн хэр өргөн цар хүрээнд сурвалжилдаг вэ?

-И Тэ Бэ-г 75 орны 5180 магадлан итгэмжлэгдсэн сэтгүүлчид болон 29 улсын 350 блогч сурвалжилж, мэдээлсэн. Үүний 1500-2000 сэтгүүлчид нь гаднаас ирсэн. Мөн бид блогчдод илүү ээлттэй байдлаар ажиллаад гурван жил өнгөрч байна. Бид тэднээс хамгийн анхаарал татсан, шилдгүүдийг нь сонгодог. Өргөн хүрээг хамарч чадах блогчдыг оролцуулахыг бид хүсдэг. Анх 200 блогчтой эхэлж байсан бол өнөөдөр 29 орны 350 болсон байна. Энэ нь олон улсад хэвлэл мэдээллийг өргөн хүрээнд хүргэж чаддагийн баталгаа болов уу. Нийтлэлийн хувьд ярьвал, зөвхөн Германд л гэхэд 12.000 нийтлэл И Тэ Бэгийн тухай гарсан байдаг. Харин дэлхий даяар цахимаар гэхэд ойролцоогоор 13-14 мянган материал нийтлэгдсэн байдаг.

-Монгол аялал жуулчлалын салбараа энэхүү арга хэмжээний дараа хэрхэн дэмжиж авч явах тал

даар Та юу гэж зөвлөх вэ?

-Би монголчуудад энд уулзсан хувь хүн, аж ахуй нэгжүүдтэйгээ тогтоосон харилцаа холбоо, хийсэн гэрээнүүдээ үргэлжлүүлэхийг зөвлөсөөр байгаа. Улс төр, хэвлэл мэдээлэл, холбоодын түвшинд олон гэрээ хэлэлцээр хийж, харилцаа тогтоосон гэдэгт чинь итгэлтэй байна. Хэрвээ эдгээр харилцаануудаа авч үлдэж чадвал амжилтаа үргэлжлүүлэх боломжтой. Хөл бөмбөгийн тэмцээнтэй зүйрлэвэл, Монгол өнөөдөр дэлхийн томоохон тоглогчдын тоглоомонд ороод ирчихлээ. Одоо хасагдахгүйг хичээх хэрэгтэй. Бөмбөгөө өшиглөөд гүйгээд бай, бүү зогс. Салбарын бүх нөлөө бүхий оролцогчдод өөрсдийнхөө талаар мэдээллийг өгөөд л байх хэрэгтэй. Мөн зөв маркетингийн багтай байж, хуулийн хүрээнд хийж буй шинэчлэлүүдийг үргэлжлүүл. Шинэ аяллын компаниудтай холбоогоо өргөтгөж, шинэ үйлчлүүлэгчдийг олох хэрэгтэй. Хэрвээ та нууц жор асууж байгаа бол надад байхгүй. Миний хэлэх зүйл бол бид энд чадах бүхнээ хийсэн. Одоо та бүхний ажил үлдлээ гэх байна.

-Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага хаашаа чиглэж байна вэ?

-Одоогийн байдлаар 1.1 тэрбум жуулчид дэлхий даяар аялж буй нь дотооддоо аялж байгаагаас долоо дахин өндөр байна. Одоогийн дэлхийн ДНБ-ий өсөлт эдийн засгийн байдлаас үл хамааран аяллууд илүү

цөөн хоногтой болох хандлагатай байна. Тиймээс үүнтэй уялдаад аялалд илүү олон зүйлийг багтаасан үр өгөөтэй байх шаардлага бий болж буй. Үүнийг дагаад мөн онцгой зүйлийг хүсэгчид ихэснэ гэсэн үг юм. Аялал жуулчлалын салбарынхан эдгээр хүмүүсийн хүсэл, хэрэгцээг хангах тал дээр ажиллаж, богино хугацаанд хэрхэн онцгой мэдрэмжийг төрүүлэхүйц аялал зохион байгуулах вэ гэдэг дээр ажиллах хэрэг гарч байна.

Мөн технологийн хөгжил аялал жуулчлалд ч мөн олон дэвшил, өөрчлөлт авчирч байна. Бид аппликэйшн буюу гар утасны хэрэглээний программууд интернэтийн шинэ ирээдүй гэдгийг мэдэрч эхэлж байна. Тиймээс аялал жуулчлалын салбарынхан ч энэ өөрчлөлтийг үйл ажиллагаандаа илүүтэй тусгаж эхлэх шаардлага үүснэ гэдгийг мэдэж, ажиллах хэрэгтэй юм. Мөн орнууд зөвхөн бизнес эдийн засгаа нэг, нэгэнтэйгээ хуваалцахаас гадна мэдээллээ хуваалцаж буй үзэгдэл том хүчин зүйл болж байна. Хүмүүс зорчсон газрынхаа талаар бусадтайгаа хуваалцан, блог дээрээ бичиж, твиттерт жиргэж, фейсбүүкээр постлож байна. Ингэснээр бусад хүмүүс тэр газарлуу улам их зорчих болно. Ийм ч учраас бид И Тэ Бэ үзэсгэлэн дээр блогчдыг оролцуулдаг. Мөн тэднийг болон хүлээн авагч улсуудын төлөөлөл хооронд мянга гаруй уулзалт зохион байгуулсан. Бид мэдээж хэрэг сонгодог хэвлэл мэдээлэллийн арга барилыг хуучирсан гээгүй л дээ. Тэдэнтэй нягт хамтарч ажилласан хэвээр байгаа. Гэхдээ өнөө үед блог, олон нийтийн сүлжээ нь мэдээлэл түгээх тал дээр том үүрэг гүйцэтгэх болсныг ажрахгүй өнгөрөөж болохгүй юм. Бид энэхүү өөрчлөлттэй уялдаж ажиллах хэрэгтэй. Эцэст нь хэлэхэд, аялал жуулчлал хүмүүс биднийг бие биенээ ойлгоход туслах гүүр нь болсоор ирсэн, болсоор ч байх болно. Учир нь, дэлхийн бусад орноор очиж үзээгүй бол бид бие биенээ ийм сайн, ийм ойр мэдэхгүй, ойлгохгүй байх байсан.

Ярилцлагын төсгөлд Дэвид Рүүтс манай улсад зочлохдоо сурсан ерөөлөө монгол хэлээр хэлэхийг хүссэнийг уншигч та бүхэнд уламжилж байна. “Монгол Улс мандан бадраа” ■



HAVE TAPAS FOR DINNER

EVERY FRIDAY 18:00 — 22:00



CONTACT US: 70100505
86095565



РЕЙТИНГ

Монгол Улсын ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ахиулах нь



Л.Бямбаа /Хөрөнгө оруулалт, санхүүгийн судалгаа ТББ, хөрөнгө оруулалтын компанийн захирал/

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Улс орон, компани, банк, санхүүгийн байгууллага зэргийн зээлжих чадварыг үнэлэн тогтоодог олон аргачлал, байгууллага байдаг бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гурван агентлаг нь Standard and Poors (S&P), Fitch, Moody's юм. Эдгээрээс оноосон зэрэглэл нь тухайн улсын эрсдэлийг илэрхийлэх бөгөөд үүнийг тогтоохдоо тухайн улсын улс төр, эдийн засаг, төсөв санхүү гээд олон хүчин зүйлийг нарийн судлан гаргадаг.

Зээлжих зэрэглэлийг ийнхүү тогтоох нь юуны өмнө хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, баялгийн сан зэрэг томоохон институционал хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь тус болдог. Зээлжих зэрэглэл сайн, өндөр байх тусам тухайн улс, компанийн зээлжих чадвар сайн, эрсдэл бага гэж тооцогдох тул зээлийн хүү буурдаг. Ирээдүйд уул уурхай, бүтээн байгуулалтын том хэмжээний олон төсөл хэрэгжих тул зээлжих зэрэглэлээ сайжруулахад одооноос анхаарвал хүүгийн зардлаас их хэмжээний мөнгө хэмнэгдэх боломжтой. Мөн компани, санхүүгийн байгууллагын зээлжих зэрэглэл нь тухайн улсын зээлжих зэрэглэлээс өндөр тогтоогдох боломж хомс байдаг учир улсын зэрэглэл доогуур байгаа тохиолдолд тухайн улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх талуудад сөрөг нөлөөтэй гэж ойлгож болно.

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХОД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛС

Бүх шатны санхүүжилтийн зардалд ийнхүү хүчтэй нөлөөлж байгаа зээлжих зэрэглэлээ ахиулахын тулд зэрэглэл тогтооход ямар хүчин зүйлсийг харгалзан үздэг вэ гэдгийг сайтар ойлгох ёстой. Жишээлбэл, S&P дараах таван чиглэлээр дүн шинжилгээ хийж үзсэний үндсэн дээр улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ олгодог. **Үүнд:**

Бусад агентлагууд ч ижил төстэй аргачлал ашигладаг бөгөөд дээрх таван чиглэлээр дүн шинжилгээ хийж үзүүлэлт тус бүрийг хэрхэн сайжруулах талаар тусгайлан анхаарч ажиллах боломжтой.

Хүснэгт №1. Урт хугацааны зээлжих зэрэглэлийн ангилал

Moody's	S&P	Fitch	Тайлбар
Aaa	AAA	AAA	Дээд
Aa1	AA+	AA+	нд р
Aa2	AA	AA	
Aa3	AA-	AA-	
A1	A+	A+	Дундын дээд
A2	A	A	
A3	A-	A-	
Baa1	BBB+	BBB+	Дундын доод
Baa2	BBB	BBB	
Baa3	BBB-	BBB-	
Ba1	BB+	BB+	Х р нг оруулалтын бус
Ba2	BB	BB	
Ba3	BB-	BB-	
B1	B+	B+	Х р нг оруулалтын бус, эрсдэлтэй
B2	B	B	
B3	B-	B-	
Caа1	CCC+	CCC	Эрсдэлтэй
Caа2	CCC		Хэт эрсдэлтэй
Caа3	CCC-		Зээлжих чадварг й, гэхдээ сэргэх бага зэргийн магадлалтай
Ca	CC		
	C		
C	D	DDD	Зээлжих чадварг й

Эх сурвалж: Холбогдох агентлагууд

Хүснэгт №2. Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлс

№	Х чин з йл	Тайлбар
1	Улс т рийн байдал	• Бодлого боловсруулах йл явц, улс т рийн байгууллагын р н л , тогтвортой байдал • Байгууллагуудын, тухайлбал статистикийн газрын тоо баримт, мэдээллийн л тод байдал, хариуцлага х лээх тогтолцоо
2	Эдийн засгийн байдал	• Орлогын твшин • Ирээд йн с лт • Эдийн засгийн т р лжилт, савалгаа
3	Гадаад орчин	• Эдэсний м нг н тэмдэгт олон улсын хэмжээнд х рв х байдал • Гадаад валютын н ц • Гадаад р
4	Т свийн байдал	• Т свийн алдагдал • рийн дарамт
5	М нг ний зах зээл	• М нг ний бодлогын р н л тэй байдал • М нг ний бодлого зах зээлд н л л х чадвар буюу санх гийн болон х р нгийн зах зээлийн х гжил

Эх сурвалж: S&P, Sovereign Government Rating Methodology And Assumptions, 2011

МОНГОЛЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Монгол Улсын зэрэглэлийг одоогийн байдлаар S&P BB-, Fitch B+, Монголын Засгийн газрын бондын үнэлгээг Moody's B1 гэж тогтоосон нь бүгд хөрөнгө оруулалтын бус буюу эрсдэлтэй ангилалд хамаарч байгаа юм. Бангладеш, Иордани, Македони, Вьетнам зэрэг улс адил зэрэглэлтэй байна.

2014 оны тавдугаар сард Moody's агентлагаас Монголын Засгийн газрын бондын үнэлгээний төлөвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан. Уг шийдвэртэй холбоотойгоор тус агентлагийн зүгээс Монголын Засгийн газрын эзэмшлийн Хөгжлийн банкны зэрэглэлийн ирээдүйн төлөвийг тогтвортойгоос сөрөг болгон бууруулсан. Монгол Улсын Хөгжлийн банкны өр төлбөрт Монголын Засгийн газрын баталгаа гаргасан байдаг тул банкны өрийн бичгийн зэрэглэл

нь Засгийн газрынхтай адилхан түвшинд тогтоогддог.

Тухайн үед Монгол Улсын дотоод валютын урт хугацаат эрсдэлийн түвшин Ва3 зэрэглэлд тогтоогдсон бол урт хугацаат гадаад валютын бонд Ва3, банкуудын хадгаламжийн зэрэглэлийг Ва3 болон В2 гэсэн зэрэглэлээр тус тус үнэлжээ. Мөн гадаад валютын богино хугацаат өр болон хадгаламжийн үнэлгээг not prime буюу төлбөрийн чадвар сул гэсэн ангилалд оруулсан байдаг. Эдгээр ангилал нь тухайн улс орны хуулийн этгээдэд олгож болох гадаад болон дотоодын валютын тухайд оноох хамгийн дээд зэрэглэлийг илтгэдэг болно.

Moody's-н зүгээс Монголын ирээдүйн төлөвийг бууруулсан нь сүүлийн жилүүдэд улсын гадаад өрийн хэмжээ их хэмжээгээр нэмэгдэж, гадаад валютын албан нөөц буурсан, 2013 оноос хойш зээлийн өсөлтийн хэмжээ нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна. Эдгээр хүндрэл нь ирэх хэдэн жилийн хугацаанд валютын ханшийн болон гадаад өрийн хямрал болох эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж үзсэн. Үүний зэрэгцээ инфляци өндөр, зээл нэмэгдэж байсан нь банкны системийн тогтвортой байдлыг сулруулж төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй байгаа нь уул уурхайн салбараас их хэмжээгээр хараат болох улсын гадаад позиц болон төсвийн асуудалд томоохон эрсдэл учруулж байна гэж дүгнэсэн байна.

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭРХЭН НЭМЭГДҮҮЛЭХ

ВВ- зэрэглэлтэйгээр Засгийн газар жилийн 5.75 хувийн хүүтэй эх үүсвэр татаж чадаж байсан нь нэг талаар сайн боловч нөгөө талаар хүүгийн зардал маш өндөр байгаа. Санхүүжилтийн зардлыг хэтдээ өсгөхгүй байх, эсрэгээр бууруулах цорын ганц боломж бол зээлжих зэрэглэлээ сайжруулах явдал.

Зэрэглэлийг нэг, хоёр шат ахиулж чадвал “хөрөнгө оруулалтын” ангилалд Монгол багтах бөгөөд орж ирэх мөнгөн дүн огцом нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гадаадын санхүүгийн байгууллага, тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сангуудын

Хүснэгт №3. Зээлжих зэрэглэлийг ахиулах арга зам

№	Х чин з йл	Тайлбар	Авах арга хэмжээ
1	Улс т рийн байдал	<ul style="list-style-type: none"> Бодлого боловсруулах йл явц, улс т рийн байгууллагын р н л , тогтвортой байдал Байгууллагуудын, тухайлбал статистикийн газрын тоо баримт, мэдээллийн л тод байдал, хариуцлага х лээх тогтолцоо 	<ul style="list-style-type: none"> Улс т рийн тогтвортой байдлыг хангах Байгууллагуудын ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах Бодлогын савалгааг бууруулах, залгамж чанарыг хадгалах
2	Эдийн засгийн байдал	<ul style="list-style-type: none"> Орлогын т вшин Ирээд йн с лт Эдийн засгийн т р лжилт, савалгаа 	<ul style="list-style-type: none"> Монголын эдийн засгийн суурь з лэлтийг сайжруулах с лтийг хадгалах, нэмэгд лэх Т р лжилтийг хангах
3	Гадаад орчин	<ul style="list-style-type: none"> ндэсний м нг н тэмдэгт олон улсын хэмжээнд х рв х байдал Гадаад валютын н ц Гадаад р 	<ul style="list-style-type: none"> Х р нг оруулалтын орчныг тогтвортой байлгах Гадаад валютын албан н цийг нэмэгд лэх Х р нг оруулалтын т сл дэд анхаарах
4	Т свийн байдал	<ul style="list-style-type: none"> Т свийн алдагдал рийн дарамт 	<ul style="list-style-type: none"> Улсын р 2009 оноос хойш огцом нэмэгдсэн. Гадаад валютаар зээл нийт улсын р т лб рт эзлэх хувь нд р байгаа нь цаашид дотоод валют сулрахад Монголын хувьд эргэн т л лт дээр х ндрэл учруулах эрсдэлийг тооцож бууруулах Т свийн гадуур зарцуулалт болон х р нг оруулалт нд р байгаа нь т свийн тогтвортой байдлын тухай хуулийн р д нг сулруулж байгааг засах Х р нгийн гадагшлах урсгалыг бууруулж, т лб рийн тэнцэл улам муудахаас сэргийлэх
5	М нг ний зах зээл	<ul style="list-style-type: none"> М нг ний бодлогын р н л тэй байдал М нг ний бодлого зах зээлд н л л х чадвар буюу санх гийн болон х р нгийн зах зээлийн х гжил 	<ul style="list-style-type: none"> Т вбанкны бодлогын р н л тэй байдлыг сайжруулах Санх гийн салбарын тэнцвэртэй байдлыг хангах Х р нгийн зах зээлийн х гжилд анхаарах

хөрөнгө оруулалтын бодлогод зээлжих зэрэглэлийн заалт, мөн нэг улсад хуваарилах хязгаарлалтууд орсон байдаг. Хэрэв Монгол өөрийн зэрэглэлээ сайжруулж чадвал дээрх сангуудаас автоматаар хуваарилалт хийгдэх боломжтой болно. Нөгөө талаас хүүгийн түвшин ойролцоогоор 2-3 хувиар шууд буурах боломжтой буюу 2 тэрбум долларын эх үүсвэрээс зээлийн хүүгийн зардал 40 сая доллар хэмнэгдэнэ гэсэн үг.

ДҮГНЭЛТ

Глобальчлагдсан санхүүгийн зах зээлд Монгол Улс өрсөлдөж ирээдүйнхээ өсөлтийг санхүүжүүлэх үүднээс гадаадаас эх үүсвэр татахыг эрмэлзэх нь ойлгомжтой.

Харамсалтай нь, хөрөнгө оруулалтын бус ангилалд багтаж байгаа манай улсын хувьд зээлжих чадвар сул, мөн өртөг өндөр байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Зээлжих зэрэглэлийг сайжруулах нь хамгийн зөв шийдэл бөгөөд үүнийг богино хугацаанд хийх боломжгүй. Системтэйгээр, төлөвлөгөөний дагуу, уялдаа холоотойгоор шат дараалсан байдлаар хэрэгжүүлж байж сая үр дүнд хүрнэ. Энэ зорилтыг хөрөнгө оруулалт, сангийн асуудал хариуцсан байгууллага үйл ажиллагааныхаа хөтөлбөрт суулган өгч зорилтот байдлаар ажиллах хэрэгтэй. Зээлжих зэрэглэл дээшилбэл хөрөнгө оруулагчдын итгэл сэргэнэ. ■

Сэм Уолш: Бид Монголоос ямар нэг онцгой эрх хүсч, тусгай шаардлага тулгаагүй

Терренс Эдвардс /сэтгүүлч/

Сэм Уолш “Рио Тинто” компанийн гүйцэтгэх захирлаар 2013 оны нэгдүгээр сараас эхлэн ажиллаж байна. Австралийн иргэн Сэм Уолш нь “Рио Тинто” компанийн удирдах зөвлөлийн багт 1991 оноос ажиллаж эхэлсэн бөгөөд тус группт олон албан тушаалыг хашиж байсан нэгэн. Тэрбээр өмнө нь “Женерал Моторс”, “Ниссан Австрали” зэрэг байгууллагад 20 гаруй жил ажилласан туршлагатай. Сэм Уолш энэ удаад “Оюу Толгой” компани нэг сая тонн зэсийн баяжмал экспортолсон баярт үйл явдлыг тохиолдуулан Монгол Улсад ирээд буцлаа. Энэ үеэр түүнээс Монголын хоёр гуравхан хэвлэл ярилцлага авч амжсаны нэг нь манай сэтгүүл юм.

“Рио Тинто”, Монголын Засгийн газар хоорондын харилцаа ямар түвшинд байна вэ. Ялангуяа, Монгол Улс шинэ Ерөнхий сайдтай болсон энэ үед.

“Рио Тинто”, Монголын Засгийн газар хоорондын харилцаа сайн байгаа. “Оюу Толгой” төсөл Монголын Засгийн газар төдийгүй тус улсын иргэд, мөн “Рио Тинто” болон түүний хувьцаа эзэмшигчдийн хувьд тун чухал төсөл. Хамтрагч талууд Монголын ард түмний сайн сайхны төлөө явж буй учраас зорилго нэгтэй ажиллаж байна гэж болно. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээх томоохон төсөл дээр хамтарч байна. Талууд сүүлийн 18 сарын турш хэлэлцээрийн ширээнд сууж, улмаар өнгөрсөн арваннэгдүгээр сард харилцан ойлголцлын санамж бичгийг Монголын Засгийн газарт хүргүүлсэн. Үүнд өнөөдрийг хүртэл хараахан шийдэгдээгүй байгаа асуудлуудыг хөндсөн төдийгүй шийдэл эрэлхийсэн саналуудыг ч тусгасан. Одоогоор тодорхой хэдэн асуудалд гарц хайж байна. Нэг зүйлийг онцлон хэлэхэд, “Рио Тинто”-гийн зүгээс олон улсад томоохон төсөл хэрэгжүүлэгч компаниуд ямар байр суурь илэрхийлдэг түүнтэй л адил зарчмыг баримталж байгаа. Бид ямар



нэг онцгой эрх хүсч, тусгай шаардлага тулгаагүй. Асар их хөрөнгө оруулалт хийгдэх ийм хэмжээний төслийг урагшлуулахад шаардлагатай тэр л алхмуудыг хийхийг зорьж байна. Монголын Засгийн газартай хамтран шийдэх асуудлууд дээр ажиллаж байна. Зөвшилцөлд хүрнэ гэж итгэж буй. Монгол Улс төсөл хэрэгжүүлж, уул уурхай хөгжүүлэх асар их боломжтой орон. Ийм ч учраас “Рио Тинто” энд үйл ажиллагаагаа явуулах чин эрмэлзлэлтэй. Миний Монголд ирсэн нь манай компанийн дээрх эрмэлзлэл бодит гэдэгт мөн хэлэлцээр амжилттай болоосой гэж ихэд найдаж байгаагийн тод илрэл юм.

“Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болох дөрвөн тэрбум ам.долларын асуудалд хөрөнгө оруулагчид хэрхэн хандаж байна вэ. Тэд сонирхсон хэвээр үү?”

Хэлэлцээрийн асуудал шуудармагц зээлдэгчид төслийг сонирхож хөрөнгө оруулах хэвээрээ эсэхийг дахин бататгах хэрэгтэй. Төслийг сонирхож, хөрөнгө оруулалтын саналаа дахин харж үзэж буй олон зээлдэгч бий. Дэлхий бол ихээхэн эмзэг атлаа төвөгтэй газар. Бидний зүгээс дээрх нөхцөл байдлыг тавааруудын ханш, тэр дундаа зэсийн ханш буурсантай холбон үзэж байгаа. Мөн тохиогоод буй дэлхийн санхүүгийн хямрал, зөрчилт байдлыг даван туулах арга зам хайж олон орон тэмцэж байна. Ийм нөхцөлд далд

уурхайн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн талаар зээлдэгч нартай дахин ярилцах шаардлагатай.

“Төслийн хоёрдугаар үе гэгдэж буй далд уурхайн үйлдвэрлэл эхлэх хугацааг хамгийн ойрхондоо хэзээ гэж та харж байна вэ?”

Шийдвэрлэх хэд хэдэн зүйл бий. Нэн тэргүүнд, Монгол Улсын Засгийн газартай хийж буй хэлэлцээрийг эцэслэх. Дараагаар нь бид өдгөө хоцрогдсон тоо баримт, мэдээллүүдээ шинэчлэх шаардлагатай болно. Ажиллах хүчнээ идэвхжүүлэх гээд олон ажил байгаа юм. Тэгэхээр өмнө хийж гүйцэтгэх ийм олон ажил байгаа учраас төслийн хоёрдугаар шат хэзээ эхлэх талаар баттай хэлэх боломжгүй.

“Өнгөрсөн арваннэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьсан санамж бичгийг “Рио Тинто”-гийн зүгээс Монголын Засгийн газарт төлөх шаардлагатай гэгдэх 30 сая ам.долларын татвар болон далд уурхайн санхүүжилтийн дөрвөн тэрбум ам.доллар зэрэг асуудлуудтай холбоотой тавьж буй эцсийн санал гэж ойлгож болох уу?”

Хамгийн сайн боловсруулсан, мөн бидний зүгээс санал болгож байгаа эцсийн хувилбар гэж болно. Манайх дээрх санамж бичгийг тун боломжийн гэж харж байгаа. Мэдээж эцсийн шийд хүртэл боловсронгуй болгох олон зүйл бий. Ийм ч учраас хэлэлцээр үргэлжилсээр байна. Төслийн бүхий л явц хэлэлцээрт үндэслэж байгаа. “Оюу

Толгой” төсөлтэй дүйх хэмжээний төсөл одоогоор Монголд байхгүй. Иймд эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг сайтар тунгаах хэрэгтэй. Бид ямар нэг тусгай анхаарал халамж хүсээгүй гэдгийг дахин хэлье. Бидний зүгээс тогтвортой байдлыг л эрэлхийлж байгаа. Төслийг явуулахад ямар нэг онцгой зүйл гэхээс илүүтэй тогтвортой байдлыг л хүссэн.

-Таны өргөн барьсан Харилцан ойлголцлын санамж бичгийг С.Баярцогт гишүүн Монгол Улсын хуультай харшилж байгаа гэсэн. Түүний хэлснээр Монгол Улс ганц улсад зориулан татварын тусгай хууль хэрэгжүүлж таарахгүй хэмээсэн. “Оюу Толгой” төсөлд ч тэр. Энэхүү шүүмжлэлийг та хэрхэн хүлээж авч байна вэ?

-Бид шударга бас боломжийн санал тавьсан гэж үзэж байгаа. Төслийн 53 хувийн ашиг Засгийн газрынх байна. Энэ бол олон улсын стандартад нийцэх хувь хэмжээ. Дэлхийд хэрэгжиж буй бусад төсөлтэй харьцуулахад ч өрсөлдөх чадвар харьцангуй өндөр. Төслийг авч үзэхдээ нөөц ашиглах хугацаанд уурхайн насжилт, боломжит эрсдэлүүдийг давахаар хэмжээний ашиг олж чадах эсэхийг баттай тооцсон байх хэрэгтэй. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэх нь Улаанбаатарын нэг захад үйлдвэр барихаас илүү эрсдэлтэй гэдгийг ойлгох ёстой. Учир нь, уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй нөөцийн таамаг, өрөмдлөгийн нарийвчилсан программ, хүдрийг баяжуулах боломж, чадавх гээд олон зүйлд найдаж ажиллаж байгаа. Уул уурхайн төслүүд дэлхий дээр хэрэгжиж байгаа бусад төрлийн төслөөс харьцангуй өөр. Төслийн ашгийг тооцоолохдоо дээрх хүчин зүйлсийг бодолцох нь чухал.

-“Turquoise Hill” компанийн зүгээс татвартай холбоотой асуудлаар арбитрын шүүхэд хандах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байсан. Байдал тэр хүртэл хүндэрвэл “Рио Тинто” үүнд хэр бэлэн байгаа вэ?

-Энэ бол нягтлан бодогч, аудиторудын асуудал. Бидний хувьд энэ төрлийн үйл явц хэрхэн автоматжлагдсан байна, түүнийг л дагадаг. Дээрх асуултад хариулахын тулд надад валютын ханшийн зөрүү, тавааруудын үнэ, газрын тосны ханш гэх мэт мэдээллүүдийг өгөх хэрэгтэй. Учир нь энэ бүгд өөрсдийн гэсэн нөлөө үзүүлдэг. Тиймээс эн тэнцүү түвшинд

авч үзэж байж, алдаа гарахгүй байх боломж үүснэ. “Рио Тинто” дэлхий даяар зохих ёсны татвараа төлдөг. Саяхан бид тавдахь удаагийн татварын тайлангаа олон нийтэд мэдээллээ. Тайланд бидний олон улсад төлсөн татварын хэмжээг гаргасан. Сонирхож үзвэл зөвхөн 2014 онд гэхэд л “Рио Тинто” 7.2 тэрбум ам.долларын татвар төлсөн байгаа юм. Бидний төлж буй татвар бүр улс, Засгийн газрын, орон нутгийн, бус нутгийн хэмжээнд хүртэл төлөгдсөн байгааг харж болно. Бид татваруудаа тухай бүрт нь төлдөг. 30 сая ам.долларын татварын асуудлыг мөн Засгийн газартай хэлэлцэж байгаа. Шаардлагатай гэж үзвэл Олон улсын арбитрын шүүхэд хандана.

-“Оюу Толгой” төсөл хойшилсоор байгаа нь төслөөс хүлээх үр дүнд сөргөөр нөлөөлөх болов уу?

-Одоогийн үйлдвэрлэл болон төсөлд төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүй байх гэж бодож байна. Өнөөгийн үүсээд буй нөхцөл байдал өдөр тутамд тохиолддог хүндрэлүүд учир ярилцаж, хэлэлцээд шийдээд л явна. Гэхдээ Монголын Засгийн газар болоод “Рио Тинто”-гийн зүгээс дээрх бүх асуудал хоёр тал хамтрагчид учир ижил тэгш байр сууриас хандана.

-Та зах зээл хүнд байгаатай холбоотойгоор ханган нийлүүлэгчид болон гэрээт байгууллагуудын хүчин чадлыг харгалзан Оюутолгойн хоёрдугаар шатны бүтээн байгуулалтаас хэр хэмжээний хөрөнгө хэмнэх боломжтой гэж харж байгаа вэ?

-Тоо, баримтуудыг дахин нягталж шинэчлэх хэрэгтэй. Төслийн идэвхтэй үйл ажиллагаа суларсан гэдэгтэй санал нэг байна. Төмөр, зэс, хөнгөн цагаан гэх мэт уул уурхайн голлох тавааруудын ханш буураад буй. Миний хувьд байдал сэргэнэ гэж найдаж байгаа. Ингэхийн төлөө ч зүтгэнэ.

-Монголын Засгийн газрын гол зорилго нь “Оюу Толгой”-гоос ирэх шууд болоод ойрын хугацааны үр ашгийг нэмэгдүүлэх хүсэлтэй байгаа. Монголын Засгийн газар хөрөнгө оруулагчид ашгаа хүртэж, ногдол ашиг тараах хүртэлх тэр олон жилийг хүлээх сонирхолгүй байх шиг байна. Ийм нөхцөлд ямар гарц байна?

-Төсөл Засгийн газарт татвараас гадна бусад төлбөрийг төлнө. Оюутолгойн төсөл хэрэгжиж, ил уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл 250 сая

ам.долларыг татвар болон бусад төлбөрт зарцуулаад байна.

-Гэсэн хэдий ч монголчуудын хувьд орлогын тэгш бус хуваарилалт, байгаль экологийн асуудалд сэтгэл зовинож байгаа. Монголчуудад уул уурхай хэрэгтэй гэдгийг “Рио Тинто” хэрхэн ойлгуулах вэ?

-Үүнийг ойлгуулах эхний хүчин зүйл бол татвар. Хоёрдугаарт, бидний бий болгож буй олон мянган ажлын байр. “Рио Тинто” бол дэлхийн хоёр дахь том уул уурхайн компани. Бид дэлхийн хэмжээний төслүүдийг дэлхийн хэмжээний туршлагад суурилан бий болгодог. Бид аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны асуудалд ихээхэн анхаарал хандуулан ажилладаг бөгөөд хамгийн шилдэг арга барилыг тухайн газартаа хэрэгжүүлэхийг зорьдог. Түүнчлэн үйл ажиллагаа явуулж буй улс орныхоо хууль эрх зүйн орчинд нийцэж үйл ажиллагаагаа явуулдаг. XXI зуунд уул уурхай чухал үүрэг гүйцэтгэж байна. Улс орныг хөгжүүлэх, хотжилт, аж үйлдвэр уул уурхайн бүтээгдэхүүнгүйгээр цааш хөгжинө гэдэг бараг л боломжгүй. Энгийнээр хэлбэл барилга барих боломжгүй болно. Бидний нийлүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүн байхгүй бол гар утас ч ашиглах боломжгүй болно. Тэгэхээр бид, уул уурхайн салбарынхан, хөгжиж буй улс орны чухал хэсэг болж таарч байна. Мэдээж бид шилдэг туршлагыг хөрсөнд буулгаж байгаа. Гэхдээ төслүүдийг урагшлуулах нь маш чухал.

Зэс дэлхийн хөгжилд чухал үүрэг хүлээнэ. Дэлхий зэсгүй болоосой гэж хүсэхгүй.

-Монгол бусад улстай харьцуулахад хамтран ажиллахад хэр ээлтэй орон юм бол?

-Өмнө нь хэлсэнчлэн Монголын татварын орчин бусад оронтой өрсөлдөхүйц. Бид татвараа төлж байгаа, төлсөөр ч байх болно. “Рио Тинто” дэлхийн 40 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулдаг. Улс бүр уул уурхайн бизнес явуулах өөрийн гэсэн зарчим, шаардлагатай байдаг. Манай компани тэр бүхнийг бидний нийгэм дэх нэр хүндийн чухал хэсэг гэж хүлээн авдаг. Үйл ажиллагаа явуулж байгаа газар нутгийн болоод нийгмийн бүлгүүдийн хүлээлтэд нийцэн ажиллахыг зорьдог. Энэ тал дээр чамлахааргүй сайн үүрэг гүйцэтгэдэг гэж боддог шүү. ■

СУДЛААЧИЙН ҮГ

Өрийн удирдлагын тухай хууль болон түүний эргэн тойронд



Л.Гангэрэл
/Эдийн засагч,
судлаач/

Хөгжлийн банкны 580 сая ам долларын бонд, 1.0 тэрбум ам долларын Чингис бонд гэх мэт Монгол улсын Засгийн газраас гаргасан гадаад баталгаа болон өр зээлийн хэмжээ 2012 оноос хойш огцом өссөнтэй холбоотойгоор улсын гадаад өрийн асуудал сүүлийн үед ихээхэн тулгамдсан асуудлуудын нэг болж хувирлаа. Зарим эдийн засгийн судлаач, шинжээчдийн зүгээс Монгол Улсын гадаад өрийн асуудал нэлээд ноцтой хэмжээнд ирлээ, ойрын ирээдүйд гадаад болон дотоод өрийн дарамтад орох бодит аюул тулгарлаа гэж хэлж ярьж байна. Энэ талаар ч гадаад, дотоод хэвлэлүүд бичиж эхэлсэн бөгөөд Хятадын “Синьхуа” агентлагийн мэдээнд Монгол Улс 2017 онд гадаад өрөө төлж чадахгүй, дефолт болох эрсдэл байна гэдгийг сануулж бичсэнийг дурдах нь зүйтэй.

Энэ тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд улсын өрийн удирдлагыг зохицуулах хууль эрх зүйн орчинтой болох, улсын гадаад өр, Засгийн газрын өрийн талаар албаны нэгдсэн ойлголттой болох үүднээс УИХ-аас энэ оны хоёрдугаар сард Өрийн удирдлагын тухай хуулийг шинээр батлан гаргалаа. Энэхүү хуулиар өрийн удирдлагын тухай концепцийн ямар ямар өөрчлөлтүүд орсон талаар товч өгүүлье.

Үүний өмнө Засгийн газрын өрийн дээд хязгаарыг урьд нь ямар хууль эрх зүйгээр зохицуулдаг байсан болон олон улсын стандартын дагуу ямар хүрээнд авч үздэг байсан талаар товч авч үзье. Дээрх шинэ хууль батлагдахаас өмнө улсын өрийн удирдлагыг зохицуулах

талаар яг тодорхойлсон хууль, дүрэм журам байгаагүй. Гэхдээ зарим нэг зохицуулалтууд Төсвийн тухай хууль, Төсвийн Тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулиудад тусгагдсан байсан. Тухайлбал Төсвийн Тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4 дэх заалтаар “уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хасч тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн хязгаарлалтыг улсын нийт өрд тавьж өгдөг байсан. Түүнчлэн Дэлхийн банк болон ОУВС-гаас эрхлэн гаргадаг улсын бодлого, институцийн үнэлгээний дагуу (СРІА) харгалзан тооцдог гадаад өрийн сэрэмжлэх түвшингээр манай Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2013 оны байдлаар 40 хувьд байвал зохистой гэж үзсэн байдаг. Учир нь Дэлхийн банк болон ОУВС-гаас Монгол Улсыг хамгийн сүүлд 2013 онд уг үнэлгээгээр 3.4 буюу хэвийн бодлоготой орон гэж дүгнэсэн байдаг.

Шинээр батлагдсан Өрийн удирдлагын тухай хуулинд концепцийн шинжтэй хэд хэдэн өөрчлөлтүүд орлоо. Нэгдүгээрт, улсын нийт гадаад өр болон Засгийн газрын өр гэж юуг хэлэх талаар тодорхойлж өглөө. Улсын нийт гадаад өрийг ОУВС-гаас гаргасан тодорхойлолттой нэн төстэйгээр “Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн

үүргийг” хэлнэ гэж тодорхойлов. Үүгээрээ Монголбанкны гадаад өрийг улсын нийт гадаад өрөнд оруулж тооцож байна. Засгийн газрын өрийг өмнө нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д зааснаар тодорхойлон оруулж ирсэн. Гэхдээ төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн зээллэг нь Засгийн газрын өрд хамаарахаа больж байгаа бөгөөд хэрэв Засгийн газраас энэхүү зээллэгт баталгаа гаргавал тэр баталгааг энэхүү хуулиар зохицуулахаар болж байна.

Хоёрдугаарт, Засгийн газрын зээллэг ба өрийн баталгааг тусад нь авч үзэх бөгөөд жил бүр буюу тухайн жилд Засгийн газрын шинээр үүсгэх зээллэг болон өрийн баталгааны дээд хязгаарыг абсолют хэмжээгээр тавьж өгч УИХ-аар батлуулдаг болно. Үүнээс гадна Төсвийн тогтвортой байдлын тухай 6.1.4 дэх заалтын дагуу Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаанд нэрлэсэн дотоодын нийт бүтээгдхүүнтэй харьцуулсан хязгаарлалтыг (40%-д тавьж өгч байна. Засгийн газрын Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн бичиг баримтыг гурван жилд нэг удаа УИХ-аар батлуулдаг байх, улсын нийт гадаад өрийн статистик тоо Мэдээг Монголбанк, Сангийн Яам хамтран улиралд нэг удаа олон нийтэд мэдээлдэг байх шаардлагатай болж байна.

Гуравдугаарт, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаггүй, тухайн орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зардлынхаа 50 хувиас багагүй байх шалгуурыг хангасан нийслэл болон аймгууд нь улирлын шинжтэй төсвийн орлогын тасалдлыг арилгах зорилгоор бонд гаргаж болох хууль эрх зүйн орчин бүрдлээ. Ийнхүү орон нутгийн бонд гаргахдаа тухайн орон нутгийн ИТХ-аасаа холбогдох зөвшөөрлийг авсан байх шаардлагатай байна.

Дөрөвдүгээрт, Засгийн газар

“ 40 сая ам долларын гадагшлах урсгалыг хаахын тулд 827 сая ам долларын зээлийн санхүүжилт хийх нь хэр зохимжтой вэ гэдэг асуудал. ”



зөвхөн төрийн өмчийн оролцоот компаниудаас гадна дотоодын хөрөнгө оруулалт бүхий Монгол Улсад бүртгэлтэй хувийн хэвшлийн компаниудын хэрэгжүүлэх гэж буй улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт орсон төслийг санхүүжүүлэхэд баталгаа гаргах боломжтой болж буй. Тухайн төсөл хөтөлбөрт нь зохих шалгуурыг тавихаас гадна төслийг хэрэгжүүлэх гэж буй компанид сүүлийн гурван жил ашигтай ажилласан байх, хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх зэрэг шаардлагуудыг тавина. Засгийн газраас Хөгжлийн банкны хэрэгжүүлэх гэж буй төсөлд 100 хувийн, бусад аж ахуйн нэгжүүдийн төсөл хөтөлбөрт тухайн төслийн өртгийн 85 хүртэлх хувьд баталгаа гаргах боломжтой байна.

Тавдугаарт, Засгийн газрын өрийн баталгааны гүйцэтгэлийг хангахад шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор Засгийн газрын өрийн баталгааны Санг байгуулна. Мөн Өрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж хөтлөх бөгөөд үүндээ улсын нийт гадаад өр, Засгийн газрын өр болон өрийн баталгааны үлдэгдэл, аймаг болон нийслэлийн бондын талаарх мэдээлэл зэргийг бүртгэн хөтөлж байх юм байна.

Дүгнэж хэлэхэд, энэхүү хуулиар зөвхөн улсын болон Засгийн газрын өртэй холбоотой харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаашид хувийн хэвшлийн гадаад өртэй холбоотой асуудлыг хэрхэн хянаж

зохицуулах талаар Монголбанк болон Сангийн Яамнаас анхаарч ажиллах нь зүйтэй. Латин Америкийн орнуудын 1970-1980-аад онуудын зээллэгийн хямрал нь улсаас зөвхөн Засгийн газрын өрийг хянахаас гадна хувийн хэвшлийн гадаад өрийг хязгаарлаж, зохицуулж байх нь нэн чухал болохыг харуулсан билээ.

Эцэст нь Засгийн газрын гадаад өртэй холбоотой сүүлийн нэг сард гарч буй томоохон шийдвэрүүдийн талаар ярилцъя. Сангийн Сайдын хамгийн сүүлд “Сайдын цаг”-аар өгсөн мэдээллээр Өрийн удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталснаар Засгийн газраас шинээр 450 сая ам долларын зээллэгийг үүсгэх боломжтой боллоо гэж байна. Аль 2013 оноос яригдаж эхэлсэн Засгийн газрын Хятад улсаас авах нэг тэрбум ам долларын хөнгөлөлттэй зээлийг авах асуудал яригдаж байгаа бөгөөд хэрэв энэхүү зээл бүтвэл үүний 827 сая ам доллараар Эгийн Голын усан цахилгаан станцын, 110 орчим сая ам долларыг Хөшгийн хөндийн олон улсын нисэх буудлын хурдны замын төслийг тус тус санхүүжүүлэхэд зарцуулах Засгийн газрын шийдвэр гарлаа.

Хувь судлаачийн зүгээс авч үзэхэд эдгээр шийдвэрүүд нь Засгийн газрын гадаад өрийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд цаг үеэ олоогүй, оновчгүй шийдвэрүүд байна гэж үзэж байна. Учир нь Эгийн голын цахилгаан станцын эдийн засгийн гол агуулга бол Оросоос авч

буй цахилгааны импортыг хаахад зориулагдаж байгаа бөгөөд энэ нь жилдээ 40 орчим сая доллар байдаг. Гэтэл 40 сая ам долларын гадагшлах урсгалыг хаахын тулд 827 сая ам долларын зээлийн санхүүжилт хийх нь хэр зохимжтой вэ гэдэг асуудал. Нөгөө талаас аливаа орны нийслэлээс олон улсын гол нисэх буудал руу явсан хурдны зам хамгийн ачаалалтай, ашигтай хурдны замд тооцогддог. Иймд Засгийн газраас өөр дээрээ нэмж 110 орчим сая ам долларын гадаад өрийн ачааллыг үүсгэхгүйгээр концессийн гэрээгээр энэхүү 38 км хурдны замыг хувийн хэвшлээр хийж гүйцэтгүүлэх бүрэн боломжтой.

Одоогийн байдлаар Монгол Улсын хувьд Хөгжлийн банкны 580 сая ам долларын бондын 2017 онд төлөх үндсэн төлбөр, Засгийн газрын Чингис бондын 2018 оны нэгдүгээр сард төлөх 500 сая ам долларын үндсэн төлбөр, Монголбанкны Хятадын Төвбанктай хийсэн 15 тэрбум юанийн своп хэлцлээр үүссэн Хятадын Төвбанкинд төлөх 2.7 тэрбум орчим ам долларын 2017 онд хийх өр төлбөрийн асуудлууд нэн тулгамдаад байгаа бөгөөд үүнийг хэрхэн барагдуулах талаар Монголбанк, Сангийн яамнаас тодорхой нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж ажиллах нь зүйтэй. ■

И-мэйл: gangerel@gmail.com
Fb: [Gangerel Ikhagvajav](#)

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

3. Нарантуяа: Системийн найдвартай, эрсдэлгүй байдлыг хангана

И.Отгонжаргал

Санхүүгийн зохицуулах хорооны дарга 3.Нарантуяатай санхүү, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн чиг хандлага, шинэчлэл, шинэ удирдлагын авч хэрэгжүүлж байгаа бодлогын талаар ярилцлаа.

-Та хэдхэн хоногийн өмнө Япон улсад ажиллаад ирсэн. Тус улсын энэ төрлийн байгууллагатай бодитой ямар хамтын ажиллагаа эхлүүлэхээр болсон бэ?

-Манай СЗХ Японы санхүүгийн үйлчилгээний төв байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байсан. Энэ хүрээнд хоёр байгууллага олон чиглэлээр хамтарч ажиллах ба ялангуяа санхүүгийн зах зээлд тавих хяналт шалгалтыг боловсронгуй болгоход түлхүү анхаарна. Энэ байгууллагын дэмжлэгтэйгээр Монголын хөрөнгийн зах зээлийн чадавхыг нэмэгдүүлэх төслийг Жайкатай хамтарч хэрэгжүүлэхээр болсон. Төслийг өмнөх удирдлагын үед өнгөрсөн оны арванхоёрдугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн байсан. Төслийн хүрээнд хийхээр тохиролцсон ажлууд дээр ойрын хугацаанд хэрэгжүүлэх зорилттойгоо уялдуулж зарим нэмэлт ажлуудыг тухайлбал, Төрийн өмчийн компаниудаас сонголт хийх, нэмж IPO хийлгүүлэх замаар хувьчлахад тусалж, сайн загвар болгох, Клирингийн буюу тооцооны байгууллагыг шинээр ажиллуулж эхлэхэд мэргэжлийн зөвлөмж өгөх экспертээр туслуулах, Хорооны ажилтнуудыг чадавхижуулах сургах хөтөлбөрийг өргөжүүлэх, суралцагчдын тоог нэмэгдүүлэх гэх мэт асуудлуудыг шинэ удирдлагын зүгээс тавьсан учраас энэ талаараа ярилцаж тохиролцох, мөн Японы санхүүгийн зах зээлийн гол гол оролцогч байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, судлах зорилгоор Токиод ажиллаад ирлээ. Японы хөрөнгийн зах зээлийн



хөгжлийн түвшинг манайхтай харьцуулахын аргагүй. Дэлхийн гурав дахь том бирж. Түүхий эдийн биржийн арилжааны горим, ашиглаж байгаа систем, хяналтын механизмтэй нь танилцлаа. Санхүүгийн зах маш сайн дэд бүтэцтэй, мэдрэмжтэй, уян хатан зохицуулалт, нарийн чанд хяналтын тогтолцоотой байж, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээж, эрсдэл багатай ажилладаг онцлогтой учраас манай зах зээлийн өнөөдрийн түвшин, онцлогт тохирсон, ирээдүйн чиг хандлагын тооцоололд суурилсан хөгжлийн загварыг богино хугацаанд бий болгоход бусдаас суралцах зүйл их байна.

-Мэргэжлийн хүний хувьд та Монголынхоо хөрөнгийн зах зээлийг хэрхэн харж байна. Ямар шийдвэртэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх вэ?

-Зах зээлийн хувьд тэлэх боломж, багтаамж байгаа. Эдийн засгийн

өсөлт буурах хандлагатай, гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгал татарсан, төгрөгийн худалдан авах чадвар болон ханш буурсан байгаа өнөөдрийн макро орчин богино хугацаандаа хөрөнгийн захын хөгжил, зах зээлийн тэлэлтэд таатай бус орчин.

Гэхдээ урт хугацаанд бидэнд хөрөнгийн захынхаа бүтэц, зохицуулалтыг зөв болгож, хөгжлийн загвараа зөв тодорхойлох боломж өгч байна. 2011-2012 оны эдийн засгийн хурдацтай өсөлтийн үед арилжаа идэвхжиж, зах зээлийн үнэлгээ өсч байсан. Энэ үед биржийн ажиллагаа, төлбөр тооцоо, хадгаламжийн тогтолцоо, арилжааны систем бэлэн биш байсан. Гадаад зах зээлтэй холбогдох гарц, холбоос байгаагүй. Одоо ч бэлэн болж чадаагүй л байна. Мөн манай хөрөнгийн зах уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд суурилсан санхүүгийн хэрэгслийн

зах болж хөгжих нь бусдаас ялгарах, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах онцлог нь болох учиртай. Хөгжлийн ийм тодорхой стратеги, загвар, хөтөлбөр байгаагүй. Иймд 2020 он хүртэл Монгол Улсын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийг батлуулж, энэ зах зээлийн оролцогч болон зохицуулагч бүрт ирээдүйд хүрэх цэг, чиг хандлагаа ойлгомжтойгоор тодорхойлж өгөхийн төлөө, шаардлагатай дэд бүтцийг бий болгох замаар зах зээлийн хөгжлийг дэмжих чиглэлд голлон анхаарч ажиллаж байна.

Оролцогч бүрийг чадавхижуулах, зах зээлийн зарчмаараа шударга өрсөлдөх, тэгш оролцох орчин хэрэгтэй. Даатгалын болон эрсдэлээс хамгаалагдах тогтолцоо бий болгох, татварын, хөрөнгийн үнэлгээний, санхүүгийн тайлагнал, аудитын чанар стандартын болон хяналт шалгалт, мөрдөн шалгах ажиллагааны гэх мэт зөөлөн дэд бүтцүүдийг сайжруулах шаардлага байгаа.

-СЗХ-ны үйлчилгээг муу байна гэсэн шүүмжлэл багагүй сонсогддог. Та үүнийг хэрхэн харж байна вэ?

Зохицуулна гэдгийг зөвхөн тусгай зөвшөөрөл олгож, хяналт тавих явцуу утгаар харахгүй байна. Энэ салбарт уялдуулж зохицуулах олон ажлууд байна. СЗХ-ны дангаараа хийчихдэггүй, Засгийн газар, салбарын яамд, агентлагуудтай, Монголбанк, Сангийн яамтайгаа хамтарч шийдвэрлэх дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн олон ажил хүлээж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын томоохон сангуудыг байгуулж, хөрөнгийн удирдлагыг мэргэжлийн түвшинд хийдэг болгоход хувь нийлүүлэгчийн хувьд Засгийн газрын зүгээс арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авах, асуудлыг түргэн хугацаанд шийдвэрлэх нь санхүүгийн зах зээлийн хөгжилд ихээхэн чухал юм. Ирээдүйн өв сан, тэтгэврийн даатгалын болон хөрөнгө оруулалтын сангууд нь хөрөнгийн захад эргэлдэх хөрөнгө оруулалтын томоохон эх үүсвэр учраас бодлогоор ийм сангуудыг байгуулах гэж байна. Хөрөнгийг хэнээр удирдуулахаа эзэмшигч шийдэх учраас улс төр, эрх ашгийн сонирхлоос ангид байлгаж, цэвэр бизнесийн менежментийг хийлгэх нөхцлийг хангаж чадвал эдгээр сан манай зах зээлд идэвхитэй

оролцогч болж чадна.

Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг удирдахад сайн засаглал шаардлагатай. Эдгээр мэргэжлийн байгууллагын удирдлагын шат бүрт эрх мэдлийн хуваарилалт зөв хийгдэхгүй бол бизнесийн шийдвэр гаргалт цаг хугацааны болон бусад хүчин зүйлээс хамаарч цагаа олохгүй байх, ашигт ажиллагаа, өгөөж зэрэгт нь сөргөөр нөлөөлөх, зах зээлд эрсдэл учруулж болзошгүй шийдвэр ч гарч болох эрсдэлтэй. Харилцагчдын нууцлал, мэдээллийн ил тод байдал хоёр маш чухал хүчин зүйл байдаг.

-Таны хэлж байгаа дэд бүтцийн байгууллагууд болох клирингийн үйлчилгээ, кастодиан банк зэргийн суурийг тавиад, зөв бүтцийг бий болгоод ажиллахад мэдээж цаг хугацаа их шаардах байх. Энэ ондоо гол нь юуг хийж амжуулахаар байгаа вэ. Эдгээрийг хийхэд хамгийн тулгамдсан асуудал юу байх бол?

-Төрийн шийдвэр гаргах байгууллагууд хоорондоо үйл ажиллагааныхаа зорилгыг ойлголцож уялдуулж, шийдвэрээ хурдан гаргах маш чухал. Хамгийн гол нь Засгийн газрын түвшинд биржийн хувьчлалын асуудлыг цаг алдахгүй шийдэх хэрэгтэй байна. Мөн ҮЦТТХТ, клирингийн төвийг тус тусын үйл ажиллагаагаа явуулах боломж нөхцөлөөр нь хангаж, өмчлөлийн асуудлыг нь шийдэх. Бусад орны жишгийг харахад эдгээр байгууллагын засаглал зах зээлд оролцогчдын дундын эзэмшилд байх нь зохистой хэлбэр гэж үздэг байна.

-Санхүүгийн зах зээл нэлээд шинэ бүтэцтэй ажиллах нөхцөл бүрдэх нь гэж ойлгож болох уу?

-Тиймээ. Олон тулгууртай санхүүгийн бүтцийг бий болгох зорилгыг тавьж байна. Энэ зорилгод үе шаттайгаар хүрнэ. Мэдээж цаг хугацаа хэрэгтэй. Банкууд болон томоохон хөрөнгө оруулалтын сангууд бий болсноор санхүүгийн компаниудын өрсөлдөх чадвар нь сайжирч чадавхиана. Манай бодит эдийн засгийг дэмжихэд шаардлагатай байгаа урт хугацааны хөрөнгө оруулалтын эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр энэ зах зээл дээр хангагдаж, богино хугацаатай өртөг өндөртэй арилжааны эх үүсвэрээс татгалзаж, хөрөнгийн зах руу шилжиж шилжилтийн үе ирнэ гэдэгт итгэж байна.

Даатгал болон бичил санхүүгийн томоохон зах зээл байна гэж харагдаж байна. Энэ салбарт бизнес эрхлэгчид ашигтай байх, ажиллах таатай орчныг нь зохицуулалтын механизмгаараа дамжуулж бүрдүүлж чадвал хөрөнгийн урсгал эргэнэ.

-Таны хэлснээр манай хөрөнгийн зах зээлд боломж, багтаамж байна. Хууль эрх зүйн хувьд нэлээд бэхжээд эхэлсэн. Хүмүүс ХХК-иудыг ХК болох сонирхлыг нь төрүүлэх хэрэгтэй байна гэдэг. Гаднын зарим эдийн засагч, санхүүчид эхлээд монголчууд өөрсдөө дотооддоо хөрөнгийн зах зээлээ сонирхож, хөгжүүлэхэд анхаарах ёстой гэж ярьдаг. Энэ дээр дэд бүтэц, хууль эрх зүйгээс гадна бодитой эдийн засгийн хөшүүрэг үгүйлэгдээд байгаа юм болов уу. Тухайлбал, арилжаанд оролцогчдын татвар хураамжийн асуудал нэлээд яригддаг шүү дээ.

-Татвар хураамжийн асуудал нэг хөшүүрэг мөн. Татварын хөнгөлөлт, урамшуулал байхгүй байгаа. Хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг судалсан. Нөгөө талаас оруулсан хөрөнгийг эрсдэлээс хамгаалж даатгалд хамруулдаг болох, эрсдэлийн буюу тогтворжуулалтын санг бий болгох асуудал. Эдгээр механизм зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийн баталгаа болдог учраас бий болгох шаардлагатай. Үйлчилгээний шимтгэлийг зохистой хэмжээг тооцож мөрдөх нь арилжаанд оролцогчдын, даатгагчдад илүү дарамт үзүүлэхгүй байх сайн талтай тул Хороо зохицуулалтын үйлчилгээнийхээ хэмжээг үйлчилгээний төрөл тус бүрийн ажиллагааны зардал, бусад хүчин зүйлүүдийг харгалзан тодорхой хэмжээгээр бууруулж тогтоолоо.

-УИХ дэлгүүрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гэдэг асуудал жилийн жилд дуулддаг. Шалгалт хийгээд тийм зөрчил гарлаа гэдэг. Тэгээд үр дүн ерөөсөө байдаггүй. Энэ дээр ямар шийдвэртэй алхам хийх вэ?

-УИХ дэлгүүрийн 45000 жижиг хувьцаа эзэмшигч гомдол гаргаж хандсан. Ашиг орлогоо нуух үйлдэл хийсэн байна уу гэдгийг шалгаж, тогтоох ёстой. Энэ удаагийн шалгалтыг холдингийн гишүүн компаниудын хэмжээнд орлого зарлагыг нь тулгах замаар хийж байгаа. Олон жил

үргэлжилсэн маргаан байна лээ.

Хувьцаат компаниуд үйл ажиллагаагаа шударгаар тайлагнах соёлд суралцаж, мэдээллээ ил тод нээлттэй байлгах нь сайн засаглалтай байгаагийн илрэл болдог учраас ХК-иудыг шинэ хуулийн орчинд хууль, дүрэм, журмыг баримталж ажиллахыг шаардаж ажиллах болно.

-1072 хувьцааг амилуулах тал дээр Зохицуулах хороо юу хийж байна вэ?

-1072 хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигч гэдгийг эрх зүйн хувьд баталгаатай болгоход анхаарч байна. Эзэмшигч нь хэн байхаас үл хамааран хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй тул СЗХ хуулийн дагуу тавих шаардлагыг ижил хэмжээнд тавьж ажиллана. Тухайлбал, Засгийн газар иргэдийн хувьцааг худалдаж авна гэхчээ мөнгөө төлөөгүй бол тэдгээр хувьцааг эргүүлээд иргэдийн нэр дээр нь бүртгэх л ёстой. Энэ ажиллагааг хийх журмыг яаралтай өөрчилж арга хэмжээ аваач гэдэг зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлсэн. Хамгийн гол нь төсөл хэрэгжиж дуусахад Тавантолгой компани богино хугацаанд ашигтай ажиллаж эхлэх нь иргэдэд ногдох ногдол ашгийн баталгаа учраас компанийн хөрөнгийн үнэлгээ, баланс дахь өр төлбөрийг цэгцлэх, эерэг баланстай компани болгох зэрэг олон асуудал байгаа. Хэлэлцээрийн явцад анхаарч байгаа байх.

-Та өөрийн хэрэгжүүлэх бодлого, шийдвэртэй холбоотой байгууллагадаа бүтцийн ч юм уу өөрчлөлт хэр хийсэн бэ?

-СЗХ 2006 онд байгуулагдсан. Олон өөрчлөлтүүд хийж байсан байх. Миний хувьд энэ зах зээлд тулгамдаж байгаа асуудлуудаа эхэлж тодорхойлсон. Дараа нь шийдвэрлэх арга зам, хийх ажлаа эрэмблээд хүний нөөцөө тооцоолсны үндсэн дээр бүтэц зохион байгуулалтаа үндсээр нь өөрчилсөн. Зах зээлээ судалгаатайгаар дэмжиж зохицуулах, салбарын нэгдсэн хяналтыг төлөвшүүлж, чанаржуулах, зөвшөөрлийн олон шалгуур шаардлагыг хөнгөвчлөх зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлууд байгаа учраас тусгай чиглэл чиглэлээр нь газар байгуулж, дагнан ажиллуулж эхэлсэн. Хүн бүрийг чадвар чадамжид нь тохирох ажлын байранд нь шилжүүлэн ажиллуулж байна. Үр дүнг тодорхой хугацаанд харна. Системийн

хэмжээний эрсдэлийн удирдлага зохицуулалтыг хийх функц бий болгосон.

-Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах тал дээр юу хэлэх вэ?

-Ямар мэдээллүүдийг ямар хугацаанд өөрийн мэдээллийн сайт болон СЗХ-нд ирүүлж ил болгох ёстой вэ гэдэг нь хуульчлагдсан учраас хуулийн хүрээнд шаардлага тавьж ажиллаж байна. Эрсдэлд суурилсан хяналт буюу зайнаас хийх хяналт шалгалт мэдээлэл дээр сууриллагдаж хийгдэх ёстой. Тайлан мэдээний агуулга, загвар, маягуудыг ойрын хугацаанд шинэчилнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр хэрэгждэг. Энэ хүрээнд засаглал гэсэн портал сайтыг нээж, бирж дээр бүртгэлтэй байгаа компаниудын санхүүгийн тайлан, засаглалын талаарх, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн мэдээллүүдийг ил тод тавьж байх юм. Мэдээллийг ил тод болгох эдгээр ажлыг эхний хагас жилдээ багтааж хийж дуусахаар ажиллаж байна.

-Иргэдийн санхүүгийн боловсролын асуудал чухал байна. Хөрөнгийн зах зээл хөгжөөд 20 гаруй жил болж байгаа ч гэсэн компаниудын соёл, иргэдийн хөрөнгийн зах зээлд итгэх итгэл, хувьцааны арилжаанд оролцох идэвх, хувьцааны үнэ цэнийг ойлгох асуудал дутмаг. Бараг 20 гаруй жилийн өмнөх ойлголт хэвээрээ байна гэхэд хилсдэхгүй. Тухайлбал, ЗГҮЦ гээд хамгийн баталгаатай үнэт цаас гарч байхад хэн ч сонирхож авахгүй байна. Зарим мэргэжлийн хүмүүс иргэдэд санхүүгийн боловсрол олгохгүйгээр хөрөнгийн зах зээл хөгжихгүй нь ээ гэдэг дүгнэлтийг хийж байх шиг байсан. Энэ тал дээр таны бодлыг сонирхоё.

-Хүн аливаа юмыг хэрэглэж сурч, үр ашгийг нь бодитой хүртэж байж мэдэрдэг. Монголчууд бидний хувьд хөрөнгийн зах зээлээр дамжуулаад хөрөнгө босгох, эсвэл өөрийн хөрөнгөө өсгөж эхэлсэн түүх 90-ээд оны эхэн үеэс л эхэлсэн шүү дээ. Тийм болохоор санхүүгийн боловсролын асуудал үнэхээр чухал. Хүүхэд байхаас нь энэ зах зээлийн ажиллагаа, үйл явцыг танин мэдүүлж, сургах сургалтын хөтөлбөр хэрэгтэй.

Гар утаснаасаа төлбөрөө шилжүүлж болж байгаа шиг

арилжаанд оролцож болдог хэмжээнд үйлчилгээг хүргэж чадах юм бол хүн бүрийн хэрэглээ болж дэлгэрэхэд маш амархан. Хэрэгжүүлж байгаа төслүүдийнхээ хүрээнд иргэдийн санхүүгийн боловсрол, хүртээмжийг сайжруулна гээд кино, аппликешн хийсэн, сургалт сурталчилгааны ажлууд хийгдэж байгаа. Гэхдээ нэг байгууллага дангаар санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлнэ гэвэл дийлэхгүй. Боловсролын асуудалд холбоотой бүх л байгууллага хамтарч хүч хөрөнгөө нэгтгэж ажиллавал илүү үр дүнд хүрэх байх.

-Арилжааны банкныхан андеррайтерын үйлчилгээ үзүүлэх нь хэр нийцтэй вэ. Мөнөөх зах зээлд 90 хувийг эзэлдэг монополия салбараа дэмжих юм биш үү гэсэн зарим оролцогчдын байр суурь дуулддаг. Жишээлбэл, "Голомт" банк кастодианы үйлчилгээ эрхлэхээр зөвшөөрөл авчигдсан байхад тус банкны охин компани давхар андеррайтерын үйлчилгээ явуулах эрх авсан нь хэр шударга вэ гэсэн мэдлээлэл би саяхан хэвлэлээс уншсан. Энэ тал дээр та ямар бодолтой байна вэ?

- Банк санхүүгийн үйлчилгээг энэ бол уламжлалт, энэ бол уламжлалт бус гэх зэргээр чиглэлээр нь салгах боломжгүй. Банкны салбараас хөрөнгийн зах руу хөрөнгө орж ирснээр нөгөө яриад байдаг зохистой бүтцийг бий болгоход маш чухал. Банкууд охин компаниа байгуулаад харилцагчдын хөрөнгөөр бус өөрийн хөрөнгөөрөө андеррайтерын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч байгаа нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа. Хуулиар хавсран эрхэлж болох, болохгүй үйл ажиллагаа гэж бий. Жишээлбэл, банкууд брокерийн үйл ажиллагааг эрхэлж болохгүй бол кастодианы хувьд том хөрөнгө оруулагчдын мөнгө, үнэт цаасыг найдвартай хадгалж байх үүрэг бүхий зах зээлийн оролцогчийн хувьд тухайлсан үнэт цаасны бүртгэлийн ажиллагаа болон төлбөр тооцооны үйл ажиллагааг хавсран эрхэлж болно гэх мэт нарийн зохицуулалт бий. Брокер дилерийн компаниуд өрсөлдөөнд өөрийгөө бэлтгэж, богино хугацаанд чадавхижих шаардлагатай тулгарч байгаа. Зохицуулагч байгууллага аль нэг талд давуу байдал бий болгохгүй цэвэр өрсөлдөөний орчныг л бүрдүүлэх үүрэгтэй. Ингэж л ажиллана. ■



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



QSDC
БИД ТАНЫ БИЗНЕСИЙН АМЖИЛТАД
ХӨРӨНГӨ ОРУУЛНА

Ханган нийлүүлэгчдийн хөгжил, чанарын төв нь хувийн хэвшлийн төлөөллийн санаачилгаар АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аас хэрэгжүүлж буй “Бизнесийг дэмжих санаачилга” төслийн дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан бизнес хөгжлийн байгууллага юм. Бидний зорилго дотоодын компаниудад борлуулалтаа нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг даван туулах, өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангахад нь техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тэдний өрсөлдөх чадварыг сайжруулахад оршино.

ХНХЧТ нь Техникийн туслалцааны сангаараа дамжуулан дотоодын ЖДҮ-д тулгарч буй:

- Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- ISO, HACCP зэрэг олон улсын чанарын удирдлагын систем нэвтрүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах;
- Шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх;

зэрэг зорилгоо биелүүлэхэд нь санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлж байна.

ХНХЧТ-ийн “Ханган нийлүүлэгчийг хөгжүүлэх” хөтөлбөр нь:

- нэг талаас өөрийн ханган нийлүүлэгчдийн үйлчилгээний чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтэй худалдан авагч томоохон аж ахуйн нэгжүүд,
- нөгөө талаас өөрийн бизнесийг өргөжүүлэхээр эрмэлзэж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйлчилдэг.

**ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

**ЧАНАРЫН УДИРДАГАЙН
ХӨТӨЛБӨР**

ХНХЧТ нь компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн олон улсын шилдэг туршлагад суурилсан чанарын удирдлагын сургалтуудыг санал болгож байна. Манай байгууллага нь Лондонд төвтэй “Орчны эрүүл мэндийн итгэмжлэгдсэн институт”-ийн олон улсын гэрчилгээтэй дараах сургалтуудыг зохион байгуулж байна:

- Хүнсний аюулгүй байдал ба аюулын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (HACCP);
- Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал.

Түүнчлэн бид “Зургаан Сигма – Ногоон бүст мэргэжилтэн бэлтгэх” сургалтыг түншлэгч байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

Холбоо барих хаяг:
Экспрес цамхаг, 12 дугаар давхар,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: (976) 11-321375
Факс: (976) 11-327825
Вэб хуудас: www.qsdc.mn

**БИД ТАНЫ БИЗНЕСИЙН
АМЖИЛТАД ХӨРӨНГӨ
ОРУУЛНА**



ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Ядуусын амьдралд олон салаа

“ Дэлхийн банк туйлын ядуурлыг өдөрт нэг ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог. Гэтэл Монголд хоногт зургаахан зүсэм талхаар өл залгаж буй өрх гэрүүд байна ”



СХД-ийн 26 дугаар хорооны “Алтан овоо 39”-ын задгай гэх хаягтай газар

Г.ОРХОН


Ядуу хүний зовлонг ядуу хүн л мэддэг гэх үнэн үг бий. Бидний амьдралд эрхэлсэн ажилгүй, мөнгөгүйгээс үүдэн өчнөөн зовлонг зүйл урган гарч байна. Манай сэтгүүл ядууралд байнга анхаарлаа хандуулдаг. Ингэхдээ зөвхөн статистикийг үндэслэх биш, бодит байдлаас сурвалжлан гаргахыг чухалчилдаг. Энэхүү сурвалжлагаа бэлтгэх явцдаа бидэнтэй хамт нэг нарны дор, нийслэлийнхээ хаяанд зүдүүхэн аж төрж буй хэсэг хүний амьдралтай танилцан, нүдээрээ харж, сэтгэлдээ тунасан бүхнээ уншигч тантай хуваалцаж буй нь энэ билээ. “Ядуурал гэж хүний амьдралын чанарыг тодорхойлогч буюу энгийнээр өдөр тутамд

хэрэгтэй хүнс тэжээл, хувцас, гэр орон зэрэг ердийн хэрэгцээний дутагдал гачигдлыг хэлнэ” хэмээн тодорхойлдог. Миний уулзаж ярилцсан хүн бүрт наад зах нь хоол хүнсний дутагдал туйлдаа хүрчихэж гээд хэлэхэд нэг их хазайхааргүй байна. Зургаан хүүхэдтэй эх хүн хүүхдүүдээ хоногт тус бүр зургаахан зүсэм талхаар хооллож, өөрөө хоосон хонох үе энүүхэнд хэмээн ярьж сууна. Манай улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь суурьшиж буй нийслэлд ядуурал өмнөх жилүүдээс буураагүй байна. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тэдний амьдрал улам туйлдаа хүрч буйг дараах баримтуудаар бататган уламжилъя.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны “Алтан

овоо 39”-ын задгай гэх хаягтай газар оршин суух П.Батбаярын гэр бүл. Задгай гэхийн учир нь эднийх өөрийн гэсэн хашаагүй. Ам бүл зургаа бөгөөд дээрх зурган дээрх ганц охин нь дөрвөн настай. Биднийг очиход 15 настай том хүү нь гэрийнхээ баруун орон дээр унтаж байв. Үе үе зовиурлах түүнийг хараад, өр өвдөж ээжээс нь “Бие нь өвдөө юү” гэтэл С.Цацралтуяа “Үгүй ээ, хүү маань сургуулиасаа гарчихсан. Гэртээ байгаа юм. Өглөөдөө жаахан унтдаг юм” гэлээ. 40 насыг дөнгөж гарч яваа энэ хоёрын амьдрал бүрхэг байна. Эднийх хүнсний талоныг эс тооцвол төрөөс халамжийн мөнгө огт авдаггүй. Бичиг баримтын асуудалтай тул хүүхдийн мөнгөө ч авч чаддаггүй аж. Бидэнтэй хамт явсан хэсгийн

өргөс ургасаар, ужигарсаар



оршин суугаа П.Батбаярын гэр бүл. 2015.03.20

ахлагч Х.Оюунгэрэл “Хүүхдийн мөнгөө хурдан хөөцөлдөөч” хэмээн уцаарлангуй хэлээд амжив. Засгийн газраас хэрэгжүүлж буй Хүнсний хөтөлбөрийн хүрээнд нэн ядуу өрхийн насанд хүрэгчдэд 10 мянга, хүүхдэд таван мянган төгрөгийг сар бүр олгодог бөгөөд эдний гэр бүл сардаа нийт 40 мянган төгрөг авдаг. Түүгээрээ нэг сарын хоол хүнсээ базаана. Үндсэндээ өрхийн сарын орлого нь энэ юм. Нөхөр П.Батбаяр нь өдөрт Улаанчулуутын хогийн цэг рүү гарч, мөнгө болгох юухныг түүн, борлуулж өдөртөө 5-10 мянган төгрөг олдог. “Энэ хогийн цэг байгаа нөхцөлд арай ч нэг юм хоол ундаар тасрахгүй л байна даа” хэмээн эхнэр Цацралтуяа ярилаа. Сүүлийн үед төмөр худалдан авахаа байж, зэс, гууль зэрэг зарим түүхий эдийн



Фотог Б.Бямба-Очир

үнэ унасан нь Батбаярын гэр бүлд хүндхэн дарамт болж байгаа аж. Тухайлбал, нэг кг хуванцар савны үнэ өнгөрсөн онд 300 төгрөг байснаа 200 болж буурсан бол зэсийнх 1500 төгрөгөөр уруудаж 4000 төгрөг болжээ. Арай их үнээр борлуулдаг хог нь архины шил, хамгийн их олддог нь ундааны хуванцар сав аж. Нэг шилийг 100 төгрөгөөр борлуулдаг ч саяхнаас зарим шар айрагны шилийг ченжүүд худалдан авахаа байжээ. Гэрийн эзэгтэйн хэлж буйгаар ганцхан төрлийн шилийг худалдаж авахаа байхад өрхийн орлогод нь их нөлөөлдөг байна. Гэрийн эзэн уушгины өвчтэй учир тогтсон ажил хийж чаддаггүй бөгөөд бие нь өвдсөн үедээ хогийн цэг рүүгээ ч гарах тэнхэлгүй өнжих нь бий. Хогийн цэгийн утаа, үнс, тоос шороо түүний биеийг улам муутгадаг гэнэ. Эхнэрийнх нь хөл өвддөг учир хог түүж чадахгүй. Эмнэлэгт үзүүлэх гэхээр даатгал байхгүй, бас л мөнгөний асуудлаас болж эмчилгээ хийлгэж чаддаггүй гэнэ. Өдөрт хүүхдээ харж, нөхрийнхээ хогийн цэг дээрээс олж ирсэн сонины тасархайг олзуурхан уншиж өдрийг өнгөрөөдөг байна. Цацралтуяагийн нэг хөл нь өнгөрсөн жилээс хойш өвдөж, нарийссаар бараг гарынх нь шуу шиг болжээ. Дунд хоёр хүү нь “Эзний хайр ивээл” асрамжийн газарт амьдарч, хорооныхоо 62 дугаар сургуульд суралцдаг. Хоёр хүүгийнх нь нэг нь төрөлхийн харааны согогтой, нөгөө хүүгийнх нь нүд гэнэт солир болж асрамжийн газрынхаа зардлаар Сингапур явж хагалгаа хийлгэжээ. Эднийх түлээгээ хогийн цэг дээрээс базаадаг ч тэр хавьд байдаг хувийн худгаас нэг литр усыг таван төгрөгөөр авч байна. Арын хашааныхаа айлаас тог цахилгаан авах гэсэн боловч цахилгааны утас нь дутчихаад байгаа гэнэ.

ХОГИЙН ЦЭГГҮЙ БОЛ ХООЛ ҮГҮЙ

П.Батбаярын хажуухан талд айл байсан бололтой гэрийн буурин дээр навсар буйдан, хуучин муу хэдэн хувцас хөглөрнө. Цацралтуяагийн хэлж буйгаар эднийх шиг л ядруухан айл байж байгаад эхнэр нөхөр хоёр салсан бололтой. Ядруухан амьдралд айл гэрийн хоёр гэлтгүй, хогийн цэг дээр хогоо булаацалдан муудалцах явдал ч их. Батбаярын гэр

бүлийн адил Улаанчулуутын хогийн цэг дээрээс амьдралаа зогоож буй өчнөөн өрх бий. Тухайлбал, эднийхээс зүүн урагшаа хоёр гудамж өнгөрөөд байх Р.Улаанбандийнх ам бүл долуулаа. Дөрвөн хүүхдээс гадна эхнэрийнх нь дүү хамт амьдардаг. 2004 онд Баянхонгор аймгаас нийслэлд нүүж иржээ. Гэрийн эзэн, эхнэр хоёр 32 настай ч одоогоор хоёул эрхэлсэн ажилгүй. Барилгын ажил эхлэхээр ажилд орох санаатай гэнэ. Тэд өдөртөө мөн л Улаанчулуутын хогийн цэгтэй нөхөрлөдөг. Улаанбанди ганцаараа ажиллаад өдөрт 7000-8000 төгрөг олдог бол хоёулаа гарахаараа хоёр дахин ихийг олдог аж. Гэрийн эзэн нуруу, нугасны өвчтэй, төдийлэн хүнд хүчир ажил хийж чаддаггүй. Гэр бүлийн сарын үндсэн орлого дөрвөн хүүхдийнх нь 80 мянган төгрөг. Хогийн цэг дээрээс олсон хэдийгээ тэр өдөртөө хоол унданд зарцуулчихаар цааш нь хадгалах юм үлддэггүй байна. Эхнэр Д.Батсайхан “Мөнгө цаас болжээ. Өмнөх жил давс 500 төгрөг байсан бол өнөөдөр 700 төгрөг. Юмны үнэ тэнгэрт хадаж” хэмээн сууна. Тэрбээр одонгийн мөнгө гэж жилд 100 мянган төгрөг авдаг. Хамгийн бага хүүхэд нь гурван настай. Цэцэрлэгт өгөх гэхээр цэцэрлэг олддоггүй. “Өөрөө ажил хийе гэхээр нас, өнгө зүс заачихаар гологдож юм” гэлээ. Ажил хайхаар ихэвчлэн цайны газарт угаагч, цэвэрлэгчийн ажил л олддог аж. Гэрийн эзэгтэй өнгөрсөн зун барилга дээр ажиллаад хамгийн дээд тал нь 300 гаруй мянган төгрөг авч байсан тухайгаа дуу өндөр ярилаа. Гэхдээ цалингаа өгөхгүй удах гээд асуудал мундахгүй. Харин энэ хогийн цэг дээр бол хүний гар харахгүй, мөнгөө өгөх болов уу үгүй юу гэх айдас байхгүй гэж байна. Энэ өрх хоногт нэг шуудай нүүрс хэрэглэнэ. Өвөлдөө шуудай илүүтэй. Тог цахилгааны төлбөрт сардаа төслийн зуухны хөнгөлөлттэй нөхцөлд тавин хувь хямдруулж төлж байсан бол одоо 50 орчим мянгыг төлж байгаа аж. Энэ долоон хүн өдөрт хэмнэж, гамнаад 10-20 мянган төгрөг зарцуулдаг байна.

Дэлхийн банк туйлын ядуурлыг өдөрт нэг ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа, дунд зэргийн ядуурлыг хоёр ам.доллараас доош мөнгөөр амьдарч байгаа хэмээн тодорхойлдог байна. Энэ

нь төгрөгөөр 1994-4000 орчим /2015.03.25-ны Монголбанкны ханшаар/ болно. Гэтэл манайд хоногт зургаахан зүсэм талхаар голоо зогоож буй өрхүүд байна.

Тэдний нэг бол Б.Бауваржаны гэр бүл. Эднийх Чингэлтэй дүүргийн арванхоёрдугаар хорооны 15 дугаар хэсгийн “Булгийн 20”-ийн 1110А тоот хашаанд таван ханатай гэрт есүүлээ амьдардаг. Хамгийн бага нь хоёр ойтой, том нь 16 настай хүү гээд зургаан хүүхэдтэй бөгөөд эхнэр Б.Саруулцэцэгийнхээ ээжийн гэрт толгой хорогддог. Өдгөө нас сүүдэр 60 гарч яваа ээж нь тэдэнтэй хамт амьдардаг. Эднийх Төв аймгаас шилжиж ирээд 15 жил болж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд амьдрал нь улам л хэцүүхэн болж байгаа тухай Саруулцэцэг ярилаа. Энэ есөн хүн эмээгийнхээ тэтгэвэр, хүүхдийн мөнгөөр амьдарч байна. Саруулцэцэг жилд нэг удаа эхийн одонгийн 100 мянган төгрөг авдаг. Түүний хэлж буйгаар ээж нь Цагаан сарын үеэр тэтгэврийн зээл авчихсан. Нөхөр нь барилгын нэг жижиг компанид ажиллаж байсан боловч компани нь дампуурчихсан, одоогоор ажилгүй байгаа аж. Ганц оюутныхаа төлбөрийг амьтан хүнээс зээлээд төлчихсэн. Саяхан бас хоёр “Портер” нүүрс зээлж авчихаад байгаа гэнэ. “Хүүхдийн мөнгө буухаар л жаахан юм авч бэлддэг” хэмээн гэрийн эзэгтэй сулхан дуугарав. Эднийд 25 кг-ын нэг шуудай гурил сар хүрэхгүй хугацаанд дуусчихна. Махгүй үедээ гурилаараа талх, боорцог хийж өдөр, шөнөгүй хэрэглэдэг учраас тэр. Хүнсний ногоо барагтай л авдаггүй. Гэрийн эзэгтэйн зөвшөөрлөөр хөргөгчийг нь нээж хартал хэдэн том гялгар уут, хоёр гурван түүнтгэр өөхнөөс өөр юу ч алга байлаа. Саруулцэцэг “Одоо гурилгүй болчихоод үлдсэн ганц ширхэг талхаа гамнаж идээрэй гээд сууж байна. Хүүхдүүддээ өглөө, өдөр, оройдоо хоёр хоёр зүсэм талх өгчихөөд л бид хэд цайгаа уугаад унтаад өгдөг дөө” хэмээн ичингүйрэн хүүрнэлээ. Сарын сүүлээр ийм үе олонтаа тохиох ч эднийх боломжтой үедээ ихэвчлэн шөлтэй хоол хийж иддэг байна. Малын дайвар бүтээгдэхүүн (гэдэс дотор) худалдаж авахаар дотор нь идчихээр олигтой юм байдаггүй. Өөх голдуу. Идэж байгаа нь уушги, элэг. Зарим нь зүрх, бөөртэй. Хүүхдүүддээ зүрх, бөөрөөр

нь бантан хийж өгчихөөд, хоёр ойтой бага хүүхэд нь мөөмөө идээд унтдаг аж. Гэтэл өлмөн зэлмүүн, дээр нь хөл нь өвддөг ээжийнх нь хөхөнд сүү байгаа гэж итгэхэд бэрх санагдав. Тэрбээр “Манай хүүхдүүд хувь заяатайгаа эвлэрч байх шиг байна. Хаа очиж бие нь өвдлөө гэдэггүй. Юм мэдэхгүйгээрээ энэ бага маань л өлсөөд байна гэдэг юм” хэмээн ярих. Мөнгө хомс, амьдрал тарчиг үед өвчин зовлон холуур байгаа нь сайн хэрэг. Огт мөнгөгүй үедээ ойр хавийн дэлгүүрүүдээс зээл авдаг аж. Ихэвчлэн ганц, хоёр кг будаа, талх, сүү зэрэг бага багаар зээлсээр эцэстээ төлж барахааргүй өр болдог гэнэ. Заримдаа ч арга тасарч байх үед ашгүй оюутан хүүгийнх нь 70 мянган төгрөг буудаг гэнэ. Ойр хавьд нь хамаатан садан айллууд байдаг ч тэдний амьдрал

эднийхээс нэг их дээрдэхгүй гэнэ. Нэгнийх нь гэрийнхээ гадаа гурил буулгаж байвал нөгөө хэдэн айлын эхнэрүүд сав суулгаа бариад очдог байна. Тог цахилгааны мөнгө сардаа дүүгийнхтэйгээ нийлээд 40 гаруй мянган төгрөг төлдөг. Үүнийг мөн л эмээ нь өгнө. 41 настай Саруулцэцэг “Дунд сургуулийн хүүхдүүдээс автобусанд мөнгө авахаа болимоор юм” хэмээн ярилаа. Түүний хэлж буйгаар настай хүмүүст тэтгэвэр авна, оюутнууд урамшууллаа авчихна. Харин хүүхдүүд ээж ааваасаа л мөнгө нэхнэ. Мөн тэрбээр “Ээжүүд улсад хөдөлмөр хийж өгч байна гэдэг ч гэртээ хүүхдээ харж байгаа ээж урамшуулал авсан юм алга. Би ажил хийвэл хиймээр л байна. Хүүхдүүдээ яах юм. Ямаа, маланд урамшуулал олгоод байдаг ч эцсийн эцэст ямаа Монголыг хөгжүүлэх үү”


хэмээв. Хүүхдүүдийн сургуулиас анги засвар, тийм ч юмны мөнгө гээд татаас мундахгүй. Гэвч эднийх эдийн саван, угаалгын нунтаг ч авч дийлэхгүй үе олонтаа. Нөхөр Бауваржан хоёр ч газар ажил хийсэн боловч цалингаа авч чадалгүй “буяны ажил” хийчихээд сууж байна. Уулзсан айл бүрт “буяны ажил” хийсэн хүн таарах. Тэд үүнийг эдийн засгийн хүндрэлтэй холбон тайлбарлаж байна. Өмнө нь жижиг компаниудад барилгын ажил хийдэг байсан ч арай ч энэ жилийнх шиг мөнгөө авч чадахгүй байдаггүй байжээ.

ТЭТГЭВРИЙН МӨНГӨ НЬ ЭМНЭЭС ИЛҮҮ ГАРДАГҮЙ

СХД-ийн долдугаар хорооных ч одоо 26-р хорооны “Алтан



Н.Чагдарсүрэн гуай тэтгэвэрээ буухаар өвчин намдаах болон толгой, даралтны эмээ базаана



овоо-44"-ийн 18 тоот албан байгууллагын хашаа манаж суугаа Н.Чагдарсүрэнгийнх ам бүл дөрвүүлээ, өөрийн эзэмшлийн газаргүй, айл айлын хашаа дамжан амьдарч буй. Энэ хоёр хөгшин ганц охинтой. 25 настай Ундрах охин нь дөрвөн настай хүүтэй. Чагдарсүрэн гуай өдгөө 77 нас зооглож яваа бөгөөд Баянхонгор аймгаас нийслэлд шилжин ирээд есөн жил болж буй. Тэрбээр залуудаа барилга дээр ажиллаж, аж ахуй эрхэлж, сүүлд мал маллаж байгаад ганц охиноо сургууль соёлтой болгох гэж хотод иржээ. Гэтэл өнөөдөр охин нь сурсан сургууль ч үгүй, наймдугаар ангиа л төгссөн аж. Охин нь 2008 оноос аав ээжийгээ асарч байгаа. Чагдарсүрэн гуайн хөгшин нь даралт харваад долоон жил болж буй. Одоо биеийнх нь нэг тал мэдээгүй, хүний хэлж ярьж байгааг ойлгох нь байтугай гэрийнхнийгээ ч таньдаггүй. Өндийж ч чаддаггүй. Өдөрт нэлээд унтана. Сэрэхээрээ орилж хашгирна. Өвгөн өөрөө зүрх муу, даралт өндөртэй. Эл өрхийн сарын орлого зөвхөн

хоёр хөгшний тэтгэврийн 400 мянган төгрөг. Ч.Ундрах хүүгийнхээ 20 мянган төгрөг хүүхэддээ л зарцуулна. Эднийх өдөр тутмын хэрэглээнээс гадна эм тариа их хэрэглэдэг болохоор арав хоногт 200 мянган төгрөг өлхөн зарцуулдаг байна. Огт мөнгөгүй болох үедээ зээлнэ. Даралтны эм л гэхэд 10 ширхэгийг нь 10 мянган төгрөгөөр авна. Асаргаа, эм тариа, группын мөнгө огт авдаггүй. Охин нь саяхан эмч нарын зөвлөлгөөний хурлаар ээжийгээ оруулахад асаргааны мөнгийг шийдэж өгөх юм хэлсэн гэлээ. Цахилгааны төлбөр нь сард 10 мянган төгрөг. Харин хашааны эзэн манаачийн цалин гэж хоёр "Портер" машин нүүрс буулгаж өгчээ. Тэдэнд энэ их дэм болж. Биднийг очиход Ч.Ундрах худагас ус авч ирээд байв. Тэрбээр ийн ярьж байна.

"Энэ хоёр маань заримдаа зэрэгцэж, бас цуварч айлгана. Хамгийн ойрхон үйлчилгээ түргэн л байна даа. Түргэн тусламжийн эмч нар зөвлөгөө өгөөд л явдаг. Хүүхэд маань удахгүй сургуульд

орно. Чадвал ирэх есдүгээр сараас цэцэрлэгт явуулна. Энэ жил их хямралтай байгаа. Талх 800 төгрөгийн үнэтэй байсан бол одоо 1050 болчихоод байна. Ээж маань өндийж чаддаггүй болохоор байнга живх хэрэглэнэ. 17 мянган төгрөгөөр 10 ширхэг живх аваад 10 хоногт л хэрэглэдэг. Хоолгүй хонох үе зөндөө. Ер нь би найз нөхөдтэйгээ уулздаггүй. Хүүгийн аав хааяа залгаж ярьдаг ч уулздаггүй. Манайд бараг хүн орж ирэхгүй. Хааяадаа хамаатны ах эгч нар орж ирнэ. Тэд нар ч бид дөрвийг нэг их тоодоггүй юм" хэмээв.

Чагдарсүрэн гуай тэтгэврээ буухаар өвчин намдаах болон толгой, даралтны эмээ базаадаг. Мөнгөний гачигдалд орохоороо аль болох өөрийнхөө нэр дээр зээл авч, энүүхэндээ хөгшинөө бодон, алс хэт арга ядахад зээл авна хэмээн эмгэнийхээ нэр дээр тэтгэврийн зээл авдаггүй байна. Гэхдээ бие гайгүй шиг болохоор мөнгөө хэмнэж, хайрлаад эм авдаггүй гэлээ. Байгаа хэдээрээ амьдралаа болгох гэж аав

охин хоёр нэлээд тооцоотой ханддаг нь ярианаас нь илт. Чагдарсүрэн өөрөө санхүүгээ барьж охиндоо бага багаар хэдэн төгрөг өгч явуулж хоол ундны юм авдаг байна. Охин “Ийм байдалтай байгаа хоёр хүнийг орхиод яаж ч ажил хийхэв дээ. Би анх хотод орж ирээд олдсон ажлыг голлолгүй хийдэг байсан” хэмээлээ. Мөнгөний хэрэгцээгээ харахаар ажил хиймээр байдаг ч тэрбээр аав ээжийнхээ ачыг хариулах гэж хичээж буй нь энэ гэсэн юм. Ундрах хааяадаа энэ гуравтаа бууз хийж өгнө. Түүнээс биш эднийг байнга гурилтай шөл иддэг бөгөөд саяхнаас ээж нь огт юм идэхээ байжээ. “Уйллаа гээд амьдрал шийдэгдчихгүй юм хойно ингэж л энэ хоёрынхоо ачыг хариулна даа” хэмээн хоолой зангиран ярих тэрбээр 25 насандаа хоолой дээр тулах зовлон бүхнийг хойш залгин амьдарч байна. “Насаараа хөдөлмөр эрхэлчихээд насны эцэст ингэж ч амьдарч байх гэж” хэмээх хоног өнгөрөөн суугаа Чагдарсүрэн гуайн эцэг хүний шаналал гаансных нь утаа адил гэр дүүргэх шиг.

СҮҮЛЧИЙН БАРИМТ

Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлангаас харахад 2010-2012 онд ядуурлын хэмжээ буурч 38-27.4 хувьд хүрчээ. Тус хорооноос хамгийн сүүлд олон нийтэд мэдээлсэн дүн нь энэ бөгөөд удахгүй дөрөвдүгээр сард шинэ тайлан гаргах гэж байгаа гэсэн юм. НҮБ-ын Мянганы хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд ядуурлын хэмжээ буурч байгаа ч хөтөлбөрийн хүрээнд энэ онд ядуурлыг 2000 оныхоос хоёр дахин бууруулна гэх зорилт тавьсан. Хэдий ядуурлын талаар нааштай үзүүлэлттэй гарч байгаа ч тус хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт одоогоор хангалтгүй байгаа талаар НҮБ-ын Суурин зохицуулгачийн газрын мэргэжилтэн А.Цэцэгмаа ярилаа.

Манай улс энэ онд ядуурлын хэмжээг нэг оронтой тоонд оруулна гэх том зорилт тавиад буй. Гэтэл ядуурал буурах биш өсчээ. Ялангуяа

Улаанбаатар хотод ядуурлын түвшин өнгөрсөн оны аравдугаар сартай харьцуулахад одоогийн байдлаар бараг хоёр дахин өсч 40 хувьд хүрсэн байна. Тус дүнг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Алтанцэцэгийн “Хэрэглэгчийн итгэлийн индекс” судалгаанаас харж болно. Түүний хэлж буйгаар ийм төрлийн өмнөх судалгаануудтай харьцуулахад Улаанбаатар хотын ядуурлын

байна. Амьд яваа цагт болох л байх даа. Хэдэн хүүхдээ өлсгөхгүй, дааруулахгүй бол ч боллоо доо” хэмээн санаашрах. Энхбаярын гэр бүлийн сарын орлого таван хүүхдийнх нь 100 мянган төгрөг. Өмнө нь эхнэртэйгээ хамт дулааны улиралд барилга дээр ажиллаж сард таваас зургаан зуун мянган төгрөг олдог байж. Харин тэр одоо ганцаараа.

Хөдөлмөр эрхлэх гэхээр үр хүүхдээ орхиж болдоггүй, ажил хайхаар олдох нь ховор, ажил хийж байгаа нэгэн нь цалингаа бүтэн авах нь асуудалтай бас маргаантай ийм л олон салаа өргөс ядуусын амьдралд ургасаар, ужигарсаар. Зүгээр суухаар өлсөх, ядуурах бас туйлдахын цондон болох. Их хотын амьдрал ёстой л эрээнтэй бараантай, ядуу гэх өрхүүд зутруухан амьдарч байна. Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны Засаг дарга Ж.Оюунцэцэг

“ Манай улс энэ онд ядуурлын хэмжээг нэг оронтой тоонд оруулна гэх том зорилт тавиад буй. Гэтэл ядуурал буурах биш өсчээ. Ялангуяа Улаанбаатар хотод ядуурлын түвшин өнгөрсөн оны аравдугаар сартай харьцуулахад одоогийн байдлаар бараг хоёр дахин өсч 40 хувьд хүрсэн байна. ”

түвшин олон өрхийн орлого, улсын эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас хамааралтай байгаа нь ажиглагджээ. “Эдийн засгийн байдал ялимгүй муудахад ядуу өрхүүдийн амьдрал түрүүлж дорддог. Тэгэхээр энэ нь ядуурлын түвшинг нэмэгдүүлж байна” хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор Б.Алтанцэцэг хэллээ. Ялангуяа өрхийн орлого тун бага, өрх толгойлсон эмэгтэй, эдгээр өрхийн ядуурлын түвшин тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдлаас илүү их хамааралтай байдаг байна. Ядуу өрхүүд ч гэлтгүй хаа сайгүй бизнес эрхлэгчид бараа, бүтээгдэхүүндээ хямдрал зарлаад буй. Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хороонд нэг ой зургаахан сартай охиноос гадна дунд сургуулийн сурагч дөрвөн хүүхдийн аав С.Энхбаяр учраа олохгүй тэвдэж сууна. Том хүү нь 18 настай жудо бөхөөр хичээллэдэг. Түүний гэр бүлийн хүн хөхний хорт хавдраар бурхан болоод дөнгөж арав хонож буй. “Одоохоондоо ханийн маань буяны ажилд цугласан хэдэн төгрөгөөр болж л байна. Цаашид яаж амьдрах учраа нэг л олохгүй

“Халамжийг хавтгайруулж олгосноос болж иргэд бэлэнчлэх сэтгэлгээтэй, амьдралынхаа төлөө тэмцэх ухамсаргүй болж байна” хэмээн яриу. Ийм хүмүүс ч бий. Гэтэл халамжийн мөнгөгүй бол өлсөж үхэхээр амьдралтай хүн олон байна. Дахин хэлье. Улаанбаатарт ядуу амьдралтай иргэд туйлдаж, ийм өрхийн эгнээ өдрөөс өдөрт өргөжсөөр. Зүдрүүхэн эдийн засгийг зүлгүүрдэх хүч нь ажиллах хүчин, хөдөлмөр эрхлэлт гэдэг нь үнэн аж. Улсын маань ажиллах хүчин, иргэдийн амьдралын өнөөдрийн дүр төрх цаашид хэр удаан үргэлжлэх юм бол оо. Магад улсын эдийн засаг сэргэх тэр үед амьдрал арай дээрдэх учиртай. Маргаашийн нар манддагаараа л мандана. Өнөөдөр гэдэс хонхолзон суугаа хэсэг хүүхэд маргааш хоолтой хонохыг мөрөөдөн сууна. Ядуугийн зовлонгоос улбаалж хөгшин, залуугүй өвчилж байна. Саяхан нэг сургалт дээр Төвбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалын хэлж байсан үг санаанд тод тусав. “Монгол Улсын иргэд ажилгүй болвол нүх рүү унана” гэж. ■

MONGOLIAN
ECONOMY

| Тавантолгой Монголын эмгэнэл | Бидний алдааг битгий давтаарай |
| Оюутолгой бол манай улсын одоогийн улс төрийн үнэн төрх | "Эмэгтэйчүүд тэнгэрийн
талыг дааж яадаг" | Модоо барьсан зуун жил | Төр гэдэг бизнес |

СОРИЛТ ГАРЦ ХӨГЖИЛ

(2011-2014 ЭМХЭТГЭЛ)



ЭМХЭТГЭЛ 2014

“Mongolian Economy”
сэтгүүлийн
2011-2014 оны онцлох
ярилцлага, нийтлэлүүд

ХУДАЛДАХ ҮНЭ
40.000₮

www.mongolianeconomy.mn



УДИРДАГЧ



Сингапурын баялаг: ЛИ ГУАН ЯАО

Б.Энхцэцэг

Ли Гуан Яао хэмээх домогт эрхмийн хөшөө дурсгалыг олж харъя гэсэн хүмүүст сингапурчууд орчин тойрноо хар гэж бахархалтайгаар хэлдэг гэх. Засгийн газар нь замбараатай, эдийн засаг нь эрчтэй, гудамж талбай нь цэмцгэр, иргэдийнх нь амьдрал баталгаажсан энэхүү арал улс өөрөө тэр чигээрээ Ли Гуан Яаогийн дурсгалт хөшөө, амьдралынх нь түүхэн гэрч. Түүний эсрэг зогсдог хамгийн хурц шүүмжлэгчид нь ч Ли Гуан Яаог Сингапур улсын хөгжилд хэмжээлшгүй том хувь нэмэр оруулсан гэдгийг нь хүлээн зөвшөөрч, оршуулган дээр нь толгой гудайлган, нулимс дуслуулан зогсож байна, эдгээр өдрүүдэд. Сингапурын түүх түүний нэрээр эхэлдэг гэхэд хилсдэхгүй. Ли Гуан Яао байгаагүй

бол өнөөдөр Сингапур гэж улс байхгүй байлаа. Тиймээс түүнийг 100 кратын алмааз ч гэж нэрлэх нь бий.

Дэлхий дээр хэдхэн л удирдагч улсдаа асар их эрх мэдлийг эзэмшиж, нэг гар дор ард түмнээ зангидаж чадсан байдаг. Тэдний дунд Фидель Кастро, Ким Ир Сен зүй ёсоор багтдаг. Гэхдээ энэхүү хоёр удирдагч Лигийн Сингапурыг дагуулан өгссөн замын эхэнд нь ч улсаа дөхүүлж чадаагүй. Ли Гуан Яаог улсаа буурай орноос бусдын манлайд авчирч чадсан хүн гэдэг. Өдгөө 50 жилийн түүхт ойгоо үзэх гэж буй орчин үеийн хот улс болтлоо хөгжсөн Сингапур нь эдүгээ нэг хүнд ногдох ДНБ-ээрээ АНУ-ынхаас ч өндөр гэдгийг Дэлхийн банкны судалгаа харуулдаг.

Сингапур улсыг хэрхэн “бүтээсэн” тухай номондоо Ли Гуа Яоа “Бид

нэг багаар, хоёргүй сэтгэлээр улсдаа болон үзэл санаандаа үнэнч зүтгэсний хүчинд одоогийн амжилтад хүрсэн” гэж бичсэн байдаг. Тэрбээр 1959 оноос 1990 хүртэл Ли Гуан Яао тус улсын Ерөнхий сайдын албан тушаалыг хашиж, 2001 онд тэтгэвэртээ гарсан. Гэсэн ч түүнийг нас барах хүртэл нь Парламентын гишүүнд тооцож иржээ.

Сингапур элсэрхэг, намгархач хөрстэй 640 ам.дөрвөлжин нутаг бүхий арал дээр оршдог, ундны усаа хүртэл гаднаас худалдан авдаг, байгалийн баялаггүй жижиг хот улс. Өнө эртний түүх гээд байх юмгүй тус улс 1819 оны үед 120 загасчин гэр бүл оршдог бяцхан тосгон байсан бол өнөөдөр зургаан сая гаруй хүн амтай дэлхийн хамгийн баян улсуудын нэг. Хотын нэг өнцгөөс нөгөөд хүрэхэд хамгийн уртдаа 48 км болдог бөгөөд Нью Йоркийн



нэг дүүргийн талаас томгүй зайд оршдог гэж "The Economist" сэтгүүл зүйрлэсэн байдаг. Тус улсын эдийн засгийн дундаж өсөлт нь өнгөрсөн таван жилийн хугацаанд 5.2 хувьтай байсан бөгөөд нийт дотоодын нийт бүтээгдэхүүн нь 348.7 тэрбум ам.доллартай дүйж байна. Тусгаар тогтнолоо олсон 1965 онд тус улсын нэг хүнд ногдох ДНБ-ий үзүүлэлт ердөө мянган ам.доллар байсан бол өдгөө 64.5 мянган ам.доллар болоод байна. Энэ нь дэлхийд гуравдугаарт бичигдэх үзүүлэлт. Ли Гуан Яо байгалийн баялгийн дутагдлыг хүн амын оюуны чадавх, дэг журам, бүтээлч зүтгэлээр нөхөж чадна гэж тооцсон. Мөн хөршүүддээ таагүй ханддаг байдал, хоорондын зөрчилт гоморхлоо гэтлэн бусад хүн ардад

хамтын хүчин чармайлтын үлгэр дууриаллыг үзүүлэхийг уриалж, өөрийн биеэр үлгэрлэдэг нэгэн байв. Тиймээс ч Америк тэргүүтэй хүчирхэг гүрнүүдийн удирдагчид түүнтэй уулзаж улс төрийн шийдвэрүүддээ хэлэлцэж, санал зөвлөмжийг нь тусгадаг байсан билээ. "Лин Гуан Яо бол улс хэмээх хөлгийг юуны өмнө нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн, хөрш зэргэлдээ улсуудын хэрэгцээ сонирхолтой зөрчилдүүлэлгүй залахыг урьдал болгосон хүн юм" гэж АНУ-ын нэртэй улс төрч Хенри А.Киссинжер хэлжээ.

Нулмист тусгаар тогтнол ба одоогийн Сингапур

Дэлхийн ихэнх орны хувьд орчин үеийн түүх нь эхэлж байхад Сингапурын хувьд улсынх нь түүх

бүхэлдээ дөнгөж эхэлж байв. Тус улсад давуу тал гээд байх нөөц боломж бараг байгаагүй ч усан зам дагуу орших байршлыг нь ашигтай гэж олж харсан Их Британийн тэлэх бодлогыг хэрэгжүүлж явсан Стэмфор Рафлесийн ачаар Зүүн Өмнөд Азийн арилжааны нэгэн зангилаа цэг болон хөгжиж эхэлсэн. Сингапур нь Их Британийн эзэмшилд 150 жил оршин тогтножээ. Гэвч дэлхийн II дайны дараагаар Их Британийн хүч суларч, цэргийн хүчээ олон улсаас татаж эхэлсэн байдаг. Хэдий тусгаар тогтнох хүсэлтэй ч бие даан хөгжих дархлаа хараахан суугаагүй сингапурчуудын хувьд Их Британийн цэргийн хүч гарч явах нь ашиггүй хувилбар байсан. Учир нь, цэргийн бааз байрлуулсныхаа



баялгийг цөмлөх уршиг авчирна гэж үзэх болж. Энэхүү хүйтэн харилцаа өдөр ирэх тусам гүнзгийрч 1964 онд дэгдсэн үймээний үеэр олон арван хүн амиа алдсанаар эцэслэгдсэн юм. Улмаар 1965 онд Малайзын Парламентийн санал хураалтаар Сингапурыг улсынхаа хаяанаас холдуулж, харьяаллаасаа шахан гаргасан байдаг. Өөрөөр хэлбэл, Их Британиас салахгүй гэж удаан зууралдаж, дараагаар нь Малайзын хаяаг дэрлэх гэж оролдсон ч ийнхүү хоёр удаа үндэстнээрээ хаягджээ. Тухайн үед хөгжих өгөгдөл бараг л үгүй энэ оронд Ли Гуан Яо гэх баялаг л байж. Малайзын холбооны улсаас хөөгдсөн 1965 он бол Сингапурын тусгаар тогтнолоо зарласан жил. Үүнийг Сингапурын эцэг Ли Гуан Яо “Бид улсынхаа тусгаар тогтнолыг баяр хөөртэйгээр бус нулимстай зарласан юм шүү” хэмээн хэлсэн байдаг. Гэвч хүслээр бус хүчээр олгогдсон нулимст тусгаар тогтнолын ачаар Сингапур улс үлэмж амжилтыг олох замд шамдаж, одоогийн хэмжээнд хүрсэн билээ. Угаас тус улсад үзээд алдах эсвэл үндэстнээрээ мөхөх гэсэн хоёр л сонголт байсан.

Сингапур газрын зураг дээр жижиг улаан цэгээр тэмдэглэгддэг хамгийн жижиг газар нутагтай орнуудын нэг ч эдийн засгийн хувьд их гүрнүүдтэй эн зэрэгцэхүйц хүчтэй. Сингапур нь дэлхийн хамгийн том боомт хотуудын нэг. Тиймээс ч худалдаа тээвэрлэлтийн хувьд Азидаа төв цэг нь. Номхон далайг чиглэсэн Малайз болон Индонез улсын дундуурх Малакка хоолойн аман дээр орших далайн боомт нь Сингапурын хувьд стратегийн ач холбогдолтой хэсэг. Энэхүү боомтдоо хөрөнгө оруулалтыг “цацаж”, дэлхийн хамгийн том агаад завгүй боомтуудын нэг болж чадсан. Тус боомтоор өдгөө дэлхийн худалдааны 40 хувь дамжин өнгөрдөг. Боомтынхоо ашигтай байдлыг бизнес эрхлэгчдийн сонирхолтой огтлолцуулж чадсанаар тус улсын хөгжил тодорхойлогддог билээ.

Баягалийн баялаг гээд байх юмгүй тус орны хувьд энэ дутагдлаа нөхөхийн тулд хууль эрх зүйн хувьд хамгийн таатай боломжуудыг бий болгож, гаднын бизнес эрхлэгчдэд улсынхаа үүдийг цэлийтэл нээж өгсөн юм. Ингэснээр тус улсад

ирж үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид хөрөнгө мөнгийг, ур чадвартай нь хамт аваад ороод ирсэн нь Сингапурын хувьд нэг сумаар хоёр биш нэлээд хэдэн туулай оносон хэрэг болж. Өнөөгийн байдлаар тус улсын хүн амын 30 хувь нь түр оршин суух эрхтэй гаднынхан байдаг байна. Сингапурын татварын орчныг бизнес эрхлэгчид “Диваажин” гэж нэрлэдэг. Энэ нь цаад утгаараа бизнес эрхлэгчдийн ачаар тус улс цаашид ч баяжсаар байна гэсэн үг. Тухайлбал, Сингапурын эдийн засагт гаднын хөрөнгө оруулагчид мөнгөө мөрөн адил цутгадагийн нэг жишээ нь өнгөрсөн жилийн гадаадын шууд хөрөнгө оруулалт 63.8 тэрбум ам.доллараар тоологдож буй нь юм. Тус улс Дэлхийн банкны Бизнес эрхлэх орчны үзүүлэлтийг жил бүр тэргүүлдэг. Мөн эдийн засгийн эрх чөлөөний индексээр дэлхийд хоёрдугаарт орж байна. Сингапур одоо ч Засгийн газрын үйл ажиллагаагаа жижиг бүтэцтэй, эдийн засгаа нээлттэй, эрх зүйн зохицуулалтаа энгийн, ил тод, өгөөж өндөртэй байх гэсэн хэдхэн зарчмыг гол болгон баримталдаг хэвээр. Авлигад автагдашгүй нэгэн гэгддэг Ли Гуан Яо Засгийн газраа бохир мөнгөнд булингартуулахгүйн тулд сайд түшмэд, төрийн ажилтнууддаа асар өндөр цалинг олгодог. Өнөөдөр түүний хүү, одоогийн Сингапурын Ерөнхий сайд Ли Сянь Луны үед ч энэхүү улс төрийн авлигаас ангид цэвэр байдал хадгалагдсаар байна.

Ихэнх жижиг улсыг хүчирхэг хөршүүдээсээ бүрэн хамааралтай, тэдний дунд хавчигдаж байх тавилантай гэж харах нь элбэг байдаг. Тэгвэл Сингапурын улс төр, эдийн засгийн нөлөө хөршүүд байтугай Зүүн Өмнөд Азийн бүс нутгаар хязгаарлагдахаа больж болдогийн тод жишээ. Сингапур улс нь баруунжсан ардчиллын хэв маягаар ази үнэт зүйлсийг бий болгож чадсан орон. Энэ бүхнийг бүтээсэн Ли Гуан Яо өдгөө бидний дунд байхгүй ч түүний үзэл бодол, үйл хэрэг олон зуун жил оршино. Учир нь, тэрбээр Сингапур хэмээх хөгжлийн шавхагдашгүй баялгийг газар доороос ухаж бус газар дээр бүтээгээд буцлаа. Энэ бол хүн төрөлхтөнд оргүй хоосноос оргилд хүрч болох үнэлж баршгүй түүхэн сургамж. ■

төлөө Сингапурын авдаг төлбөр нь үндэсний нийт төсвийн орлогын 20 хувийг бүрдүүлж, 70 мянган ажлын байрыг хадгалж байсан байна. Тухайн үед Хятадаас нүүн ирсэн ажилчид болон худалдаачдыг Сингапур найрсгаар хүлээж авч байсан нь одоогийн хүн амын дийлэнх хувь хятад иргэд бүрдүүлж байгаагийн тайлбар.

Их Британи Сингапурт 1959 онд өөрийгөө удирдах бүрэн эрхийг өгсөн байдаг. Тийм ч учраас Ли Гуан Яо Ерөнхий сайдаар сонгогдон гарч ирсэн. Улмаар 1963 онд Малай холбооны улстай /одоогийн Малайз улс/ нэгджээ. Гэвч энэхүү нэгдэл нь ахархан настай байв. Малайзын удирдлагууд удалгүй сингапурчууд Малайзын өв соёлыг сэвтээж,

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Агаарын тээврийн өчигдөр ба өнөөдөр

Б.Энх

Та онгоцоор нисэхээс айдаг уу? Айж байна уу? Хаа нэгтэй осолдчих болов уу хэмээн бодож байсан удаа бий юу?

Тэгвэл салбарын судлаачдын үзэж байгаагаар бол бид иргэний нисэхийн хамгийн аюулгүй цаг үед амьдарч байгаа аж. Гэвч өнгөрсөн оны байдлаар агаарын тээврийн ослоор 700 гаруй хүн амь үрэгдсэн гэсэн тоо гарчээ. Тухайлбал, Малайзын “МН 370” онгоцор сураггүй алга болсон бол тус компанийн “МН 17” нислэг Украины нутаг дэвсгэр дээр осолдсон харамсалтай хэрэг гарсан. Эдгээрээс төд удалгүй Алжирын “Air Algerie 5017” цөлд унаж, зорчигчид, нислэгийн багаас нэг ч хүн амьд үлдээгүй билээ. Саяхан хүртэл Малайзад бүртгэлтэй “Air Asia” компанийн QZ8501 нислэг далайд осолдож 162 хүний амийг авч одсон.

Ердөө 138 өдрийн дотор энэ бүгд болж өнгөрсөн бөгөөд үүний улмаас 700 гаруй зорчигч, нислэгийн багийнхан золгүй ослоор алтан амиа алдсан. Энэ явдал агаарын тээврийн аюулгүй байдалд эргэлзэхэд хүргээд буй. Дэлхий нийт улирсан он нисэхийн салбарт хамгийн халтай жил байв уу хэмээн асууж байна.

Нислэгийн аюулгүй ажиллагааны сүлжээний статистик мэдээлэлд 2014 онд иргэний агаарын тээврийн 12 осол гарч, улмаар 761 хүн хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн гэсэн тоо дурьджээ.

Вашингтоны Нислэгийн аюулгүй ажиллагааны байгууллагын Олон улсын төслийн захирал Руди Кэвэдо хэлэхдээ “Ослын давтамжийн талаарх мэдээлэл цуглуулах бүрэн боломжтой ч нягтлахад маших хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулна” гэсэн юм.

Иргэний агаарын тээвэрт хамгийн халтай жилээр 1972 он хэмээн бүртгэсэн байдаг. Тус онд 2429 хүн нисэх онгоцны ослоор нас баржээ. Тухайлбал, ОХУ-ын Аэрофлотын 217-р нислэг төдийгүй Испанид унасан Конвэйр 990 онгоцны осол маш олон хүний амийг авч



одсон байдаг. Сүүлийн жилүүдийн мэдээллээс үзэхэд нисэхийн салбарт том хэмжээний ослын тоо харьцангуй багассан аж. Тус тооцоог гаргахын тулд нисэх урсгалыг хянах мэргэжилтнүүд дэлхийн бүхий л онгоцны буудлаас ирж, очих нийт онгоцны тоог гаргадаг байна. Үүний дараагаар нийт нислэгийн тоог тухайн жилд гарсан ослын үзүүлэлтэд хувааж тухайн жилийн индексийг тайлагнадаг. Тухайлбал, 2013 онд 1.0 сая нислэгийн дунджаар 0.24 хувь нь осолдох магадлалтай гэж гарч байжээ. Энгийнээр хэлбэл, тус онд онгоц осолдох магадлал нэг буюу түүнээс бага байсан гэсэн үг. Вашингтоны Нислэгийн аюулгүй ажиллагааны байгууллагын Олон улсын төслийн захирал Руди Кэвэдо “Энэ үзүүлэлт том хэмжээний осол гарах магадлал маш бага гэдгийг нотолж байна” гэсэн юм. Тэгвэл Швейцарийн “Aviation Advocacy” стратегийн зөвлөх фирмийн удирдах зөвлөлийн дарга Андро Чарлтон “Онгоцоор зорчигчдын хувьд нисэхээс илүү аюултай зүйл нь онгоцны буудал руу машинтайгаа явах” гэжээ.

Хамгийн их амь эрсдэж байсан жилүүдэд дэлхийд томоохонд тооцогддог ослууд багтаагүй байдаг нь хачирхалтай. Тухайлбал, 1977 онд Испанийн Тенериф арлын агаарын зурваст нисэж байсан хоёр онгоц мөргөлдөж 583 хүн амь үрэгджээ. Харин 1946 оноос хойших “хамгийн аюулгүй жилүүдэд” жилд 11-21 осол гарч 224-627 хүн амь насаараа хохирсон гэсэн баримт байна. Кэвэдо “Осол гарахгүй байна гэдэг боломжгүй зүйл гэж бодож байна. Гэхдээ аюулгүйн байдлаас харвал засаж, залруулах зүйлс үргэлж гардаг. Агаарын тээврийг илүү найдвартай

болгох боломж бас шаардлага бий” гэсэн байна.


Мэргэжилтнүүд нисэхийн салбарын таагүй үзүүлэлт буурсаар байгаа нь техникийн дэвшил, холбоо харилцаа сайжирсан, мөн smart буюу ухаалаг үйл ажиллагаа, удирдлагын систем нэвтэрсэнтэй холбон тайлбарлаж байна. Дэвшилт технологи олон сая хүний аюулгүй зорчих тасалбар болж байгааг Кэвэдо учирлав. Тэрбээр “Аюулгүй байдлаас авч үзвэл иргэний тээвэрт зориулан зохион бүтээсэн нисэх онгоц гэнэтийн аюул, тухайлбал пуужингаас зайлж бултах зориулалттай биш. Иймд энэ төрлийн халдлагаас үүдсэн ослоос улбаалж тус салбарын аюулгүй байдалд эргэлзэх, ямар нэг дүгнэлт гаргах нь учир дутагдалтай” хэмээн онцолжээ. Түүний хэлснээр олон улсын иргэний агаарын тээврийн салбарын үйл ажиллагаа тогтвортой явж буй.

Өнгөрсөн жилүүдэд иргэний агаарын тээврийн салбар дуулиант бас таагүй мэдээллээс хол тойроогүй. Гэхдээ энэ онд байдал өөрчлөгдөж салбарын хувьд чихэнд чимэгтэй мэдээ дуулгах бололтой. Тухайлбал, Airbus A350 XWB загварын шинэ онгоц 2015 оны арванхоёрдугаар сарын 22-нд анхны захиалагч болох “Fatar Airways” компанид харьяалагдах аж. Улмаар 2016 оны нэгдүгээр сард зорчигчдоо хүлээн авах юм байна. Тус онгоц аэродинамикийн хувьд далавчаа хамгийн үр дүнтэйгээр ашиглаж чаддаг болсон гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна.

Түүнчлэн шинэ загварын Боинг 787 онгоц захиалагчдынхаа гарт очсон төдийгүй дараачийн загвар болох 787-10 загвараа Боинг компани 2018 оноос гаргах төлөвлөгтэй байгаа аж. ■

ШИНЖЛЭХ УХААН

Дэлхийг хэрсэн Чингисийн үр сад



Б.Энхмөнх

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Лэйчэстэрийн их сургуулийн судалгаанд өнөөгийн Азид амьдарч буй олон сая иргэн эртний овог удмын 11 удирдагчаас гаралтай байх магадлалтай гэжээ.

Европын “Хүний генетик судлал” сэтгүүлд хэвлэгдсэн уг судалгаанд өөр улс үндэстний 5.3 мянган Ази эрчүүдийн зөвхөн эцгийн талаас хүүдээ дамждаг Y хромосомыг шинжилсэн байна. Судлаачдын үзэж буйгаар Y хромосомын төрөл маш цөөн байдаг бөгөөд судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь ижил төрлийн хромосомтой байсан нь өнөөгийн Азийн олон сая эрчүүд нэг өвөг дээдэстэй байх магадлал маш өндөр болохыг нотолж байгаа аж. Төслийн удирдагч Лэйчэстэрийн их сургуулийн профессор Марк Жоблинг “Бидний судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 37 хувь нь эрт дээр үед амьдарч байсан

нэр бүхий 11 удирдагчаас дамжсан Y хромосомтой болохыг тогтоосон. Энэ тоог бид Азийн нийт хүн амын дунджаар үржүүлж үзвэл хэдэн тэрбум хүн нэг гаралтай болж байгаа юм. Зарим удмын хромосом яагаад илүү давамгай байгаа талаар профессор Жоблинг “Сүүлийн 1700 жилд үүссэн хамгийн залуу удмынхан болох нүүдэлчдийн Y хромосом илүү тархсан. Учир нь тэд маш хол зайг туулах чадвартай байсан. Энэ удмынхан олон эмэгтэйчүүдэд өөрийн үр удмаа үлдээснээр Y хромосомын тархалт ч их байсан байна. Тэдний үр сад өнөөдрийг хүртэл удмаа үлдээсээр байна” гэжээ.

Судалгааны багийнхан аль овог удмын удирдагчид дээрх хүмүүсийн өвөг дээдэс байх магадлалтайг тодруулахын тулд тэдний шарилд шинжилгээ хийх шаардлагатай болжээ. Гэсэн ч судалгааны багийн таамаглаж буйгаар эх үндэс нь Чингис хаан байх магадлал тун өндөр хэмээн тайлбарлажээ. Жоблинг “Чингис

хааны үе хойчид өмнө нь хийсэн хромосомын шилжилгээ эдгээр Y хромосомын төрөлтэй ижил болохыг тогтоосон бөгөөд Y хромосомын тархсан байдал нь ч Чингис Хааны эзэнт гүрний тархалттай нэгэн ижил байгаа юм” гэсэн байна.

Мөн тэрбээр “Хэрвээ энэ баримтуудыг нийлүүлэн авч үзвэл Чингис хааныг өнөөдөр Азид амьдарч буй хүмүүсийн өвөг дээдэс мөн гэж болохоор байна” гэжээ. Түүний хэлснээр Y хромосом нь Азид илүү давамгай байдаг ч өнөөгийн Чингисийн үр сад Монголын гурван сая иргэнтэй ижил хромосомтой хүмүүс Европт ч байдаг талаар дурдсан. Жоблинг “Ирландын хүмүүс Y хромосомтой ижил төстэй хромосомтой байдаг. Тэдний өвөг дээдсийг Есөн Барьцаалагчдийн Ниалл гэдэг байсан. Тэгсэн хэдий ч мянган жилийн тэртээгээс гаралтай Y хромосомын дээрх төрөл Ирландад маш нийтлэг” гэжээ. ■



ЭДИЙН ЗАСАГ

Хүндрэлийг даван туулах хөтөлбөрийг тольдохуй

Э.Тунгалаг /Эдийн засагч/

Эрдэс баялгийн олон улсын зах зээл дээрх ханшийн уналт болон хөрөнгө оруулалтын их хэмжээний бууралтаас үндэстэй одоогийн эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг даван туулахын тулд эрх баригчид өнгөрсөн Цагаан сарын битүүний өдөр “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээ”-ний төлөвлөгөөг баталсан. Тус хөтөлбөр нь 2015-2016 оны хүрээнд төсвийн хүндрэл, гадаад хөрөнгө оруулалтын орчин, гадаадын худалдааны тэнцэл болон санхүүгийн секторыг сайжруулахад чиглэгдсэн. Ерөнхийдөө, энэхүү төлөвлөгөөнүүд нь эдийн засгаа аль болох хумихгүйгээр мега төслүүдийг эхлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг татан, мөн дотоод дахь үйлдвэрлэлээ дэмжих зорилготой харагдаж байна. Гэвч одоогийн байдлаар энэ ондоо багтан мөнгө авчрах хөтөлбөр нь төрийн банкны 300 сая ам долларын бонд байгаа бөгөөд нэг бус мега төслийг нэгэн зэрэг 2016 онд багтаан эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах: Монгол Улсад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээн гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилго бий. 2012 оны тавдугаар сард батлагдсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай (СААНХО) хуулиас шалтгаалан анх бууж эхэлсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оны долдугаар сард гарсан Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалтыг зогсоох шийдвэр гарснаар маш эрчимтэй унаж энэ оны эхний сарын байлдаар бүүр хасах дүнтэй гарсан. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд 2016 он гэхэд Оюу Толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын асуудлыг эцэслэж, V цахилгаан станцын ажлыг эхлүүлэн, төрийн банкны бондыг босгохоор шийдвэрлэжээ. Үүнээс цахилгаан станцуудын хөрөнгө оруулалтыг гацааж байсан үнэ тарифыг чөлөөлөх асуудал эрчимтэй яригдаж байгаа



бөгөөд төрийн банк бонд босгох зөвшөөрлөө авчихаад байна. Эдгээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээнүүд амжилттай болвол 2016 оны эцэс гэхэд доод тал нь 1,7 тэрбум долларын хөрөнгө оруулалт орж ирнэ хэмээн хөтөлбөрийг боловсруулсан мэргэжилтнүүд үзэж байна. Энэхүү дүн нь 2013 оны нийт хөрөнгө оруулалтын дүнтэй ойролцоо боловч 2011-2012 оных шиг их хэмжээний биш юм. Оюутолгой,

Тавантолгойн хоёр том төслийн асуудал шийдэгдсэнээр хөрөнгө оруулалагчдын итгэл нэмэгдэн бусад төслүүдийн хөрөнгө оруулалт дагаад нэмэгдэх боломж бүрдэнэ. Ялангуяа дэд бүтцийн томоохон төслүүдийн ажлууд эхлэх боломжтой болох юм. **Дэд бүтцийн төслүүдийг эхлүүлэх:** Дэд бүтцийн томоохон төслүүдийн хувьд богино хугацаандаа V цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станцын

барилгын ажлыг эхлүүлэх зорилт тавин 2016 он гэхэд төслийн бэлтгэл ажил нь хангагдан барилгын ажил нь эхэлсэн байхаар тусгасан байна. Түүнчлэн Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг 2015 оны хоёрдугаар хагасаас эхлүүлэх зорилготой байна. Харин дунд хугацаанд үр дүн нь гарах газрын зураг дээр тэмдэглэгдсэн авто зам, төмөр зам, цахилгаан станцын төслүүдийг 2016 он гэхэд концессийн гэрээ байгуулан төсөл болон барилгын ажлыг нь эхлүүлчихсэн байх юм байна. Эдгээр дэд бүтцийн төслийг хэрэгжүүлж дуусахаддоод тал нь 5 тэрбум долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Тиймээс хөрөнгө оруулагчдын итгэл буцаж сэргэсний дараагаар л тус төслүүд нь хэрэгжиж эхлэх боломжтой юм. Мөн цахилгааны үнийн тарифийн чөлөөлөлт нэлээд үүрэг гүйцэтгэнэ.

Импортыг давсан экспорт: Гадаад худалдааны тэнцлээ сайжруулахын тулд уул уурхайн экспортын хүчин чадал, үйлдвэрлэлийг нэмэхээс гадна уул уурхайн бус экспорт (ноос, ноолуур, оёдол) болон импортыг орлуулах (цемент, арьс ширээр хийсэн бэлэн бүтээгдэхүүн) үйлдвэрлэлд хөгжлийн банкнаас хөнгөлөлттэй зээл (~500 сая доллар) олгон зарим бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг нэмэх зэргээр дэмжлэг үзүүлэхээр тусгажээ. Үүнээс гадна энэ хүрээнд нэлээд хэдэн мега төслүүд 2015-2016 онд эхлэхээр төлөвлөгдсөн байна. Цагаан суваргын орд, Зэс хайлуулах үйлдвэр, Нүүрснээс шингэн болон хийн түлш гарган авах үйлдвэр болон Газрын тос боловсруулах үйлдвэр. Эдгээр нь маш их хөрөнгө оруулалт шаардагдах том төслүүд бөгөөд гадаад хөрөнгө оруулалтын орчин болон Хятад, Орос болон Япон улстай хийж буй гэрээ хэлцлүүдээс ихээхэн хамаарахаар байна. Мөн 2016 он гэхэд алтны үйлдвэрлэлийг 2014 оныхоос гурав дахин, төмрийн хүдрийн экспортыг хоёр дахин нэмэгдүүлнэ гэж байгаа нь дэлхийн зах зээл дээрх үнэ унаад байвал эсрэгээрээ алдагдал ч авчрах

магадлалтай юм.

Улсын төсвийн тогтвортой байдлыг дэмжих: 2015 оны батлагдсан төсвөөс гадуурх зардлыг багтаасан нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх таван хувийг 2016 онд багасгаж дөрвөн хувь болгон ДНБ-ий 58,3 хувь байгаа улсын өрийн хэмжээг 55% болгож бууруулна гэсэн зорилт тавин ажиллахаар болсон. Үүн дээр нэмээд төсвийн тогтвортой байдлыг хангахаар тогтворжуулалтын сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, дээрээс нь ирээдүй

“ **2016 онд суурь асуудлууд нь шийдэгдээд хөрөнгө оруулалтын орчин сайжирлаа гэхэд тэр олон том төслийг нэгэн зэрэг эхлэх шийдвэр гарах нь бас эргэлзээтэй юм. 2015 оны хувьд төрийн банкны бонд ганцаараа эдийн засгийг аврахад хангалтгүй учраас Дэлхийн банк болон ОУВС орж ирэх үү гэдэг л байна.** ”

хойчдоо зориулагдах баялагийн санг 2015 оны сүүлээс эхлэн 2016 ондоо багтаан шийдвэрлэхээр болсон байна. Өрийн таазын тухайд энэ нь боломжтой зүйл юм. Учир нь өрийн удирдлагын тухай хуулиар засгийн газрын баталгаа болон төрийн өмчит байгууллагуудын өрийг улсын өрөөс хасахаар болсон. Тиймээс энэ нь аль хэдийн улсын өрийн ДНБ-н 55%-аас буулгасан төдийгүй бүүр нэмэлт өр босгох боломжийг олгосон. Харин Хөгжлийн банкны зардыг багтаасан төсвийн алдагдлын хэмжээг 2015 онд 5%, 2016 онд 4%-д байлгах нь асуудалтай байж болох юм. Учир нь энэхүү хөтөлбөрийн хүрээнд ажилгүйдлийн түвшинг 6.9% (2014 оны байдлаар 7.7% байсан), ядуурлын түвшинг 26.0% (2012 оны тооцооллоор 27,4% байсан) болгох

зорилтот бүлэгт чиглэгдсэн нийгмийн халамжийн бодлого багтсанаас гадна хөгжлийн банкны зээлээр дамжуулан уул уурхайн бус экспорт болон импортыг орлох төслүүдийг дэмжихээр болсон байна. Харин 2015-2016 онд тогтворжуулалтын сан болон баялагийн сангийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн ч мөнгө цугларах эсэх нь эрдэс баялгийн олон улсын зах зээл дээрх үнээс илүү хамааралтай. Түүнчлэн энэхүү хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг дахь төрийн оролцоог багасан, төрийн өмчит байгууллагуудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах болсон заалтууд орсон нь урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлөх юм.

Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх: Богино хугацаанд үр дүн нь гарах хөтөлбөрүүдийн хувьд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалан, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулна. Мөн төрийн банкны 300 сая ам долларын бондыг энэ оны 2,3-р улирлаас гурван жилийн хугацаатай босгохоор зөвшөөрлөө авчихсан байна. Харин дунд хугацаанд үр дүнгээ өгөх хөтөлбөрүүдийн хувьд хөрөнгө оруулалтын сан, Засгийн газрын баталгаа болон Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төлөвлөгөөтэй.

Ерөнхийдөө, энэхүү эдийн засгийн хүндрэлээс гарах төлөвлөгөөнүүдийн суурь нь Оюу Толгой болон Таван Толгойн хэлэлцээр байгаа мэт харагдаж байна. Хөтөлбөрийн ихэнх төлөвлөгөөний хэрэгжилт нь энэ ондоо багтаж эхлэх нь эргэлзээтэй байгаа бөгөөд мөнгө босгох арга нь Төрийн банкны бондыг түрүүлж босгох. Мөн цахилгааны үнийг чөлөөлөх тал дээр хэлэлцээр явагдаж байна. Харин 2016 онд суурь асуудлууд нь шийдэгдээд хөрөнгө оруулалтын орчин сайжирлаа гэхэд тэр олон том төслийг нэгэн зэрэг эхлэх шийдвэр гарах нь бас эргэлзээтэй юм. 2015 оны хувьд төрийн банкны бонд ганцаараа эдийн засгийг аврахад хангалтгүй учраас Дэлхийн банк болон ОУВС орж ирэх үү гэдэг л байна. ■

ТАТВАР

Бодлогыг тандахад

Ц.Элбэг

“Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээ”-г Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хүрээнд Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн зөвлөл татварын бодлогоор эдийн засгийг дэмжих арга хэмжээний талаарх асуудлыг хэлэлцэж буй. Одоогоор чухам ямар шийдэл яригдаж байгаа нь тодорхойгүй байгаа ч эдийн засаг хүндрэлтэй үед төсөв татварын бодлогыг зөөллөх буюу халамжаа багасгаж, татвараа бууруулах нь бодитой дэм болдог гэж эдийн засагчид тайлбарладаг. Ингэснээр төсвийн зардал буурч, ажлын байруудаа хадгалж үлдэх боломж бий болно гэж үздэг байна.

Гадаадын зарим улс оронд татварын хувь хэмжээ ямар байдаг талаар сонирхвол өмнөд хөршид ААНОАТ 25 хувь байдаг бөгөөд өндөр технологийн салбарт 15 хувь болгож бууруулдаг байна. Харин НӨАТ 17 хувь. Хойд хөршид ААНОАТ 20 хувь боловч боловсролын салбарт татваргүй, эрүүл мэндийн салбарт зургаан хувь, ЖДҮ-д 13 хувийн татвар ногдуулдаг байна. НӨАТ-ын хувьд 18 хувь хүртэл байдаг бөгөөд дотоодын ЖДҮ эрхлэгчдээс татвар авдаггүй байна. Европын орнуудад авдаг татварууд нь ерөнхийдөө 20 хувиас дээш ААНОАТ ногдуулдаг байна.

Өмнөд хойд хөршийн болон олон орны жишгийг ажиглахад татвар жигд бус байгаа юм. Энэ нь татварын бодлогыг хавтгайруулах бус зөвхөн улс орны хөгжил, эдийн засагт чухал нөлөөтэй салбаруудад их хэмжээний татварын хөнгөлөлтийг үзүүлдэг жишиг ажиглагдаж байна. Дээр дурдсан улс орны тарифтай харьцуулахад Монгол бол татварын таатай орчинтой. Зарим онцгой тохиолдлыг тооцохгүйгээр Монгол Улсын үндсэн татварууд жигд 10 хувь байдаг нь бусадтай харьцуулахад бага. Гэхдээ Катар зэрэг тэг хувийн татвартай улс ч байдгийг дурдах хэрэгтэй байх.

Сангийн сайд Ж.Эрдэнэбат гуравдугаар сарын 19-нд



“Сайдын 30 минут” сэтгүүлчидтэй хийх уулзалтын үеэр татварыг нэмэхгүй, бас бууруулахгүй болохыг мэдэгдсэн. Түүний хэлснээс үзэхэд эдийн засгийг дэмжих өөр шийдэл хайж байгаа бололтой. Тэрбээр уулзалтын үеэр “эдийн засгийн хүндрэлээс гарах, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой, бизнес эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцсэн, хууль хоорондын хийдэл, зөрчилгүй болгох зорилготой татварын багц хуулийн төслийг боловсруулан ажиллаж байна.” гэв. Тэгэхээр эдийн засгийг дэмжих татварын бодлого нь тэдгээр хуулийн төсөлд шингэсэн байх нь.

Монгол Улсын Их хуралд өнгөрсөн оны тавдугаар сард татвартай холбоотой дөрвөн хуулийн төсөл өргөн баригджээ. Тэдгээр нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, “Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл”, “Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төсөл” юм. Хуулийн төслүүдэд өөрчлөлт оруулахдаа өнөөгийн татвартай холбоотой асуудлууд нь татварын хувь хэмжээнээс бус гол төлөв хуулийн нэр томъёоны зөрүүтэй

ойлголтоос үүдэлтэй гэж дүгнэсэн байна. Тиймээс хуулийг илүү энгийн ойлгомжтой болгож маргаануудыг цэглэе, тэгэхдээ төр болон хувийн хэвшил аль аль нь хохиролгүй байх шийдлийг эрэлхийлсэн гэж байна.

Улсын Их Хуралд өргөн барьсан дээрх хуулийн төслүүдээс гадна татварын асуудлаар эрүүгийн хэрэг үүсч буй одоогийн тогтолцоо, татвараа хугацаанд нь төлөөгүй, эсвэл нуун дарагдуулсан хэрэгт хариуцлага хүлээлгэж буй өнөөгийн зохицуулалтыг эргэн харж татвар төлөгчдийн дунд тэгш, шударга байдлыг үүсгэхээр зорьж байгаа аж.

Мөн хяналт, шалгалтын тогтолцоог хүндрэлгүй болгохыг зорьжээ. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар “Зайлшгүй шаардлагатайгаас бусад үед 10 хоногийн өмнө” мэдэгдэх ёстой. Хэрэв зайлшгүй шаардлагатай гэж үзэх юм бол урьдчилан мэдэгдэхгүй байж болно. Энэ нь эргээд аж ахуйн нэгжүүдэд дарамт болж хувирдаг байна. Тиймээс ямар ч тохиолдолд урьдчилан мэдэгддэг больё, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийдэг болж татвар төлөгчтэй хамтран ажиллая гэж зорьж байгаа аж. Үүнээс гадна хөгжлийн чиг хандлагаа дагаад заавал тамга, тэмдэгтэй баримт бичиг шаарддагаа больж цахим баримтыг ашигладаг болох зэрэг шийдлийг тусгасан байна.

Хуулийн эдгээр зохицуулалт УИХ-аар дэмжигдэж, батлавал Ерөнхий сайдын шүүмжилдэг “бие биетэйгээ

уралдан бизнес эрхлэгчдийн хаалгыг өшиглөсөөр, төлөвлөсөн төлөвлөөгүй шалгалт хийсээр, материал баялаг бүтээгчдийн тал нь “Х” тайлан гаргаж, тэр хэмжээгээрээ үүд хаалгаа барих нөхцөлийг бүрдүүлэхэд төрийнхөн жинтэй хувь нэмрээ оруулсаар” байгаа байдал зүгшрэх болов уу гэсэн хүлээлт бизнес эрхлэгчдийн дунд бий болж байна. Багц хуулийн ерөнхий агуулга ийм байна. Харин хуулийн төсөлд орж буй тодорхой өөрчлөлтөөс дурдвал НӨАТ-ын босго нэмэгдэж байна. Ингэхдээ НӨАТ төлөгч болох босго өндөрссөн бус сонголт бий болгож буй аж. Мөн хууль батлагдахыг хүлээлгүйгээр НӨАТ-ын урамшууллыг хүн бүр хүртдэг болох зарчим руу шилжих нь. Иргэн худалдан авалт бүрийнхээ баримтыг хадгалснаар түүнд суутгасан НӨАТ-ын хоёр хувийг буцаан авч болно. Энэ шинэ тогтолцооны туршилтыг

Татварын ерөнхий газар хийж байгаа бөгөөд энэ дөрөвдүгээр сард багтаад улс даяар ажил хэрэг болох юм байна. Ингэснээр үйлчлүүлэгч бараа, үйлчилгээ худалдан авалт бүрдээ НӨАТ төлсөн баримт нэхэх эрхтэй болж, үр дүнд нь “далд эдийн засаг” буюу хяналтаас гадуурх гүйлгээг илрүүлэх гарц нээгдэж байгаа аж.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд төлөвлөж буй өөрчлөлт нь тухайн компани жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой бол заавал тайлан баланс гаргахгүйгээр хуулиар тогтоосон мөнгөн дүнг тогтмол төлдөг сонголт хийх боломж юм. Хөрөнгийн албан татварын тухай хуулийн төслийн хувьд ямар нэгэн шинэ төрлийн татвар биш юм. Энэ нь өмнө байсан “малын хөлийн татвар”, одоо мөрдөгдөж байгаа тээврийн хэрэгсэл, буунд тус тусын татвар ногдуулдаг

байдлыг халж нэгдсэн зохицуулалтад оруулах аж. Мөн олон орон сууц эзэмшигчийн гурав болон түүнээс дээш хэсэгт татвар ногдуулдаг болох зэрэг бас бус зүйл тусгажээ. Тэгэхдээ үл хөдлөх хөрөнгийн татвар нь орон нутгийн төсөвт орох бөгөөд хувь хэмжээг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь иргэдтэйгээ зөвшилцөж тогтоох зохицуулалттай.

Харин Нийслэл хотын албан татварын тухай хуулийг “орон нутгийн албан татварт хамаарна” гэж Татварын ерөнхий хуульд заасан байдаг боловч урьд өмнө хэрэгжиж байгаагүй юм. Иймд энэ хуулийн төсөл бол яалт ч үгүй шинэ төрлийн татвар. Хуулийн зорилго нь нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэлтэд шинэ эх үүсвэр бий болгох бөгөөд орлогыг нийслэлийн амьдрах орчинг сайжруулахад зарцуулахаар төлөвлөсөн байна. ■

ШҮҮХ

Арбитртай найзалъя

А.Бүрэнжаргал

Арбитр гэдэг үгийг монголчууд амандаа хэлэхээс ашиглахгүй шахуу явна. Монголын арбитрын шүүхийн үйлчилгээний талаар иргэд төдийлэн сайн мэдэхгүй. Харин гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг эрчимжсэнтэй холбоотой сүүлийн жилүүдэд Монголын талын оролцоотой томоохон хэргүүд олон улсын арбитраг очлоо, ...яллаа, ...ялагдлаа гэсэн мэдээлэл байн байн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гардаг болсон учраас монголчууд арбитр гэдэг үгтэй ичнээ танил болоод багагүй хугацаа өнгөрч байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л саяхан Канадын хөрөнгө оруулалттай “Хан ресурс” компани Парисын олон улсын арбитрын шүүхэд Монголын Засгийн газрын талаар зарга үүсгэж, 100 сая ам. долларын нөхөн төлбөр гаргуулахаар болсон. УИХ-ын гишүүн Ц.Нямдорж энэ талаар хэлэхдээ “Сайн ярьж, тохиролцож чадвал Олон улсын арбитрын шүүхэд ялж болдог юм. Миний бие өнгөрсөн хугацаанд

гурван ч удаагийн ийм заргад ялж байсан” хэмээн телевизэд өгсөн ярилцлагадаа дурьдсан. Гэхдээ энэ удаа манайх олон улсын арбитрын шүүхтэй холбоотой нийтлэл бичих гэсэнгүй. Харин монголчууд арбитр гэдэг үгийг сайн мэддэг хэрнээ дотооддоо яагаад сайн ашиглахгүй, сайтар хөгжүүлэхгүй байна вэ гэдгийг хөндөхийг зорилго. Аль эсвэл манайд энэ төрлийн шүүхийн хөгжил сайн байгаа ч, иргэдэд мэдээлэл хомс байгаад байна уу. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг ажиглахад, ялангуяа бизнес эрхлэгчид арбитрын шүүхийг Монголд илүү мэргэжлийн түвшинд сайн хөгжөөсэй хэмээн хүсэж байна. Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хэргийн тоо нэмэгдсээр байгаа учраас тэр.

Арбитр гэх грек үг нь орчуулагдах боломжгүй бөгөөд хөндлөнгийн шүүх гэж утгачилсан байдаг. Арбитрч Л.Баасан багшийн хэлснээр “гэрээний шүүх” гэх нь ч бий. Учир нь талууд аливаа гэрээ байгуулахдаа маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр урьдчилан тохиролцсон байдагтай холбоотой.

Энэ ойлголт нь 300 орчим жилийн түүхтэй төдийгүй өнөөгийн байдлаар Швед улсад аливаа хэргийн 80 орчим хувь нь арбитрын шүүхэд ханддаг аж. Харин манай улсын хувьд энэ салбар тийм ч шинэ тутам зүйл биш. 1929 онд одоогийн Хууль зүйн яамыг “Шүүх, арбитрын яам” гэж нэрлэдэг байж. Харин 1940 онд Улсын арбитрын газар гэж байсан нь албан байгууллага хоорондын гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг байв. Тус байгууллага нь 1986 он хүртэл Улсын дээд шүүхийн дэргэд үйл ажиллагаагаа явуулж байгаад татан буугдсан гэдэг. 1960 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж 2003 оноос гаднын улсуудад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хэргийг шийдвэрлэж буй хөндлөнгийн шүүх нь МҮХАҮТ байгуулагдахад үйл ажиллагаагаа эхэлж байсан түүхтэй.

Сүүлийн үед Монголд ажилладаггүй арбитр олширсон гэх мэдээлэл байх ч яваад судлаад үзэхээр манайд одоогоор ганц Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын /МҮХАҮТ/-ын дэргэд Монголын олон улсын

ба үндэсний арбитр гэсэн нэртэй байгууллага энэ салбарт ганцаараа үйл ажиллагаа явуулж байгаа аж. Тус арбитраар шийдвэрлэж байгаа хэрэг маргаануудын 50-60 орчим хувь нь олон улсын буюу гаднын компани, байгууллага, иргэдийн оролцоотой маргаан эзэлдэг байна. Ямар хэргүүд дээр ажилласныг нь сонирхвол арбитрын ажиллагаа хаалттай, мэдээлэл нууц байдагтай холбоотой энэ талаарх мэдээллийг өгөх боломжгүй гэв. Харин нэгэнт нийтэд ил болсон хэвлэл мэдээллийн хэрэгслээр талууд өөрсдөө мэдээлэл хүргэсэн “Монгол шуудан банк” БНСУ-ын “Номаранг корпораци”-тай холбогдох хэргийг шийдвэрлэж байсныг дуулгасан.

ЧХАУТ-ын Манай танхимын дэргэдэх арбитр нь 1960 оноос хойш ойролцоогоор 1000 гаруй хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна. 50 гаруй жилийн хугацаанд иймхэн хэрэг шийдвэрлүүлсэн гэхээр инээдтэй ч юм шиг. Харин сүүлийн жилүүдэд МОУУАрбитраар шийдвэрлэх хэрэг маргааны тоо өсөн нэмэгдэж байгаа бөгөөд жилд дунджаар 50-60 орчим хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа аж. Салбарынхны хэлж байгаагаар манай улсын зах зээлд энэ тоо харьцангуй ихэд тооцогдоно гэв. Үүгээр ч зогсохгүй энэ салбарт ажилладаг гаднынхны дүгнэж буйгаар хүн ам, бизнесийн салбар, гаднын компанитай хамтын ажиллагаа явуулж байгаа цар хүрээтэй харьцуулахад их тоо байна гэх бөгөөд салбарын хөгжилд ам сайтай байдаг аж. Ер нь олон улсад арбитраар шийдүүлэх хэргийн тоог шүүхийнхтэй харьцуулшгүй бага байдаг байна. Тухайлбал, өндөр хөгжилтэй Япон улсад гэхэд жилд арбитраар 15 гаруй хэрэг шийдвэрлэгддэг аж.

Арбитрын шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх онцлог нь хуралдааны талаарх мэдээлэл хэзээ ч олон нийтэд тардаггүй. Учир нь бизнес бол хэрэглэгчдийнхээ итгэлийг алдах ёсгүй гэсэн ойлголтод тулгуурладаг. Энэ тохиролцоонд үндэслэн арбитрын үйл ажиллагаа нь хэлэлцээр байгуулах, талуудын маргааныг эцэслэн шийдвэрлэхэд тохиролцоонд үндэслэн эцсийн шийдвэрийг гаргадгаараа ач холбогдолтой. Учир нь хоёр тал цаашид хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх, хэрэглэгчдийн



итгэлийг алдахгүй байх боломжтой. Арбитрын шүүхийг хөгжүүлэх нь гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн хөгжилд түлхэц болно гэж үздэг. Тухайн улсын бизнесийн эрх зүйн орчныг тодорхойлход маргаан шийдвэрлэх шүүх засаглалын хөгжлийг анхаардаг байна. Шүүхийн ачаалал их, хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагаа олон шаттай зэргээс шалтгаалж бизнес эрхлэгчид шүүхэд хандах сонирхол тэр бүр байдаггүй. Түүнчлэн хөрөнгө оруулагчид тухайн улсад хөрөнгө оруулахад тавьдаг шалгуур үзүүлэлтэд эдийн засгийн нөхцөл байдал, татварын тогтвортой орчин, эрүүл шүүх засаглал болон арбитрын орчныг эхний гурван чухал асуудал гэж үздэг байна. Иймээс арбитрын хөгжлийг хөрөнгө оруулалтыг татах хөшүүргийн нэг гэж үзэх нь бий.

Арбитрын ажиллагааны онцлог бол талууд өөрсдөө тодорхой салбарт мэргэшсэн арбитрчдыг томилох боломжтой” юм гэлээ. Хамгийн том сорилт болох хуулийг амжилттай хэрэгжүүлж, арбитрын үйл ажиллагааг хөгжүүлснээр хөрөнгө оруулагчид, шүүх эрх зүйн хүрээнд олон улсад итгэл хүлээхүйц болох

юм. Энэ сорилтыг давахын тулд урт хугацаанд тууштай оршин тогтнох улс төрийн эрмэлзэл шаардлагатай. Манай улсын хувьд Ази Номхон далайн орны гишүүн, 1995 онд олон улсын арбитрыг хүлээн зөвшөөрөх тухай Нью-Йоркын конвенцид нэгдэн оржээ. Ингэснээр Монголын үндэсний арбитрын гаргасан шийдвэр дэлхийн 170 гаруй оронд хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл бүрдсэн байна. Глобалчлагдаж буй ертөнцөд арбитраар хил дамнасан маргааныг шийдвэрлүүлэх ач холбогдол нь нэмэгдсээр байна. Түүнчлэн өндөр хөгжилтэй орны жишгээс харахад арбитрын шүүх нь хөдөө аж ахуй, барилга, уул уурхай тэр ч байтугай ургамлын тосны асуудал шийдэх арбитр гэх мэт салаалсан байдаг аж. Учир нь салбарын асуудлаа туршлагатай мэргэшсэн хүнээр шийдүүлэх нь илүү тохиромжтой гэж үздэг учраас дэлхий даяар салбар бүрт арбитрын үйл ажиллагаа явуулдаг компаниуд бий. Арбитрыг хэрэглэгч болон үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйлчилгээ үзүүлж буй аль ч төрийн бус байгууллагууд байгуулж болно. Өнгөрсөн хугацаанд манай улсад Хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалах

нийгэмлэг, Уул уурхайн ассоциацийн дэргэд арбитрын үйл ажиллагааг нэвтрүүлсэн боловч төдийлөн үр дүнгээ өгөлгүй татан буугдсан байна. Монгол Улсад гадаад худалдааны арбитрын тухай хууль 1985 онд мэндэлсэн. Цаашлаад 2003 онд НҮБ-ын Олон улсын арилжааны арбитрын загвар хууль гарснаар шинэчилсэн бөгөөд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оржээ. Сүүлд 2010 оноос эхлэн яригдаж эхэлсэн хуулийн шинэчлэлийг өнгөрсөн онд хийх талаар багагүй судалгаа хийж хөрөнгө зарцуулсан боловч улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан батлах хуулийн жагсаалтаас хасагджээ. Монголын үндэсний арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Гүнждавга “Одоо мөрдөж буй арбитрын тухай хууль нь олон улсын арбитрын үйл ажиллагаанд тусгах ёстой хууль журам бүгд орсон “сайн” хууль. Гэхдээ 2006 оноос хойш нийгэмд багагүй шинэчлэл явагдсан.


Тухайлбал, арбитрын бүрэлдэхүүний хэмжээг хязгаарласан, нөгөө талаас шүүхийн оролцоо их байгаа аж. Энэ нь шүүх огт оролцохгүй гэсэн хэрэг биш бөгөөд нэгэнт хоёр тал асуудлаа арбитраар шийдвэрлүүлэхээр гэрээнд тусгасан бол шүүхийн оролцоог эрх зүйн хүрээнд хязгаарлах, хэмжээтэй байх хэрэгтэй гэх олон улсын жишгийг дагах заалтыг шинэ хуульд тусгах аж. Түүнчлэн нэмж оруулах өөр нэг заалт бол цахим харилцаа. Чехийн эдийн засаг, Хөдөө аж ахуйн танхимын дэргэдэх Арбитрын шүүх 2004 оны зургадугаар сард арбитрын

ажиллагааны шинэ дүрэм баталсан нь цахим буюу интернэтээр арбитрыг явуулах нэмэлт өөрчлөлт. Цахим хэлбэрээр арбитрын ажиллагаа явуулахаар заасан тохиолдолд талууд нэхэмжлэлийн өргөдөл, хариу тайлбараа электрон шуудангаар явуулах үйл явцыг хэлэх аж. Энэ нь бичиг хэргийн зардлыг хөнгөвчлөхөөс гадна шуурхай байх нөхцөлийг бүрдүүлэх давуу талтай юм. Энэ нь олон улсад нэвтрээд есөн жил болж байхад манай улсын хуульд заавал бичгээр гарын үсгээ зурсан байх шаардлагатай гэх заалт нь хэтэрхий хоцрогджээ.

Олон улсын харилцаа холбоо өргөсөж байгаа энэ үед аливаа гэрээнд арбитраар шийдвэрлүүлнэ гэж тусгаж байгаа бол өөрийн улсын арбитрт хандах нь олон талын ач холбогдолтой. Тодруулбал, хоёр талын хамтын ажиллагаанд үл ойлголцол үүссэн нөхцөлд гаднын арбитрт хандахаар заасан нөхцөлд хэрэгт холбогдох талын хүн бүр тухайн улсыг зорих, буудаллах зардал нь арбитрын төлбөрөөс хол давах асуудал байдаг. Тиймээс өөрийн улсын арбитрыг сонгосноор улсын эдийн засагт хөрөнгө оруулж, өөрийн зардлыг хэмнэх боломжтой.

Харин арбитрын үйл ажиллагаа явуулах эрх нь хэн бүхэнд нээлттэй байдаг нь хамгийн том асуудал гэдгийг мэргэжилтнүүд сануулж байна. Учир нь хэн дуртай нь арбитрын үйл ажиллагаа явуулж хэргийг хариуцлагагүй шийдсэнээр манай улсын нэр хүнд унах, гаднын компаниуд хөрөнгө оруулагчдын

итгэл сулрах эрсдэлтэй. Зах зээл жижигт тооцогдох манай улсын хувьд олон арбитр байх нь зуун ямаанд жаран ухна гэдэгтэй адил зүйл болно гэх нь ч бий. МОНУА нь 58 арбитртай бөгөөд 11 гаднын мэргэжилтэн. Хандагч хоёр тал арбитраар өөрсдөө сонгох боломжтой бөгөөд сонгох эрхийн хүрээнд тодорхой журамтай. Арбитрч Ч.Гүнждавга “Манай улсын шүүхэд жилд 30 гаруй мянган хэрэг шалгагдаж байгаагийн 12 мянга нь нийслэлд бүртгэлтэй. Өнөөдөр манайд хандаж байгаа 60 хэрэг энэ тооны хажууд бага мэт боловч аливаа хэргийг хүчээр арбитраар шийдвэрлүүлэх нь боломжгүй зүйл. Учир нь хоёр тал анх гэрээ байгуулахдаа арбитрт хандах заалтыг оруулах ёстой байдаг” гэсэн юм. Тус байгууллагаас үйл ажиллагааны цар хүрээг сайжруулж олонд таниулахын тулд Монгол Улсад арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хөгжүүлэх сурталчлах, судалгаа шинжилгээ хийх, маргаан шийдвэрлэх, МУХАУТ-ын гишүүн болон гишүүн бус байгууллагууд мэдээлэл сурталчилгаа, зөвлөгөө үйлчилгээ, сургалтыг тогтмол хүргэж буй аж. Мөн хуульч, өмгөөлөгч, эрх зүйч, оюутнуудад сургалт орж арбитрчид болон хуульчдыг мэргэшүүлэх чиглэлээр олон улсын арбитрын байгууллагуудтай хамтран ажиллаж сургалт явуулах, туршлага солилцох хүрээнд олон улсын 21 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажилладаг байна. ■








2015
MONNIS EQUIPMENT EVENT
APRIL 7 - 9, 2015 LIEBHERR CENTER



50% DISCOUNT **30% DISCOUNT** **20% DISCOUNT** **10% DISCOUNT**


Уул уурхай, зам, барилгын
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА
4 сарын 7 – 9 өдрүүдэд 10:00 – 17:00 хооронд **Лиебхэрт Сервис төвд**
Утас: 8811-0193, 9911-8273 | И-мэйл: Liebherr_sales@monnis.com

ОНЦГОЙ ХЯМДРАЛТАЙ ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

ХҮНИЙ НӨӨЦ

Байгууллагын нэрийн хуудас бол хүн

А.Бүрэнжаргал

Аливаа байгууллагын үнэт баялаг бол мэдээж хүн. Компаниудын хүний нөөц бүрдүүлэлт, хувь хүмүүсийн хувьд ажилд орох саналыг нэгтгэж байдаг “Biznet-work consulting” компанийн захирал Н.Жавхлантай ярилцлаа. Тэрбээр үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөж хоёр ч шинэ үйлчилгээг нэвтрүүлээд байгаа юм байна. Мөн энэ сарын 10-нд “Name card-day” буюу хүний нөөцийн чиглэлээр холбогдох салбарынхныг хамарсан өдөрлөг зохион байгуулах юм байна. Энэ талаар Н.Жавхлан захиралтай ярилцлаа.

-Нэрийн хуудасны өдөрт байгууллагуудын нэр нүүрийг сонгон шалгаруулах томоохон үүрэг хүлээж байдаг хүний нөөцийн салбарынхан нэгддэг. Тус өдөрлөгийн энэ жилийн онцлог нь юу вэ?

“Name card day” хүний нөөцийн салбар болон ажил горилж байгаа хүмүүсийг холбож өгдөг дээрх үйл ажиллагааг зургаандах жилдээ зохион байгуулж байна. Энэ үеэр нэг салбарт ажиллаж буй салбарынхан бусдаасаа мэдээлэл авч, өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын зорилго нь аль чигт явж байгаа талаар ярилцах, нэгнээсээ суралцах боломж юм. Өдөрлөг “Мэдлэгээ хуваалцъя” уриан дор сургалт, хөгжлийн арга хэмжээнүүдийг хамарч байгаа. Хүний нөөцийн менежерүүд, бизнес эрхлэгчдийг хооронд нь ажил хэргийн зорилгоор холбох. “Biznetwork” сайттай хамтран ажилдаг хүний нөөцийн мэргэжилтэн, менежер, захирлууд оролцох болно. Өнгөрсөн жилүүдэд 500-700 хүн оролцож байсан. Цахим ертөнцөөр л хоёр талаас хамтарч ажиллаад байдаг. Жилдээ нэг удаа АГУ, МАКС, MCS, Шунхлай, “Таван богд” зэрэг томоохон групп компаниудын хүний нөөц ямар арга барилаар ажиллаж үйл ажиллагаагаа амжилттай явуулж



байгаа талаар туршлага солилцох боломжтой. Энэ жил “Сүү” хувьцаат компани ивээн тэтгэгчээр оролцож байна. Ажил хэрэгч уулзалт учир сургалттай, салбарынхан нэгдэж асуудлаа ярилцсан, гарцаа хайсан үйл ажиллагаа болох болно.

-Энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн захирлын хувьд салбарын хөгжилд оруулах таны цаашдын зорилго юу вэ?

Аль ч салбарт ажиллаж байгаа хүний нөөцийн менежер зөв бодолтой эерэг хандлагатай байгаасай. Тухайн байгууллагад ажиллаж байгаа хүнээ байгууллагадаа үнэнч урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах орчинг бүрдүүлэх хэрэгтэй. Ингэснээр туршлагатай боловсон хүчин бий болох, хоёр тал харилцан ашигтай ажиллах нөхцөл бүрдэх юм. Манай компанийн зорилго ч мөн энэ чигт ажиллаж байна. Ажил горилж байгаа хүмүүсийн хувьд хэрхэн ажилд орох вэ. Нөгөө талаас хүний нөөцийн менежер та ямар хүнийг сонгон шалгаруулж авах ёстой юм бэ. Тэр хүнээ хэдий хугацаанд ажиллуулж, хөгжүүлж албан тушаалаа өсгөх вэ гэдгийг ч тооцоолсон байх хэрэгтэй. Ерөнхийдөө бид хоёр талруу л хандаад ажиллаад байдаг. Эцсийн зорилго нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл хөдөлмөрийн орчин сайжрах ёстой гэдэгт байгаа юм. Мөн төрийн зүгээс бас багагүй анхаарч ажилладаг. Хөдөлмөрийн яам хүртэл байгууллаа. Гэхдээ үйл ажиллагааны хувьд байгаа оноогүй л явна. Гаднын улсуудын жишиг бол хөдөлмөрийн яам нь хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсээ хамгаалж хамтарч ажилладаг. Манай улсын хувьд хөдөлмөрийн насны нэг сая орчим хүн байдгаас долоон хувь

нь ажилгүй иргэд буюу 70-80 мянган иргэний асуудлыг бүхэл бүтэн яам шийдэх гээд явах жишээтэй. Гэтэл хөдөлмөрлөж байгаа хэдэн мянган хүний эрх ашиг, тэдний хөгжилд хандсан зүйл үгүй.

-Байгууллагуудхүний нөөц тал дээр юунд илүү анхаарах хэрэгтэй вэ?

Бидний хувьд давуу тал нь мянга орчим байгууллагатай хамтарч ажиллаж байна. Тэгэхээр тухайн байгууллагуудын хүний нөөцийн менежерүүдээс шаардлагатай мэдээллийг нь авч ажил хайгчдад хүргэх нөхцөл бүрдэж байгаа юм. Ингэхээр бид нэг ёсондоо Монгол Улсын хүний нөөцийн салбарт багагүй нөлөөлж байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувь албан хаагчдын цар хүрээнээс хамаарч 40-өөс дээш хүнтэй байгууллага хүний нөөцтэй байна. Аливаа байгууллагын хамгийн үнэт зүйл нь хүн гэдэг утгаараа ажилтнаа тогтвортой ажиллуулж туршлага авч үлдэх, хүнд суурилсан баялгаа хамгийн их тордож байх нь чухал. Учир нь хүн гэдэг чинь машин биш. Засаад эргүүлээд уначихдаг зүйл биш. Сэтгэл зүрх итгэлийг дэмжин ажиллаж байж энэ нөөцийг байгууллагын амжилттай холбох ажлыг хүний нөөцийн менежер анхаарч ажиллах хэрэгтэй. Хүн гэдэг байнга сонголт сорилт хийж байдаг учир хүнд суурилсан туршлага алдах бол хамгийн их гарз байдаг.

-Манай улсын хүний нөөц бүрдүүлэлт ажилгүйдэл хоёрын зааг хэр байна вэ?

Монгол Улсад ажил байдлын түвшин гэж ярих үнэхээр утгагүй санагддаг. Бүр юу ч хийх боломжгүй хүн л ажилгүй байна гэж тооцохоос

биш нээлттэй ажлын байр өдөр бүр нэмэгдэж байдаг. Ажилгүй хүмүүс маань ажил хийхийг хүсэхгүй байх шиг. Үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л газар хүний нөөцийн асуудал хөндөж өдөрт манайд 150 орчим ажлын байрны захиалга орж ирдэг. Тэгэхээр ажил бол байна. Ажилгүйчүүд үүнийг ч анзаарахгүй идэвхгүй байна гэж харах юм. Эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа ч ажлын байрны тоо буурахгүй байна. Гэхдээ өнгөрсөн таван жилийн хугацаанд өсөлттэй байсан бол энэ жилээс өсөлт нь тогтворжиж эхэлсэн.

-Уул уурхайн компаниудын ихэнх нь зогсонги байна. Түүнчлэн цөөнгүй аж ахуйн нэгж хаалгаа барьсан. Үүнтэй холбоотой бууралт ажиглагдахгүй байна гэж үү?

Аль нэг салбарын өсөлт удааширахад тухайн салбарын хүний нөөцийн эрэлт буурдаг. Мэдээж энэ нь дан ганц нэг салбарт бус бүхий л салбарт мэдрэгдэж байгаа ч зарим эерэг зүйлс гарч байгааг дурдахгүй өнгөрч болохгүй. Уул уурхайн салбарын хурдтай өсөлтийн үед ажиллах хүчний огцом өссөн эрэлт нь бусад салбарын байгууллагаа чирэх хандлага ажиглагдаж байсан бол одоо арилсан. Учир нь энэ салбарын цалингийн дундаж харьцангуй өндөр байснаас болоод хүмүүсийн хувьд тийшээ хошуурах байдал байсан. Түүнээс болоод бусад салбарынхан ажиллах хүчээ хадгалж үлдэхийн тулд өөртөө ахадсан өндөр цалин олгох зэргээр чирэгдэж байсан бол өдий энэ байдал байхгүй болж байна. Энэ нь ажилтан хүнд хохиролтой гэж үзэж болох ч компаниудын чадавхи нэмэгдэж тогтвортой ажлын байр бий болох нөхцөл бүрдэж байгаа юм.

-Байгууллагууд ажилтан шалгаруулахдаа ямар чадварт тулгуурлаж хүнээ сонгохоор зарласан байдаг вэ?

Аливаа байгууллагад ажиллаж байгаа хүн сэтгэлтэй зөв хандлагатай, чадвартай байх нь зүйтэй. Гэхдээ миний ажигласнаар тухайн хүний зорилго. Ажилд орох гэж байгаа хүний зорилго тухайн байгууллагын зорилготой ижил төстэй байж нэгдсэнээр урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж байгууллага амжилтад хүрнэ.

-Шинээр нэвтрүүлж байгаа үйл ажиллагааныхаа талаар танилцуулна уу?

“Recruitment service” буюу хүний

нөөцийн ажилтангүй компаниудад зориулсан үйл ажиллагааг нэвтрүүлж байна. Тухайн байгууллагуудын хувьд сонгон шалгаруулалтад их цаг зарцуулдаг байдлыг нь хөнгөвчилж ирсэн CV бүрийг шүүж анхан шатны ярилцлагыг манайх авах юм. Энэ нь хувь хүний хувьд энэ хүн тухайн байгууллагад тохирох уу гэдэг дээр анхаарна. Үүний дараа тухайн байгууллага мэргэжлийн хувьд тохирохуу гэдэгт шалгуур тавих юм. Ингэснээр нөгөө л яриад байгаа зорилгоо биелүүлэх гэж байгаа хэрэг. Байгууллагад чанартай боловсон хүчин, ажилтанд ажлын байр бий болгох. Энэ бол шинэ тутам үйлчилгээ биш. Олон улсад хэрэгжиж буй туршлагыг оруулж ирсэн нь энэ. Өөр нэг шинэ үйлчилгээ бол “Talent service”. Энэ нь салбарын мэргэжилтнүүдээс чанартай хүнийг сонгон шалгаруулах үйл явц. Боловсон хүчнээ ямар ч үндэслэлгүйгээр сайн муу гэхээс илүү бид таны мэргэжлийн чиглэлээр олон улсад үнэлж болох ийм шалгалт авч үнэллээ гэдэг ойлголтыг нутагшуулахаар ажиллаж байна. “TOFEL” өгчихсөн байхад олон улсын их, дээд сургуульд хүлээн зөвшөөрөгддөг шиг аливаа салбарт ажиллахад манайд мэргэжлийн шалгалт өгсөн байхад аль ч компани хүлээн зөвшөөрөх. Тийм л ирээдүйг харан санхүүгийн салбарт эхний шалгуураа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

-Хүн өөрийн хүсэл сонирхлоор дуртай ажлаа сонгох, эсвэл нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж ажлын байрны сонголт хийх тохиолдол их болсон байна. Энэ ер нь хэр ирээдүйтэй сонголт вэ?

Миний хувьд бодитой зөвлөгөө өгөхөд хүсэл сонирхлынхоо дагуу ажиллаж байгаа хүмүүсийг азтайд тооцно. Харин танд тийм аз тохионо гэж хэлж чадахгүй учраас нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж суралцаад ажиллах боломж арай их. Гэхдээ ямар ч салбарт хэн чадвартай туршлагатай чадаж байгаа нь л тунаж үлддэг. Өөрийн хүсэл сонирхлыг ажлын хажуугаар хөгжүүлээд хэрэгжүүлээд явах боломжтой.

-Танай явуулж буй үйлчилгээнээс ажиглахадэдийн засаг сайнгүй байгаатай холбоотой бизнесийн байгууллагуудад ажиглагдаж байгаа өөрчлөлт юу байна вэ?

Томоохон групп компаниудын хувьд ажлын байрны зарлал тогтвортой байгаа. Харин жижиг, дунд үйлдвэрүүдэд сайнгүй үзүүлэлтүүд ажиглагдаж байна. Хамтран ажиллах гэрээ сунгаж байгаа байдлаас ажиглахад 20 орчим хувиар буурсан. Мэдээж байгууллагууд өмнөх шигээ үйл ажиллагааны хувьд ялимгүй хумьж ажиллаж байгаа ч тийм доошоо орсон үзүүлэлт бол байхгүй.

-CV бөглөж байгаа хүмүүсээс ажиглахад залуу боловсон хүчин хэр чанаржиж байна вэ?

Өнөөгийн хөдөлмөрийн зах зээлд 1993-1994 оныхон гарч ирж байна. Тэдний хувьд өнгөрсөн үетэй харьцуулахад гадаад хэлний мэдлэг харьцангуй сайн. Ихэнх нь 1-2 хэлтэй байна. Мөн ажлын ярилцлагад урихад ажиглагддаг зүйл нь өөртөө итгэлтэй, дэврүүн гаднын жишиг их байна. Манай байгууллагуудын хувьд энэ байдлыг юу ч хийж үзээгүй байж юун ч онгиороо юм бэ гэж хүлээж авах нь бий. Үүнд тэдний сурсан байдал манайхны суурь ойлголт болох “ярихаас өөр ид шидгүй” гэх үзэл зөрчилдөөд байдаг юм болов уу гэж боддог. Түүнээс чадвар мэдлэгийн хувьд бол гологдохгүй. Удирдлагын түвшний хүмүүст аль үе давамгайлж байгаагаас шалтгаалаад хүний нөөц шалгаруулах үйл явцад өөрчлөлт орж байна. Дэлхийн хэмжээний боловсрол эзэмшээд ирсэн хүн удирдлагаар томилогдлоо гэж бодоход өөртэйгөө дүйх хэмжээний чанартай ажилтан шаардана. Тэр чинээгээр л хүн бүр удирдагчийн шаардлагаар мэдлэг боловсролынхоо хувьд хөгжиж байх сайн талтай. Түүнээс тогтоол ус шиг байвал ширгэнэ шүү дээ.

-Ажилтнуудын албан тушаал ахих үе шат хэр хугацааны давтамжтай явагддаг вэ?

Манайд бүртгэлтэй байгаа 100 гаруй мянган гишүүдийн CV-нээс ажиглахад гурван жилийн турш тогтвортой ажилласны дараа 3-5 жилийн хооронд албан тушаалын өөрчлөлт хийж байгаа байдал ажиглагддаг. Ажилд орох CV-нд л үүнийг асуусан байдаг. Таван жилийн дараах өөрийгөө юу гэж харж байна вэ гэдэгт тулгуурлаж хүний нөөцийн менежер үүнд анхаарах хэрэгтэй. Энэ өөрчлөлтийг өөрийн байгууллага дотроо хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй. Туршлагатай, ажлаа сайн мэддэг хүнээ тогтвор суурьшилтай ажиллуулах нь шинэ хүн авсанаас илүү үр дүнтэй. ■



Хятадын талаар тэр дундаа эдийн засгийн талаар нэг цагт багтааж уншиж мэднэ гэж байж боломгүй зүйл. Гэвч энэхүү “Хятадыг 1 цагт” гэсэн ном бол манай Монголын эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлэгч хүчин зүйл болсон Хятадын эдийн засагт гарч буй гол өөрчлөлтүүдийг энгийн ойлгомжтойгоор тайлбарлаж, ерөнхий чиг хандлагуудыг нүдэнд харагдахаар буулгасан ном юм. Тус номыг Эдийн засагч Б.Дөлгөөн орчуулжээ.

Та өнөөдөр “Wall Street Journal”, “Financial Times”, “Economist” зэрэг сонин сэтгүүл, “Bloomberg”, BBC зэрэг телевизээр өдөр болгон Хятадын өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал болон өсөлт бууралт, цаашлаад олон улсын зах зээлийн түүхий эдийн үнэд хэрхэн нөлөөлж байгаа талаар олон сонин мэдээлэл гарч байхыг уншиж сонсдог. Тэгвэл энэ ном эдгээр мэдээ мэдээллийн цаана эдийн засгийн хөдөлгөгч хүчин зүйлс юу байгааг тун хялбараар тоо баримттай, Хятадын амжилттай яваа бизнес эрхлэгчдийн түүхтэйгээр танд хүргэж байна.

Номонд танд бизнесээ өргөжүүлэх, цаашид экспортод чиглэсэн бизнес эрхлэх санаа оноо төрөхөөр олон баримтыг

дурьдсан. Жишээлбэл Хятад өнөөдөр дэлхий дээрх жилд хэрэглэж буй агааржуулагчийн 80, зөөврийн компьютерийн 90, нарны эрчим хүчний хавтангийн 75 гар утасны 70, гуталны 63 хувийг тус тус үйлдвэрлэдэг байна. Хятадын ДНБ-ий 40 хувийг аж үйлдвэрлэл бүрдүүлдэг бөгөөд энэ салбарт нийт 130 сая хүн ажилладаг аж. Өнөөдөр Хятад дэлхийд хамгийн том үйлдвэрлэгч улс бөгөөд жилд 2.2 их наяд ам.долларын нэмүү өртөг бүтээж байна. Сүүлийн 30 жилийн туршид үйлдвэрлэх суурь хүчин чадал 18 дахин нэмэгджээ.

Өнөөдөр “Алибаба” хэмээх компанийн эзэмшигч Жак Ма гэгч нөхрийн өөрийн хөрөнгө манай улсын хоёр жилийн ДНБ-тэй тэнцэх хэмжээнд хүрлээ. Жак Ма олон зүйлийг хийж, компаниа амжилтад хүргэсэн хэдий ч цаад нөхцөл байдал буюу Хятадын эдийн засгийн тулгуур хүчин зүйл “Алибаба” компанийн амжилтын гол үндэс болсон учраас өнөөдөр Жак Ма ийм их хөрөнгийн эзэн болж суужээ. Цаашид энэ компани улам өсөх болно гэсэн хүлээлт байгаагийн цаана эдийн засагт ямар том хандлага явж байгааг та энэ номноос уншиж мэдэх болно.

НОМЫН ХЭСГЭЭС:

Хятадад буй үйлдвэрлэлийн МАНГАС-ын талаар цөөн баримт дурьдахад:

- Хятад дэлхийд хамгийн том үйлдвэрлэгч улс бөгөөд жилд 2.2 их наяд ам.долларын нэмүү өртөг бүтээдэг. Сүүлийн 30 жилийн туршид Хятадын үйлдвэрлэх суурь хүчин чадал 18 дахин нэмэгдсэн байна.
- Хятад өнөөдөр дэлхий дээрх жилд хэрэглэж буй агааржуулагч (air-conditioner)-ийн 80 хувийг, зөөврийн компьютерийн 90 хувийг, нарны эрчим хүчний хавтан (solar panel)-гийн 75 хувийг, гар утасны 70 хувийг, гуталны 63 хувийг тус тус үйлдвэрлэдэг.
- Хятадын ДНБ-ний 40 хувийг аж үйлдвэрлэл бүрдүүлдэг. Энэ салбарт нийт 130 сая хүн ажилладаг. Сүүлийн арваад жил эдийн засагт эзлэх үйлдвэрлэлийн ажлын байрны тоо тогтвортой байна.
- Хятадын үйлдвэрлэлийн салбарт тус улсын асар олон компани ширүүн өрсөлддөг. Жишээлбэл өнөөдөр Хятадын барилгын материалын салбарт нийт 30 мянга гаруй компани ажиллаж, керамик плитанаас эхлүүлээд модон шал хүртэл хийж байна. ■

УЛС орнуудын өрсөлдөөн

“Хөгжлийн хөтөч” клубээс эрхлэн гаргасан хамгийн сүүлийн бүтээл болох “Улс орнуудын өрсөлдөөн” номыг уншигч танд танилцуулж байна. Тус номыг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан орчуулан хэвлүүлжээ. Номын эх хувилбарыг АНУ-ын Харвардын Их сургуулийн профессор Ричард.Х.К.Виетор бичсэн юм.

Дэлхийн орнуудын өрсөлдөөнд ялах, ялагдах нь тухайн улсын эдийн засгийн стратеги, бүтэц болон Засгийн газрын үйл ажиллагаанаас шууд хамаарч буйг тус номын зохиолч олон улсын жишээн дээр харьцуулан өгүүлжээ. Номын нээлтийн үеэр УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “Сайн Засгийн газаргүйгээр хөгжлийн төлөөх өнөөгийн өрсөлдөөнд орох нь ахмадгүй онгоцтой далайд гарах, дасгалжуулагчгүйгээр Олимпийн тэмцээнд оролцохтой адил болжээ” хэмээн онцолсон юм. Өөрөөр хэлбэл, муу Засгийн газартай орон ахмадгүй онгоцтой адил бөгөөд үе үе аль нэг төхөөрөмжийг нь эвдчихдэг, бүтэлгүй механиктай далайд гарч буйтай ижил аж.

Дэлхийн II дайнаас өмнө улс орнууд гадаад ертөнцөөс харьцангуй хамаарал багатай, бие даасан байдалтай хөгжиж байсан. Харин энэ цагт даяаршлын нөлөөгөөр дэлхийн орнууд маш олон өрсөлдөгчтэй болж, тэдэнтэй уралдахаас өөр аргагүй болсныг номын зохиолч учирлажээ. Эрчимтэй хөгжиж буй Хятад, Энэтхэг, Малайз, Индонез зэрэг орны давшингүй байдалтай хөгжихийн төлөө зүтгэж байгаа болон хөгжингүй орнууд нүүр тулах болсон. Тус номын зохиолч Ричард.Х.К.Виеторын бичсэнээр одоо үед улс орнууд зах зээл, технологи, ур чадвар болон хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөхөөс гадна хөгжлийн стратегиа зөв гаргаж, зөв хэрэгжүүлж чадсан орон амжилт олж байна.



Улс үндэстэн бүр эдийн засгийн хөгжлийн стратегитай байдаг. Түүнийг төрийн дээд тушаалтнууд нямбай томъёолж ярилцан боловсруулсан ил тод зүйл байж болно гэжээ. Эсвэл энэ нь хэрэгжсэн хойно л

“ Хөгжлийн өрсөлдөөнд ялах түлхүүр нь сайн Засгийн газар ”

стратеги гэж ойлгогддог бодлого, зорилгын салангид цуглуулга маягтай, тодорхой бус байж ч болох аж. Мэдээж стратеги бол дангаараа хангалттай биш. Улс гүрнүүд стратегиа үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай зохион байгуулалтын бүтэцтэй байх ёстой. Стратеги бүтэц хоёр хоорондоо тохирохгүй байх, эсвэл бүр дор, урагшгүй бүтэцтэй байх нь өсөлтийг удаашруулаад зогсохгүй бүр байхгүй болгох талтай байна. Тэгвэл энэ нь ямар байх ёстой юм бол. Стратеги бүтэц нь тухайн улс орны онцлог нөхцөл, тухайн орон оршин байдаг үндэсний болон олон улсын нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Харин бизнесийн нөхцөл байдал нь мөн адилхан зах зээлтэй тохирч байх учиртай. Нөгөөтэйгүүр аливаа үндэстний зорилго нь “эдийн засгийн өсөлт”, “улс төрийн тогтвортой байдал” гэсэн ерөнхий шинжтэй байж болох хэмээжээ.

Түүнчлэн зорилгууд илүү нарийн тодорхойлогдсон байж болдог. 1981 онд Ерөнхийлөгч Рональд Рейган нийлүүлэлт-талд эргэлт хийх дөрвөн зорилт дэвшүүлсэн байна.

1. Инфляцийг бууруулах
2. Эдийн засгийн өсөлтийг дахин буй болгох
3. Төрийн хэмжээ, оролцоог багасгах
4. Үндэсний асуулгүй байдлыг бэхжүүлэх зэрэг.

Иймэрхүү зорилгыг биелүүлэхийн тулд Засгийн газар бүр тодорхой бодлогыг заавал гаргах ёстой аж. Хамгийн наад зах нь макро эдийн засгийн сонголтуудыг хийнэ. Энэ мэт сайн засаглалын суурь үзүүлэлт, сайн бодлогын уг чанарыг эл номонд баримтаар уялдуулан өгүүлжээ. Өдгөө санхүүгийн үрэлгэн байдал, нийгмийн хэт ачаалалд дарагдсан эдийн засаг, бизнесээ зохицуулах чадваргүй, саад тушаа болдог хуучирсан тогтолцоотой орнууд алдахын хэрээр дэлхий нийтийн “уралдаанд” сүүл мушгиж байна. Дэлхийн банкны судалгаагаар манай улс хөгжлийн үзүүлэлтээрээ хойгуур байр эзэлж буй. Дотоодын зөрчил, мөргөлдөөн, улс төрийн маргаан, тэмцэл хөгжлийн замд ноцтой саад болдог аж.

Уншигч та “Улс орнуудын өрсөлдөөн” номноос сайн засгийн нөлөөгөөр дэлхийн улс орнууд хөгжилд чөдөр болж буй асуудлуудаа хэрхэн шийдвэрлэсэн бодит жишээг оюундаа буулгах болно. ■

ШОГ ӨГҮҮЛЛЭГ

ЧӨТГӨРИЙН ТОЙРОГ /фельетон/



А.Амарсайхан
/шог зураач, зохиолч/

Дамын наймаачин гэхээр хамгийн муу хүн гэж адладаг байсан үе саяхан. Дамчингуудыг шалгаж, мөрдөж, торгож, яллаж, шийтгэж, хорьдог байлаа. Бодоод үзэхээр зөв ч юм шиг. Дэлгүүрээс дөчин таваар авсан гутлаа цааш нь ерээр дамлан зарж нэгнийгээ шулахыг яагаад ч зөвшөөрч боломгүй. Ийм ажил эрхэлж ашиг олсон хүнийг шударгаар амьдарлаа гэж хэлэх аргагүй.

Гэвч одоо бид эрсээр сэтгэлгээтэй, тэс өөр нийгэмд амьдарч байна. Тэндээс зуугаар авсан малгайгаа энд авчраад сая төгрөгөөр өгсөн ч болно. Тэрбумаар зарсан ч чиний дур. Энэ үйлдлийг “дамын наймаа” гэж нэрлэхээ болиод, “чөлөөт худалдаа”, “чөлөөт зах зээл”, “чөлөөт үнэ” хэмээн өргөмжлөх болсон.

Бурангуй цагийнхаар бол дамчин өнөөгийнхөөр бол чөлөөт худалдаачин хүн Монголд тоймгүй олон. Эмч багш, малчин барилгачин, сайд дарга бүгд чөлөөт үнийг дээдэлдэг чөлөөт худалдаачид болцгоожээ. Дамчид юмыг нэг

бөгтөрч зараад сэтгэл ханадаг байсан бол чөлөөт худалдаачид тав нугалахаас нааш цадна гэж үгүй.

Ерээд оны дундуур нэг кило мах гурав дөрвөн зуун төгрөгийн үнэтэй байлаа. Тэгтэл чөлөөт үнийг шүтдэг, чөлөөт ченжүүд чөлөөтэй хөдөлж, гурван зуугаар авсан махаа гурав нугалаад мянгаар зарсан. Адилхан нүдчихтэй учраас малчид ч бас тэднээс дуталгүй, махаа нугарсан үнээр наймаалахыг хүслээ. Ингээд л жил тутам махны үнэ нугарч цойлсоор өнөөдөр арван мянган төгрөгт тулж ирчихээд байна. Хорин жилийн өмнөхөөс хорь гуч дахин өсчихлөө гэсэн үг. Гэвч хэнд ч ямар ч буруу байхгүй. Ченжүүд дамын наймаа хийгээгүй. Зах зээлд чөлөөт үнийг тогтоосон нь энэ гэнэ!

Ерээд онд тавин мянган төгрөг дөнгөж хүрдэг байсан идэшний үхэр одоо сая төгрөг даваад хадчихлаа. Үхэр сүргээ алтны орцтой арвайгаар тэжээж, мөнгөжүүлсэн усаар умдаалж, түрээсийн гурван өрөө байранд хашдаг болоо юу? гэж бодогдохоор. Тэгтэл хэрэг дээрээ огт худлаа.

Монголын үхэр барууны алаг

тарлангууд шиг тохилог байранд тарайж, цахилгаан дулааны өндөр зардал гаргадаггүй. Үйлдвэрийн үнэтэй тэжээл иддэггүй. Аанай л ерээд онд хивж байсан цагаан өвсөө идээд, урсгал усаа уугаад, үнэ төлбөргүй бэлчээрмөлжөөд, өөрийн зөнгөөрөө өсч үрждэг хэвээр. Хамгийн хуудуутай дамчин хамгийн хуумгай аргаар, хамгийн хэтийдүүлсэн өртөг үнэ тооцоолж гаргалаа ч бэлчээрийн үхрийн үнэ ийм өндөр тоо руу дөхөж очимгүй. Гэтэл Монголын чөлөөт худалдаачин малчид үхрээ сая төгрөгөөр зарж, арав хорь нугарсан ашиг хийсээр л. Гэхдээ энэ бол дамын наймаа биш. Хууль ёсны чөлөөт зах зээл дэх жам ёсны чөлөөт худалдаа!

Махны ченжүүдээс эхтэй чөлөөт худалдааг манай яруу алдарт барилгачид бас ажилдаа нэвтрүүлсэн. Ерээд онд таван зуун мянган үнэтэй байсан нэг өрөө байр одоо тавин сая төгрөгөөс хол давсан. Хорин жилийн өмнө улаан шороон тоосгоор өрж, устай шавраар шавдаг байснаа болиод, одоо оюуномин тоосгоор өрлөг хийж, очир эрдэнийн нунтгаар шавардаж барилгаа босгодог болсон гэлтэй.

Учир юу гэвээс тэд барилгын газраа хотын дарга аснаас хорь нугарсан өндөр үнээр авсан. Ченжүүд тэдэнд арав нугарсан үнээр цемент нийлүүлж байгаа. Хайрга шороог нь бас нэг этгээд тав бөгтөрч буулгаж буй. Цавуу цаас, будаг шохой, хадаас хатгуур бүх зүйлсийг урдаас оруулж ирдэг наймаачин гурав нугарсан үнээр нийлүүлсэн нь мэдээж. Энэ бүхний эцсийн дүнд юу болох нь ойлгомжтой. Арав нугарсан өндөр өртөг үнээр барилга нь босно. Барилгачин ч бас хүн юм болохоор байруудаа тав нугалж зарах гэж зүтгэнэ. Ингээд л орон сууцны үнэ арав байтугай тавь нугарчихсан байна. Гэвч энэ үйлдэл бидний байгуулж буй чөлөөт зах зээлтэй, чөлөөтэй нийгэмд байх л ёстой зүйл. Дамын наймаа биш чөлөөт худалдаа

гэнэ ээ!

Улаан цайм дамын наймаа явагдаад байгааг харсаар үзсээр суугаа хэрнээ УИХ, Төр, Засаг үүнийг зохицуулахыг хэзээ ч хүсэхгүй. Учир юу гэвээс эрхэм гишүүн өөрөө барилгын компанитай. Ноён сайд намар мах авч дараад, хавар нугалж зардаг бизнестэй. Тэд өөрсдөө тариа, гурил, түлш, шатахуун, архи, дарс гээд хэрэгцээтэй бүхнийг дамлаж зардаг компанийн эзэд, ченжүүд.

Дамлаж зардаг үхэр шигээ ухаантайэрхэм гишүүн, молхи монгол эр өөрийн юмаа хэд нугалж зараад, ашиг хийчихлээ гэж бахдана. Гэтэл хэрэг дээрээ тэр нь ашиг биш. Буцаад л өөр шигээ мулгуу нөгөөгийн барааг нугарсан үнээр авахад өнөөх ашиг нь шингэнэ. Талх гурван зуугаар гардаг ч талхчин түүнийгээгурав нугалж зарна. Хариуд нь тогооч хуушуураа дөрөв нугалж өгөөд санаа амарна. Түгээгүүрийн эзэн жолоочид шатахуунаа тав нугалж шахаад мушийна. Жолооч түгээгүүрийн эзний ачааг зургаа нугарсан хөлсөөр зөөнө. Эмч багшийн шүдийг долоонугарсан үнээрломбодож өгнө. Багш эмчийн хүүхдэд найм нугарсан шангаар давтлага өгч хариугаа авна.

Эрүүл хүмүүстэй эрүүл зах зээлтэй улсад худалдаа болоод үйлдвэрлэлээс гучин хувийн ашиг харахад л хангалттай гэдэг байхад манайд тэс ондоо. Эрээнээс хог чирээд, хорь нугалж зардаг алтан наймаа зөвхөн Монголд л цэцэглэдэг. Японоос хоёр саядавчирсан хуучин машиныг заавал найман саяд зарна. Германаас задгай зоосоор авсан хүнсийг заавал мянга хүргэх гэж улайрна. Дөрвөн зуун төгрөг зарцуулж бээлий оёчихоод дөрвөн мянгаар зарна гэж дайрдаг далий үйлдвэрлэл зөвхөн Монголд л байдаг.

Монголчууд бид дамын наймаа хэмээгч чөтгөрийн тойрогт орчихсон эргэлдэж байна. Тэрхүү чөтгөр шулмын эргүүлэг жилээр биш сараар хурд нэмж, улам эртэй хуйлран шуурч, улс орны эдийн засгийг сүйрүүлсээр. Гэвч үүнийг дамын наймаа биш чөлөөт үнэ, чөлөөт худалдаа гэж шинэ үеийн түнш, монхор ах нар номлоно. Удахгүй бүх зүйл үлгэрийн юм шиг сайхан болно, чөлөөт зах зээлийн далд гар өөрөө өөрийгөө зохицуулна гэж биднийг молгидсоор л. Монхор ахын толгойд Монголыг онхолдуулах санаархал яах аргагүй байна гэх сэжиг төрнөм. ■

ЖИРГЭЭ



МОНГОЛ ЖИРГЭЭНИЙ ЕРТӨНЦӨД

ОксфордБизнесГрупп @OBGnews гуравдугаар сарын 7-н

#Монголын #жигжиглэнгийн худалдааны салбар 2015 оны туршид хүнд байдалд байх төлөвтэй <http://www.oxfordbusinessgroup.com/news/tight-times-mongolia%E2%80%99s-retail-sector>

Оксфорд бизнес группын мэдээлснээр удааширч буй эдийн засаг, өндөр инфляци болон зээлийн хатуу журмаас үүдэн 2015 онд Монголын жигжиглэнгийн худалдааны салбар хүнд байдалд байх нь. “Уул уурхайн салбарын уналтыг дагаж барилга, жигжиглэн/бөөний худалдааны салбарууд хүндхэн жилийн ард гарсан. Гэвч 2015 онд дээрх байдал үргэлжлэх төлөвтэй байна хэмээн тус бизнес группын мэдээлэлд тайлбарлажээ. Дэлхийн банкны мэдээлснээр 2014 оны эхний гурван улиралд жигжиглэн/бөөний худалдааны салбарын өсөлт 6.8 хувиар багассан. Монголбанкны 2014 онд гаргасан зээлийн шаардлага, хүүний өндөр түвшин жигжиглэнгийн худалдаачдад хүндээр туссан. Өнгөрсөн аравдугаар сард хувийн хэвшлийн зээл 22 хувьд хүрсэн нь өмнө жилийнхтэй харьцуулахад 53 хувиар багассан үзүүлэлт аж.

Andrew McLean @amcl2004 Mar 16

#Монголд хийх зүйл маш их байна @MaxCRoser: Дэлхийн байгаль орчны хамгийн хүнд асуудал: Байр орон сууцны агаарын бохирдол. <http://www.maxroser.com/we-are-making-progress-against-the-worlds-biggest-environmental-problem/>

Оксфордын их сургуулийн эдийн засагч Макс Роузер “Байр, орон сууцны агаарын бохирдол дэлхийн байгаль орчны хамгийн том асуудал. Ил галын улмаас жилд 4.3 сая хүн нас бардаг. Буурай хөгжилтэй орнууд хатуу түлшийг гэрийн нөхцөлд хэрэглэх нь элбэг байдаг. Үүнээс болж гэр дотор өтгөн утаа тархаж уушгины үрэвсэл, цус харвалт, зүрхний өвчин, уушгины архаг өвчин, уушгины хорт хавдар зэрэг үүсэх гол нөхцөл болдог. Үүний улмаас олон сая хүн амиа алддаг бол тэдний ихэнх нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг. Хатуу түлшний төрөлд мод, бууц, модны нүүрс, нүүрс зэрэг багтдаг” гэжээ.

The Diplomat @Diplomat_APAC Marc 17

АНУ #Монголын 8 дахь гол хөрөнгө оруулагч, үүнийг нэмэх хэрэгтэй: Элчин сайд Б.Алтангэрэл @MGLEmbassy_USA#DiplomaticAccess<http://thediplomat.com/2015/03/diplomatic-access-mongolia/>

Ази, Номхон далайн бүсийн асуудлаар мэдээлдэг “The Diplomat” сэтгүүл Монгол Улсаас АНУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Б.Алтангэрэлтэй Монгол Улсын хоёр хөрш болон АНУ-тай харилцах харилцаа, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад нэгдэх хүсэл, хоёр Солонгосын харилцаанд голлох үүрэг гүйцэтгэх талаар ярилцлага хийжээ.

Ник Кусин @ncousyn Mar 2

МИАТ-ын хувьчлалд бэлдэгчээр үү, эс бөгөөс Хаан Ресурс #Монголын онгоцыг барьцаанд авах болно <http://www.valuewalk.com/2014/11/elliott-letter-2014-argentina/>

Хэрвээ Монгол Улс “Хаан Ресурс”-т 100 сая ам.доллар төлж чадахгүй бол Канадын тус компани Монголын гадаадад орших эзэмшлийг барьцаанд авах боломжтой юм. Үүнд МИАТ-ын онгоцнууд хамаарах бөгөөд олон улсын нисэх буудалд онгоцыг байрлаж байх үед хураан авч өрийн оронд зарах эрхтэй юм. ■

